

**Хувьчлал, Орлогын хуваарилалт, Ядуурал:
Монгол улсын туршлагаас**

Фрэдрик Никсон
Бернард Волтерс

Манчестерийн Их сургууль

2004 оны 1 дүгээр сар

Агуулга

Хураангуй

1. Удиртгал

- Хувьчлал
- Тайлангийн бүтэц

2. Макро эдийн засаг, Ядуурал, Тэгш бус байдал

- Макро эдийн засгийн байдал; ДНБ, нэг хүнд ногдох орлого, инфляц
- Ядуурал, тэгш бус байдал

3. Монгол дахь хувьчлал

- Малын хувьчлал
- Орон сууцны хувьчлал

4. Онолын асуудал

- Хүн амын амьжиргаа, орлогын хуваарилалтад гарсан хувьчлалын нөлөө
- Орлогын хуваарилалтад гарсан шууд бус нөлөө
- Хувьчлагдсан байгууллагад гарсан үйл байдлын өөрчлөлт
- Засгийн газрын Санхүүжилт, Зорилтод гарсан хувьчлалын нөлөө
- Шалтгааны гол гол сувгууд

5. Олон улсын туршлага

6. Түүвэр судалгаа

- Малын хувьчлалын талаарх оролцооны аргаар хийсэн судалгаа
- Орон сууцны хувьчлалын талаарх оролцооны аргаар хийсэн судалгаа
- Орон сууцны хувьчлалын талаарх түүвэр судалгаа
- ЖДҮ-ийн хувьчлалын талаарх түүвэр судалгаа
 - Хувь эзэмших
 - Ажил эрхлэлтэд гарсан нөлөө
 - Цалин хөлсний хуваарилалт
 - Мөнгөн биш үр ашиг

7. Дүгнэлт

- **Зөвлөмж**

Ном зүй

Хавсралт 1: Хувьчлал, Эдийн засгийн шинэчлэлийн он дараалал

ХУСНЭГТ

- Хүснэгт 1 Бодит ДНБ ба Эдийн засгийн өсөлтийн хэмжээ, 1989 – 2002
- Хүснэгт 2 Нэг хүнд ноогдох бодит ДНБ, 1989 – 2002
- Хүснэгт 3 Ядуурлын гол үзүүлэлтүүд, 1995
- Хүснэгт 4 Ядуурлын гол үзүүлэлтүүд, 1998
- Хүснэгт 5 Орон сууцны үйлчилгээний сарын загдал
- Хүснэгт 6 Судалгаанд хамрагдсан үйлдвэр, аж ахуйн газруудын хувьчлагдсан жилүүд
- Хүснэгт 7 4 том хувьцаа эзэмшигчид
- Хүснэгт 8 Хувьцаа эзэмшил удирдлага, ажмлчид, бусад хүмүүсийн эзлэх Хувиар
- Хүснэгт 9 Хувьчлагдсан аж ахуйн нэгж, компанийн ажил эрхлэлтийн дундаж түвшин
- Хүснэгт 10 Аж ахуйн нэгж, компанийн дундаж ажил эрхлэлт хувьчлалын когортоор
- Хүснэгт 11 Нийт ажил эрхлэлт хувьчлалын когортоор
- Хүснэгт 12 Цалин хөлс удирдах албан тушаалын хүмүүсийн цалин хөлсөнд эзлэх хувиар

ЗУРАГ ДҮРС

Зураг 1



© 1999 MAGELLAN GeographixSM (805)685-3100 www.maps.com

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаа Монгол улсын зах зээлийн эдийн засагт шилжих үед бий болсон ядуурал тэгш бус байдалд өмч хувьчлал хир зэрэг нөлөөлсөн, цаашид хувьчлалыг аль болох сөрөг үр дагавар багатай явуулахад сургамж болох асуудлыг тодруулах зорилтуудыг тавьсан болно.

Үр дүнгийн шинжилгээний дараах чухал хэдэн нөхцөлийг урьдчилан авч үзлээ. Нэгдүгээрт, өмч хувьчлал нь засгийн газрын улс төрийн шийдэл байжээ. Ингэж хэлснээр бид өмч хувьчлалыг огт үгүйсгэх зорилго агуулаагүй харин өмч хувьчлалыг арай өөр арга хэлбэрээр, үйл ажиллагаагаар явуулсан бол ямар байх байсан гэдэгт дүгнэлт өгөх зорилго агуулсан юм. Хоёрдугаарт, өмч хувьчлалыг нарийн утгаар авч үзвэл шилжилтийн үеийн бусад өөрчлөлтүүдээс тухайлбал, бүтцийн өөрчлөлт салангид авч үзэж болохгүй юм.

Өмч хувьчлал нь ядуурал, тэгш бус байдалд ихээхэн нөлөөлж байсан макро эдийн засгийн хүнд үед явагдсан байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хүртэл хувийг бүрдүүлж байсан хуучин Зөвлөлт Холбоот улсын тусламж зогсож байсан үед шилжилтийн үе эхэлсэн. Дотоодын нийт бүтээгдэхүүн 20 гаруй хувиар шилжилтийн эхний гурван жилд унаж худалдаа эргэлт хатуу валютаар хийгдэх болсон нь Монгол улсад хүнд нөхцөл болсон юм. Улмаар хүн амын амьжиргааны түвшин ч муудаж эхэлсэн.

Шилжилтийн эхний жилүүдэд ядуурал, тэгш бус байдал улам нэмэгдэж хамгийн өндөр түвшинд хүрчээ. Ядуу хүмүүс 1980-д оны сүүлчээр бараг үгүй байсан хэдий ч 1995 он гэхэд хүн амын 36 орчим хувь нь ядуусын тоонд оржээ. Энэ хэмжээ 1998 он гэхэд нэг их өөрчлөгдөөгүй ч ядуурлын гүнзгийрэлт орлогын хуваарилалт улам дордсон байв. Хэдийгээр бусад шилжилтийн эдийн засагтай орнуудтай харьцуулахад арай гайгүй ч орлогын тэгш бус байдал улам нэмэгдэж Жини коэффициент 1995 онд 0.31 байсан бол 1998 он гэхэд 0.35 болжээ.

Нэг хүнд ногдох орлогын өсөлтийн түвшин бага хэвээр байгаа нь тэгш бус байдлыг нэмэгдүүлж цаашид ч ядуурал, тэгш бус байдлын ялгааг арилгахуйц хэмжээний эдийн засгийн өсөлт ажиглагдахгүй байна.

Өмч хувьчлалын эхэн үед эрхийн бичгийн үндсэн дээр хувьчлал явагджээ. Зарчмын хувьд тэгш хуваарилалт мэт боловч практик дээр энэ нь тэгш бус байдлыг бий болгоход нилээд нөлөө үзүүлжээ. Ялангуяа хувьчлалын энэ аргыг хэрэглэх үед мал хувьчлалд ихээхэн ач холбогдол бүхий улсын болон хоршооллын байгууллагыг анхаарлын гадна орхисон явдал тэгш бус байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлжээ. Үүний нэгэн адил орон сууцыг оршин суугчидад нь хувьчилсан явдал орон сууцгүй олон тооны хүн амыг хувьчлалаас юу ч хүртэх боломжгүйд хүргэсэн байна.

Өмч хувьчлалын “үйл явдлууд” болон ядуурал, тэгш бус байдалд гарч буй өөрчлөлтүүдийн онолын холбоо нь ихээхэн төвөгтэй асуудал юм. Гэвч онолын түвшинд тодорхойлж болох хэд хэдэн холбоо сүлбээ бий. Нэгдүгээрт, өмч хувьчлал бол орлогын урсгалд өөрчлөлт бий болгодог үндсэн хөрөнгийн дахин хуваарилалт юм. Хоёрдугаарт, өмч эзэмшигчийн хувьд гарч буй өөрчлөлт нь хуучин улсын эзэмшилд байсан өмчийн зорилго, хариуцлагыг өөрчилнө. Ингэснээр хөдөлмөр эрхлэлт, цалинд өөрчлөлт гарна. Гуравдугаарт, өмч хувьчлал нь улсын төсвийн бүтэц, улсаас үзүүлж байсан нийгмийн болон бусад үйлчилгээнүүдийн хариуцлага, чадавхид өөрчлөлт оруулна.

Хэдийгээр өмч хувьчлалын үр дагаварт анхаарал тавих явдал нилэнхүйдээ сул ч ядуурал, тэгш бус байдалд хэрхэн нөлөөлж болох талаар олон улсын олон туршлага бий. Ерөнхийдөө тэгш бус байдал гэхээсээ илүү үр ашгийн асуудлыг түлхүү авч үзэж байгаа ч аль ч тохиолдолд үр шимийн хүртээмж, орлогын хуваарилалт сайжирсан тохиолдол байдаггүй. Олон улсын туршлагаас үзэхэд өмч хувьчлал явуулсан арга, хэлбэр, зохион байгуулсан байгууллага тэдгээрийг даган гарч ирсэн зах зээлийн бусад өөрчлөлтүүд, орлого хуваарилалтад ихээхэн нөлөө үзүүлэх өмчийн шинэ эзэмшигчийн байдал хамгийн

чухал байдаг. Ялангуяа өмч хувьчлал өөрөө хувийн салбарыг бий болгодоггүй гэдэг нь ойлгомжтой.

Монголд явагдсан өмч хувьчлалын байдалд түүвэр болон оролцооны аргаар судалгааны дүнг үндэслэн дүгнэлт хийлээ. Энэ нь онолын хувьд ч олон улсын туршлагаар ч батлагдаж байгаа юм.

Мал хувьчлалын хувьд хэд хэдэн дүгнэлт хийж байна. Үүнд мал хувьчлал хэт түргэн хийгдсэн бөгөөд тийм ч ил тод болсонгүй. Яаран хийсэн хувьчлалын болзошгүй үр дагавар, олон гэр бүлд тулгарч байсан элдэв цочролыг даван туулахад дэм болж байсан хоршооллын болон улсын байгууллагууд үгүй болж байсан зэрэгт бага анхаарал тавьжээ.

Орон сууц хувьчлал ч эхний үед тэгш бус байдал бий болоход ихээхэн нөлөөлсөн байна. Орон сууцаа хувьчилж авсан эзэмшигчдийн хувьд ч тэдний орон сууцны эхний үнэ, өмчилж авсан хөрөнгөө хэрхэн ашиглах мэдлэг чадвар, шинээр хэрхэн бизнес эрхлэх, түрээсийн зах зээлд оролцох боломж чадавхи зэргээс нь шалтгаалан тэдний үр ашиг янз бүр байжээ.

Мал болон орон сууц хувьчлалын үед хувийн салбар бий болох бусад олон асуудлуудтай уялдан хөрөнгийг дахин хуваарилах явцад тэгш бус байдал ихээхэн бий болжээ. Гэхдээ зээл хүртээмжид хэрхэн нөлөөлсөн нь тодорхой мэдэгдэхгүй байна.

Жижиг, дунд үйлдвэрийн газруудад хийсэн судалгааны үр дүнгээс харахад хувь эзэмшигчид олширч үйлдвэрүүдийн орон тоо нилээд хумигдсан нь хүмүүсийн ажил эрхлэлтэд ихээхэн нөлөөлжээ. Мөн өмч эзэмшигчидийн олонхи нь “өөрсдөө” буюу хуучин тухайн үйлдвэртээ байсан хүмүүс байжээ.

Онолын хувьд авч үзэхэд жижиг дунд үйлдвэрүүдийн шинэ зорилт нь өмнө нь улсын өмчид байсан үйлдвэрүүдийн үзүүлж байсан нийгмийн үйлчилгээнүүдийг үзүүлэх болж байгаа бөгөөд эдгээр үйлчлгээний олонхийг хувьчлагдсан жижиг, дунд үйлдвэрүүд үргэлжлүүлэн үзүүлж байгаа байдал судалгаагаар гарсан. Түүвэр судалгааны үр дүнгээс үзэхэд цалин хөлсний түвшинд тэгш бус байдал ажиглагдсангүй. Гэхдээ эдгээр үр дүнд эргэлзэх нөхцөл бас бий. Үр дүн ямарч гарсан өрсөлдөөнт нөхцөлийг бий болгож чадахгүй юм.

Энэ тайлангийн зарим дүгнэлтүүдийг зөвлөмж болгон ашиглаж болох бөгөөд тайлангийн зөвлөмжүүдийг дор толилуулж байна.

1. Дараа дараагийн хувьчлалыг хийхдээ эн тэргүүнд ил тод байдалд ихээхэн ач холбогдол өгөх хэрэгтэй. Тухайлбал, өмч хувьчлалын талаарх мэдээллийг нийтэд хүртээмжтэй тархаан, түүний үр дүнгийн талаарх ойлголтыг бий болгох чухал юм.
2. Хувьчлагдах эд хөрөнгийн үнэлгээг үнэн зөв тогтоох асуудалд гол хүчин чармайлт гаргах ёстой. Эдийн засгийн аливаа үйл ажиллагаа явуулдаггүй эд хөрөнгөөс байгууллагууд ёс бус ашиг олох ёсгүй.
3. Хувьчлагдах эд хөрөнгийн зөв үнэ тогтоох хамгийн зохимжтой арга бол нээлттэй, өрсөлдөөнт тендэр явуулах явдал байна.
4. Өмч хувьчлалын эхний шатанд өмч хувьчлалын талаар шийдвэр гаргахад шаардлагатай жинхэнэ өрсөлдөөнт орчин бий болгох хууль эрх зүйн болон зохицуулах хүрээ зайлшгүй хэрэгтэй.
5. Хоршооллын бүтцийн үүрэг роль, харилцан хамаарлын асуудал болон хувьчлалын улмаас бий болсон зах зээлийн уналт зэрэгт илүү анхаарах хэрэгтэй.
6. Хувьчлалын дараах төр засгийн үүрэг хариуцлагад илүү нарийн хандах ёстой.

7. Үүнээс хойш аливаа хувьчлалыг явуулахдаа нийгмийн хамгааллын сүлжээ, нийгмийн хамгааллын бусад тогтолцооны хангамжтай холбоотой хувьчлалын үр дагаврыг харгалзан үзэх хэрэгтэй.

8. Өмч хувьчлалыг дагалдан гарах санхүүгийн нөлөө, үр дагаврыг илүү ил тодорхой болгож, зах зээлд суурилсан эдийн засгийн нөхцөлд энэ талаарх төр засгийн үүрэг хариуцлагыг эрчимжүүлэх ёстой.

1. Удиртгал

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих үеийн эдийн засгийн шинэчлэлийн багц арга хэмжээг дагалдан ядуурлын түвшин нэмэгдэж, орлогын хуваарилалтын тэгш бус байдал бий болжээ. Шинэчлэлийн үеийн нэг гол үйл явц нь хувьчлал байсан юм. Иймд энэхүү тайланд ядуурал, тэгш бус байдалд хувьчлал ямар хэмжээгээр, ямар арга замаар, шууд ба шууд бусаар гэх мэт хэрхэн нөлөөлсөн талаар тусгах зорилт тавьсан болно.

Энэхүү судалгааны бас нэгэн давхар зорилго бол өнгөрсөн туршлагыг судлах замаар цаашдын хувьчлалын асуудалд хэрэглэж болох аливаа зарчим буюу сургамж байгаа эсэхийг олж тогтоох явдал юм. Хамгийн чухал болох өмч хөрөнгийн нилээд хэсэг нь төрийн мэдэлд хэвээр байгаа бөгөөд эрүүл мэндийн халамж, үйлчилгээ, сургууль, эмнэлэг, дэд бүтцийн салбарт олон тооны маргаантай хувьчлал хийгдэж, газар өмчлөлийн асуудал шинээр тавигдаж байгаа тул “ хувьчлалыг зохистой, нийцсэн хэлбэрээр хэрхэн хийх талаарх мэдээлэл маш их чухал хэвээр байна” (Бридсалл, Неллис, 2002, Хуудас 3).

Хувьчлал нь ядуурал, орлогын хуваарилалтад гарч болох түр болон олон жилийн туршийн болзошгүй үр нөлөөнд дүн шинжилгээ сайтар хийлгүйгээр, тэрч бүү хэл энэ асуудлыг харгалзан үзэлгүйгээр хийгдсэн үндсэндээ улс төрийн шийдэл байжээ. Хувьчлалын зорилго нь зарим талаар 1990 оны хавар, зун болсон улс төрийн өөрчлөлтийг батжуулахад чиглэж байсан мэт. Шилжилтийн үйл явцын суурийг тавьж, бүрдүүлсэн түүх, улс төр, эдийн засгийн болон нийгмийн хүчин зүйлсийг бий болгосон зарим хувьчлал, хувийн секторын хурдацтай хөгжил нь маш чухал бөгөөд хүсүүштэй зүйл байлаа. Гэвч, хамгийн чухал нь хувьчлалын арга буюу үйл явц бөгөөд хувьчлалыг хийх олон тооны арга зам байдаг. Хувьчлалын түр зуурын буюу хэтийн нилэнхүй нөлөө нь сонгож хэрэглэсэн аргууд, хувьчлал явуулсан хурд буюу цаг хугацаанаас ихээхэн хамаардаг. Ингэхлээр Монголд явуулсан хувьчлалыг бусад орнуудынхтай жишин харьцуулж үзэхдээ тухайн оронд явуулсан хувьчлалын үйл явцын хурд, хувьчлалын арга зам, хувьчлал хийгдсэн нөхцөл байдалыг харгалзах нь чухал билээ.

Хувьчлал

“Хувьчлал” гэсэн ойлголт нь тэгш байдал, ядуурлын тархалтад чухамдаа өөр өөр замаар нөлөөлөх ялгаатай, ялгаагүй олон хувилбаруудыг хамарсан “ойлголтын хүрээ”-г төлөөлнө. Харин манай судалгаанд энэ ойлголт нь хувийн секторыг нэмэгдүүлж, зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэхэд хүргэсэн, урьд өмнө нийтээр эзэмшиж байсан өмч хувь хүн, хувийн байгууллагуудын гарт шилжих асар том шилжилтийг илэрхийлэхэд хэрэглэгдэж болно. Иймээс, хувьчлалын хамгийн гол бүрэлдэхүүн хэсэг бол улсын өмчийн үйлдвэрүүд (УӨҮ) хувийн өмч болон шилжих асуудал юм.

Хувьчлал нь эдийн засаг, нийгэм-улс төрийн олон тооны зорилгуудыг агуулдаг. Монгол, Орос, БНЧУ, Литва гэх мэт шилжилтийн эдийн засгийн орнуудад улсын өмчийг бөөний худалдаагаар худалдаалж маш түргэн хугацаанд цөөрүүлэх нь төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн чухал нөхцөл гэж үзэж байжээ. Эдгээр орнууд төр засаг, улсын ашигтай үйлдвэрүүдийн холбоог задлахын тулд хувьчлалыг хялбар, түгээмэл аргаар (Неллис 2000) аль болох хурдан хийж гүйцэтгэсэн. "... Эрхийн бичгийг ашиглах замаар хийгддэг нийтийг хамарсан, түргэн хувьчлалыг коммунизмын үеэс өвлөгдөж ирсэн олон тооны улсын үйлдвэрийн асуудлыг шийдэх хамгийн тохиромжтой арга гэж өргөнөөр үздэг" гэж Неллис (2000, хуудас 2) дүгнэжээ.

1990-д оны эхээр аль болох түргэн хуучныг устгаж, шинэ байгууллагуудыг бий болгох зорилгоор Монголчуудын олонхи нь эдийн засгийн шинэчлэлийн "цочроох эмчилгээ" гэдэг хандлагыг илүүтэйд үзэж байсан. Энэ утгаараа хувьчлал нь стратегийн чухал ач холбогдолтой байсан бөгөөд ашигтай хөрөнгүүдийг улсын мэдлээс хувийн сектор руу эргэлт буцалтгүйгээр шилжүүлэн плюрализмыг дэмжигч, либерал, капиталист, зах зээлийн эдийн засгийг бий болгох зорилгыг агуулж байжээ.

Одоогийн ном хэвлэлүүд нийтийг хамарсан хурдацтай хувьчлалаас хүлээгдэж байсан бүхэн практикт хэрэгжээгүй гэдгийг ерөнхийдөө хүлээн зөвшөөрч байна. Хэрэгцээг хувьчлах явдал нь ашигтай хөрөнгийн дахин хуваарилалтыг агуулдаг бөгөөд энэ нь эргээд цаашдын орлогын урсгалын хуваарилалтын өөрчлөлтөд нөлөөлдөг. Тэрчлэн хувьчлалын дараах үйлдвэрийн шинэчлэл болон шинээр хүчээ авсан хувийн секторт шинэ ажлын байр бий болсны улмаас хуучин байсан ажлын байр үгүй болж, орлогын урсгалд нөлөөлнө. Хувьчлалын санхүүгийн нөлөө болон хувьчлалын дараах мөнгөний бодлого нь хувьчлалын орлогын хуваарилалт, ядуурлын түвшинд үзүүлэх шууд, шууд бус үр нөлөөний аль алиныг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Харин Бирдсалл, Неллис нар (2002, хуудас 11) "...хувьчлалын хуваарилалтын үр нөлөөний талаар энгийн нэг таамаглал байж болохгүй. Тэгш шударга байх зарчимд үзүүлэх үр нөлөө дор хаяж 3 хүчин зүйлээс шалтгаалдаг. Үүнд: анхны нөхцөл байдал, худалдах үйл явц, болон хувьчлалын дараах улс төр, эдийн засгийн орчин" гэж үздэг байна. Хувьчлалын өмнөх нөхцөл байдал нь орлогын хуваарилалт, ядуурлын түвшин, улсын өмчийн үйлдвэрүүдийн үр дүнтэй/үр дүнгүй үйл ажиллагаа гэдэг талаасаа хийгдэж болох ахицыг тодорхойлно. Хувьчлалын дараах орчин, ялангуяа өрсөлдөөний далайц, зохицуулах арга зам зэрэг нь эдийн засгийн цаашдын замыг зааж өгөх буюу өөрчлөх болно. Хувьчлалын үйл явц нь өөрөө буюу хувьчлалд хэрэглэсэн арга нь үр дүнгийн тархалтад нөлөөлнө.

Хувьчлалын дараах үеийн эдийн засгийн хөгжлийн зам нь ийнхүү нэг чиглэлээр явдаггүй бөгөөд зөвхөн улсын мэдлийн ашигтай үйлдвэр хувьд шилжих шилжилтээр

тодорхойлогддоггүй. Монгол Улсын хувьд хувьчлал нь зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед шилжилтийн үйл явцын хамгийн томоохон асуудал болон хийгджээ. Тогтворжуулах, бүтцийн өөрчлөлт хийх бодлогууд, түүний дотор эдийн засгийг чөлөөлөх, хяналтаас гаргах зэрэг нь гадны хүчин зүйлсийн хамт (Хуучин ЗХУ-ын задрал, ЭЗХТЗ тарсан) 1990 оны шилжилтийн дараах үеийн мөн чанар, шинж байдлыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэжээ. Эдийн засгийн бодлогын өөрчлөлтийн үр нөлөөг үнэлэх нь хэдийгээр чухал боловч Монгол Улсын хувьчлалын асуудалд харьцуулах боломж муутай тун хэцүү юм.

Тайлангийн бүтэц

Тайлангийн нэгдүгээр хэсэгт хувьчлалын асуудлыг улс төрийн мөн чанарынх нь үүднээс болон хувьчлалын ядуурлын түвшин, орлогын хуваарилалтад үзүүлэх нөлөөг гадны хүчин зүйл, тухайн үед хийгдсэн бодлогын томоохон өөрчлөлтүүдээс тусгаарлах оролдлого хийхэд гарсан хүндрэлүүдийн талаар танилцуулна. Хоёрдугаар хэсэгт 1990 оноос хойшхи Монгол Улсын хөгжлийн макро эдийн засгийн байдал, түүний дотор нэг хүнд ногдох орлогын бууралт, түүний дараах эдийн засгийн сэргэлт, ядуурлын өсөлт, орлогын хуваарилалт дахь тэгш бус байдлын талаар тоймлон дурдана. Эдгээр асуудлыг баталгаажуулах зорилгоор хавсралтаар шилжилтийн үйл явцын он дарааллыг харуулна. Гуравдугаар хэсэгт Монгол орны хувьчлалын үйл явц, тухайлбал хувьчлалын далайц, хэрэглэсэн арга замын (эрхийн бичгийн арга) талаар илүү дэлгэрэнгүй авч үзнэ. Зарим нэг нийтлэг хүндрэлтэй асуудлуудыг тодорхойлж, малын хувьчлал, орон сууцны хувьчлал гэсэн хоёр төрлийн хувьчлалын талаар хэлэлцэнэ.

Тайлангийн дөрөвдүгээр хэсэгт хувьчлалын 'үйл явц' ядуурал ба орлогын хуваарилалтад зарчмын хувьд нөлөөлж болох янз бүрийн сувгуудын талаар Төв болон Зүүн Европын шилжилтийн эдийн засагтай орнууд, ОХУ, Хуучин ЗХУ-ын шинээр тусгаар тогтносон орнуудад гарсан өөрчлөлтүүдийн хөдөлгөгч хүчний талаарх бидний ойлголтыг сайжруулахад чиглэсэн 1990-ээд оны үеийн онолын номуудыг үндэслэн хэлэлцэнэ. Тавдугаар хэсэгт эдгээр шилжилтийн эдийн засгийн бусад оронд хийгдсэн хувьчлалын бодит туршлагын талаар авч үзэж, ямар сургамж байгаа талаар дурдана. Бусад орнуудын туршлагыг тоймлон үзэж байхад нилээд тооны чухал асуудлууд гарч байна. Харин энэ туршлага нь улс орон бүрийн хувьд өөр өөрөөр нөлөөлдөг болохыг тэмдэглэх нь чухал юм.

Тайлангийн зургаадугаар хэсэгт энэхүү судалгааны нэгэн хэсэг болж үндэсний зөвлөхүүдийн хийсэн 4 түүвэр судалгааны үр дүнг харуулна. Малчин гэр бүлүүд, хувьчлагдсан орон сууцны эзэмшигч нарыг хамарсан оролцооны аргаар хийгдсэн хоёр судалгаа, хувьчлагдсан жижиг дунд үйлдвэрийн түүвэр судалгаа, өмчлөл ба орон сууцны үнийн асуудлыг тодруулах оролдлого хийсэн орон сууцны түүвэр судалгаа тус тус хийгдсэн

болно. Ашигласан арга, түүвэрлэлтийн үйл явц болон судалгааны үр дүнгийн талаар энэ хэсэгт өгүүлнэ. Долоодугаар хэсэгт тайлангийн нэгдсэн дүгнэлт, бодлогын зөвлөмжийг харуулна.

2. Макро эдийн засгийн байдал, ядуурал, тэгш бус байдал

ДНБ-ээр бүрэн илэрхийлэгдэхгүй ч ядуурал, тэгш бус байдлын ерөнхий түвшин нь эдийн засгийн үйл ажиллагааны түвшний механизм болж байдаг. Тухайлбал, хөрөнгө эзэмшлийн хуваарилалт, ашгийн хэмжээ болон бүтээгдэхүүн, үйлчилгээ хэнд ямар хэмжээгээр хүртээмжтэй байгаа, төрийн үйлчилгээ, халамжийг хэрхэн хүртэх эрхтэй байгаа зэрэг бусад эдийн засаг, зохион байгуулалтын гэх мэт олон илэрхийлэх арга зам байдаг. Шилжилтийн өмнө Монгол Улс нэг хүнд ногдох ДНБ-нээрээ харьцангуй ядуу орны тоонд орж байсан боловч хөдөлмөр эрхлэлтийн бүрэн, тогтвортой түвшинг хадгалах бодлого, үндсэн хэрэглээнд өгөх татаасын тогтоцлоо үйлчилж байсан, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ хүрэх цэгтээ төлбөргүй хүрдэг байсан гэх мэт нийгмийн үйлчилгээний өргөн цар хүрээтэй тогтолцоотой байсан нь тэгш бус байдал хурцадмал биш барууны орнуулын жишигт, ядуурлын асуудал тулгамдсан асуудал байгаагүйг илтгэж байна. Шилжилт нь нийгмийн энэхүү нөхцөл байдлыг өөрчилсөн боловч ДНБ-ний нийт хэмжээ, хөдөлмөр эрхлэлт, макро эдийн засгийн бусад үзүүлэлтүүдэд асар их нөлөөлсөн билээ. Энэ хэсэгт эдгээр макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, шилжилтийн үед бий болсон ядуурал, тэгш бус байдлын хэмжээ, далайцын талаар товч харуулах болно.

Макро эдийн засгийн байдал; ДНБ, нэг хүнд ногдох орлого, инфляц

Зах зээлийн эдийн засгийн үед бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зах зээлийн урамшуулалттай хэлбэрт чиглүүлдэг тул зах зээлд шилжих шилжилт нь бүтээгдэхүүний хэмжээ огцом буурахад хүргэх хандлагатай байдаг. Цочроох эмчилгээний арга нь бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ ихээр буурахыг шилжилтийн зайлшгүй дагалдах үр нөлөө гэж үздэггүй харин бүтээгдэхүүн алдагдалтын гүнзгийрэл, хурдыг хувийн секторын үүсч бий болох хурд, баталгааг илэрхийлэх индекс гэж үздэг болохыг илэрхийлдэг байсан. Тэрчлэн Монгол Улс нь гадны маш том цохилтод өртсөн бөгөөд энэ нь ДНБ-ий уналт, шилжилтийн жирийн иргэдийн амьжиргаанд үзүүлсэн нөлөөг маш дутуу үнэлсэн болохыг харуулж байна.

Шилжилтийн үе эхэлснээс хойшхи Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг Хүснэгт 1-д харуулав. Шилжилтийн эхний жилүүдэд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн уналт маш их байсан бөгөөд 1990-1993 онд ДНБ 20 гаруй хувиар буурчээ.

Хүснэгт 1: Бодит ДНБ ба Эдийн засгийн өсөлтийн хэмжээ, 1989-2002

	1989	1990	1991	1992	1993	1994	1995
ДНБ	651.5	635.1	576.4	521.6	505.9	517.6	550.3
Өсөлт	4.2	-2.5	-9.2	-9.5	-3.0	2.3	6.3
	1996	1997	1998	1999	2000	2001	2002
ДНБ	563.2	585.7	606.4	625.9	632.5	639.7	
Өсөлт	2.3	4.0	3.5	3.2	1.1	1.1	

Тайлбар: Бодит ДНБ сая төгрөгөөр, 1995 оны зэрэгцүүлсэн үнээр
Эх үүсвэр: ОУВС, 2002, Хүснэгт 1.1, хуудас 7; ОУВС, 2003.

Гэвч шилжилтийн өмнө Монгол Улс хуучин Зөвлөлт Холбоот Улсаас (ЗХУ) их хэмжээний тусламж авдаг байсан. Энэ нь ойролцоогоор ДНБ-ий 30 хувийг эзэлдэг байжээ (ОУВС, 1996). Үүний үр дүнд үндэсний ашигласан орлого ДНБ-ээс 30 хувиар илүү байсан. Энэ тусламж нь ДНБ буурахтай нэгэн зэрэг үгүй болсон ба газрын тос зэрэг хамгийн чухал бүтээгдэхүүн нийлүүлэт үгүй болсон нь энэхүү уналтад зарим талаар нөлөөлсөн. ЗХУ-ын тусламж зогссоны дээр Монголын бараг бүх экспортын бүтээгдэхүүний зах зээл, импортын барааны ихэнхийг нь хангагч байсан Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл (ЭЗХТЗ) задарсан явдал мөн нэрмээс болжээ (ОУВС, 1996). Монгол Улс гэнэт хатуу мөнгөний арилжааны ертөнцөд хүчээр дасан зохицох шаардлагатай болж, ЭЗХТЗ-ийн үед найдвартай үнээр зарагддаг байсан зэс зэрэг экспортын үндсэн бүтээгдэхүүний үнэ огцом унаж, худалдаа арилжааны нөхцөл байдал ч эрсдэлтэй болжээ. Эдгээр хүчин зүйлүүд нь Монголын үндэсний орлого, хүн амынх нь амьжиргааны түвшин 1989-1993 оны хооронд 60 хувиар буурахад нөлөөлсөн тооцоо бий (Бооне, 1994).

Үнэн хэрэгтээ, бүтээгдэхүүний урьд өмнө үзэгдээгүй их бууралтыг үл харгалзан 1994-1995 онд өсөлт гарч эхэлсэн. Үүнд гадаад хүчин зүйлүүд илүү нөлөөлж байв. Ялангуяа, зэс, алт, ноолуур, газрын тосны үнэ хээхэн чухал байсан. Худалдааны хувьд таатай үр дагавар гарч Дэлхийн Банкны тооцоолсноор ДНБ бараг 8 хувиар нэмэгджээ. (Дэлхийн банк, 1997). Гэвч 1997-1998 оны дэлхийн эдийн засгийн хямрал нь өсөлтийн хэмжээг огцом унагасан. Үүний дараах сэтгэл гонсойлгосон үйл явдал нь 2000, 2001 оны цаг агаарын нөхцөл байдлын улмаас гол төлөв шалтгаалсан сүүлийн жилүүдийн эдийн засгийн өсөлтийн удаашрал байсан ч 2002 он гэхэд өсөлт эргэн 4 хувиар нэмэгдсэн. Энэ нь ДНБ шилжилтийн өмнөх 1989 оны өсөлтөд дөнгөж 2002 онд хүрсэн гэсэн үг. Хүснэгт 2-т үзүүлснээр нэг хүнд ногдох ДНБ хүн ам өсөхийн хирээр шилжилтийн өмнөх үеийнхээс доогуур, нэг хүнд ногдох ашигласан үндэсний орлого төвлөрсөн төлөвлөгөөт үеийнхээс хамаагүй доогуур хэвээр байна.

Хүснэгт 2: Нэг хүнд ноогдох бодит ДНБ, 1989-2002

	1989	1990	1991	1992	1993	1994	1995
Нэг хүнд ногдох ДНБ	542364	506508	446198	397124	383775	388793	406395
	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Нэг хүнд ногдох ДНБ	410626	421258	428662	437009	440122	438356	449672

Тэмдэглэл; 2000 оны үнээр
Эх үүсвэр; www.econstats.com

Хэдийгээр хөрөнгийн бүтээмж (ДНБ/Хөр) ДНБ-ээс илүү хурдан өссөнч энэ үзүүлэлт сүүлийн үед удааширч, хөдөлмөрийн бүтээмж (ДНБ/Хөд) шилжилтийн өмнөх түвшингээс доогуур байсаар байна (ОУВС, 2002, хуудас 8). Ажиглагдсан өсөлт нь үйлдвэрийн нийт бүтээмжид тусгагдсан үр ашигийн өсөлтөд үндэслэсэн болох нь харагдаж байна. Харин үйлдвэрийн нийт бүтээмж нь 1995-2001 оны хооронд дөнгөж 1,7 хувиар өссөн байна (ОУВС, 2002, хуудас 9). 1993-2000 онд ДНБ дунджаар 3,1 хувиар өсчээ. Дэлхийн эдийн засгийн байдал сайжирч байгаа Монгол Улсын эдийн засгийн өсөлт Ядуурлыг бууруулах завсрын баримт бичигт тэмдэглэсэн 5-6 хувьд өөрийн хүчээр хүрч хүн амынхаа дийлэнх хэсгийн амьжиргааны түвшинд тэмдэглүүштэй үр нөлөө үзүүлэх боломж бага байна.

Шилжилтийн эдийн засгийн бусад орны нэгэн адил, Монгол Улсад шилжилтийн улмаас инфляци маш өндөр түвшинд хүрч 1993 онд 325 хувьд хүрсэн байна (Никсон, Лувсандорж, 2000). Инфляци ийм өндөр түвшинд хүрсэн шалтгаан нь маш нарийн, төвөгтэй бөгөөд тодорхойлоход тийм ч амаргүй. Гэвч үүнийг үндсэн бараа, үйлчилгээний хангамжийн маш хурдацтай уналт, түүнийг дагасан үнийн чөлөөлөлт, улмаар үйлдвэр, аж ахуйн байгууллагууд зах зээлийн үнэд яаралтай шилжих шаардлагатай болсон зэргээр тайлбарлаж болох юм. Үнийн энэхүү өсөлт нь шилжилтийн эхний жилүүдэд улсын өмчийн болон хуучин улсын мэдэлд байсан үйлдвэр, аж ахуйн газруудын хэрэгцээнд уян хатан ханддаг хэвээр байсан банкны тогтолцооны улмаас улам эрчимжиж байсан, шилжилтийн турш мөнгөний хангамжийн өсөлт инфляцийн түвшнээс хол хоцорч байсантай холбоотой (Чимэддагва, 2000, хуудас 67).

Үйлдвэр аж ахуйн газрууд зах зээлийн харилцаанд орох, улсын татаасын хэмжээг бууруулахад мэдээж үнийн чөлөөлөлт зайлшгүй шаардлагатай байсан. Харин, дээр дурдсанчлан, үндсэн хэрэгцээний татаас нь хуучин тогтолцооны үед амьжиргааны түвшин дэх тэгш байдлын хэмжээг тогтвортой хадгалах гол хэрэгсэл байсан. Үүний хамтаар бүрэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, суурь үйлчилгээг хангах бодлого баримталдаг байсан нь шилжилтийн өмнөх үед ядуурал маш бага, хөрөнгө, орлогын хуваарилалтад тэгш бус байдлын хэмжээ харьцангуй доогуур байсныг илтгэж байна. Шилжилтийн үеэс эхлэн энэ байдал эмгэнэлтэйгээр өөрчлөгдөж тэгш бус байдал, ядуурал хурдацтай өсч, өндөр түвшинд хадгалагдсаар байна.

Ядуурал, тэгш бус байдал

Ядуурал, тэгш бус байдлын шинээр үүссэн хандлагын талаар Монголын Үндэсний статистикийн газрын (ҮСГ) мэдээнээс гадна олон тооны судалгаа, тайлангуудад мэдээлсэн байдаг. 1995 онд ҮСГ Дэлхийн банкны тусламжтайгаар Амьжиргааны түвшний түүвэр судалгааг (АТТС) хийжээ (Дэлхийн банк, 1996). НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн тусламжтайгаар 1998 онд хоёр дахь АТТС хийсэн байна (ҮСГ 1999). Эцэст нь, 2000 онд ҮСГ Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгааг хийсэн (ҮСГ, 2001). Эдгээр судалгааны тайлангууд нь НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн Хүний хөгжлийн илтгэл (НҮБХХ, 1997 ба 2000), Гриффиний илтгэл (1995) зэрэг бусад хэд хэдэн судалгаанаас гарсан үр дүнг баяжуулж, Ядуурлыг бууруулах стратегийн завсрын баримт бичигт (ЯБСЗББ) тусгагджээ (Монгол Улсын Засгийн газар, 2001). 1995 оны АТТС-ны ерөнхий үр дүнг Хүснэгт 3-т харууллаа.

Хүснэгт 3: Ядуурлын гол үзүүлэлтүүд, 1995

Бүс нутаг	Ядуурлын хэмжээ (P_0)	Ядуурлын ялгаа (P_1)	Ядуурлын гүнзгийрэл (P_2)
Хотод	38.5%	12.2	5.7
- УБ хот	35.1%	10.4	4.5
Хөдөөд	33.1%	8.9	3.6
Үндэсний хэмжээнд	36.3%	10.9	4.8

Эх сурвалж: Дэлхийн банк 1996, Хүснэгт 1.4, хуудас 25

Ядуурал шилжилтийн өмнөх үед бараг огт бүртгэгдээгүй байснаа нийт хүн амын гуравны нэгээс илүү хэсэг нь ядуу гэж тодорхойлогдох хүртэл өссөн байна. Илтгэлд хүн амын нилээд хэсэг ядуурлын шугамд ойрхон байгаа тул ядуурлын шугамын ялимгүй өөрчлөлтөд ядуучуудын тоо өсөх магадлал өндөр байгаа талаар тэмдэглэжээ. Ядуурлын шугамыг 10 хувиар нэмэгдүүлэхэд ядууралд байгаа хүн амын эзлэх хувь 43 хувь хүртэл өснө гэсэн тооцоо ч бий (Дэлхийн банк, 1996, хуудас 23). Харин ядуурлын ялгаа (P_1) болон ядуурлын гүнзгийрэл (P_2) нь олон улсын стандартаар харьцангуй доогуур байна (хуудас 24); ядуучуудын дийлэнх хэсэг нь ижил түвшний ядуу, ядуурлын шугамын дөнгөж дээгүүр байгаагаасаа тийм их ялгаатай биш байна. Энэ нь АТТС-ны мэдээн дээр үндэслэсэн хэрэглээний (үнийн өөрчлөлтөөр) хувьд тооцоолсон Жини коэффициент 3,1 байгаагаар илэрхийлэгдэж байгаа юм. Энэ үзүүлэлт нь Азийн шилжилтийн эдийн засгийн бусад орнуудтай төстэй байгаа бөгөөд хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан зарим улсынхаас хамаагүй доогуур байна (Милановик, 1999).

АТТС –гаар ядуу хүмүүсийн шинж байдалд дүн шинжилгээ хийж, ядуурал үүсч бий болсон сувгуудыг харуулжээ. Ядуурлыг хөдөлмөр эрхлэлтийн байдалтай холбон үзэхэд ажилгүйчүүдийн бараг 60 хувь нь ядуурлын шугамнаас доогуур байсан (Дэлхийн банк, 1996, хуудас 28) бөгөөд нэн ядуу хүмүүсийн талаас илүү хувь нь ажилгүйчүүд байна (хуудас 28). Тайланд ажилгүйдлийг албан ёсны статистикаас өндөр ойролцоогоор 20 хувь гэж тооцоолсон байна. Сүүлийн үеийн тооцоогоор ажилгүйдлийн бүртгэлд тэр бүр ажилгүй хүмүүс хамрагдахгүй байгааг тэмдэглэсэн байдаг. Энэ нь 1995 оны АТТС-ны үр дүнг мөн л бататгаж байна (Кларк эт эл, 2000). Хөдөөгийн ядуурлын хувьд мал сүргийн тоо хамгийн гол тодорхойлогч байдаг бөгөөд цөөхөн тооны малтай малчид хамгийн эмзэг хүмүүсийн тоонд багтдаг (Дэлхийн банк, 1996, хуудас 32). Тэтгэвэр авагчид болон аливаа тэтгэмжид найдаж амь зуудаг хүмүүсийн ядуучуудын дунд эзлэх хувь өндөр байна. Тэтгэмжийн хэмжээ инфляцийн түвшинтэй хөл нийлүүлж чадахгүй байгаа болон ядуучуудын зарцуулалтын ихэнх хэсэг болох үндсэн бүтээгдэхүүн, хэрэглээний үнийг чөлөөлсөнтэй холбоотой үр нөлөөг тооцож чадаагүй нь ядуурал өсөх хамгийн гол шалтгаан болсон. Гэвч тэтгэмж авах эрхийн асуудал чухал байдаг ба тэтгэврийн хэмжээ нь тэтгэвэрт гарсан он зэрэг зарим нэгэн нөхцөл байдлаар тодорхойлогддог тул зарим тэтгэвэр, тэтгэмж авагчид ядуу зарим нь үгүй байдаг байна (хуудас 33-35). Ядуучуудын бусад шинж байдлыг харахад бусад улсуудын нэгэн адил олон ам бүлтэй гэр бүлүүд, халамжлах хүнгүй хүүхдүүд, эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүд, тахир дутуу хүмүүс болон боловсролын түвшин доогуур хүмүүсийн ядуучуудын дунд эзлэх хувь өндөр байна.

Амьжиргааны түвшний хоёр дахь удаагийн түүвэр судалгаа нь (АТТС, 1998) 1995 оны АТТС-тай яг харьцуулахуйц (FIDE, 1999, 2001 оны ҮСГ –ын мэдээнээс) биш боловч Монголын ядуучуудын талаар бага зэрэг нааштай өөрчлөлт гарсан, зарим талаараа дордсон зүйл ч байгаа болохыг харуулжээ. Ядуурлын дөрвөн гол үзүүлэлтийг Хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт 4: Ядуурлын гол үзүүлэлтүүд, 1998

Бүс нутаг	Ядуурлын хэмжээ (P ₀)	Ядуурлын ялгаа (P ₁)	Ядуурлын гүнзгийрэл (P ₂)
Хотод	39.4%	13.9	7.1
- УБ хот	34.1%	13.0	7.4
Хөдөөд	32.6%	9.8	4.4
Үндэсний хэмжээнд	35.6%	11.7	5.6

Эх сурвалж: АТТС, 1999, р.24

Ядуурлын нийт хэмжээ 2 судалгааны хооронд ялимгүй өөрчлөгдсөн. Харин ядуурлын ялгаа, гүнзгийрэлтийн хэмжээ өсч байгаа нь сэтгэл зовоосон асуудал болоод байна. Ядуучуудын хэрэглээний дундаж түвшин ядуурлын шугамнаас 10-аас илүү хувь доогуур байгаа бөгөөд

ядуучуудын хоорондох орлогын хувиарлалт P_2 муудсаар байна. 1998 оны судалгаагаар бас Жини коэффициент өмнөх судалгаанаас хойш 3 жилийн хугацаанд 0,35 болж өссөн болохыг харуулжээ. Хэдийгээр энэ нь цочроох эмчилгээний замаар шилжилтээ хийсэн бусад ихэнх орнуудтай харьцуулахад доогуур байгаа боловч хурдацтай өсч байгаа нь сэтгэл зовоож байна. Ядуу байсан хүмүүс болон тэдний ядуурлын наад захын шалтгаанд хийсэн судалгааны тайлангийн дүн шинжилгээнээс харахад 1995 оноос бага зэрэг өөрчлөгдсөн нь харагдсан. Ажилгүйдэл, мал сүргийн хэмжээ 2 судалгаагаар ядуурлын гол шалтгаан хэвээр байсан ба ам бүлийн тооноос шалтгаалж байсан; ядууралд өртөх хамгийн өндөр магадлалтай хүмүүст эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүд орж байсан бөгөөд боловсролын түвшин ч үүнд бас нөлөөлжээ.

Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа нь (ҮСГ, 2001) амьжиргаанд үндэслэсэн эдийн засаг, нийгэм, эрүүл мэнд, бие бялдрын болон оюун санааны байдлын олон талт шалгуурыг ашиглан ядуурлыг илүү өргөн хүрээтэй, илүү чадавхид тулгуурлан судлаж өмнөх хоёр АТТС-ны үр дүнг баяжуулсан байна. АТОАҮС –нд “1992-1995 оны хооронд дунд зэргийн амьжиргаатай өрхийн нийт өрхөд эзлэх хэмжээ ерөнхийдөө буурч ядуу болон нэн ядуу өрхийн эзлэх хувь тэр хэмжээгээр өссөн болохыг хүмүүс тодорхойлсон нь энэ хугацаанд нилээд олон өрх ядууралд орсон болохыг харуулж байна. 1995-2000 оны хооронд ядуу, нэн ядуу өрхийн эзлэх хувийн өсөлт бүр ч их ажиглагдсан байна” (АТОАҮС, 2001, хуудас 11). АТОАҮС хүмүүсийн аж амьдрал хоорондоо холбоотой олон хэлбэрийн найдваргүй байдлаас болж эрсдэлд өртөмтгий эмзэг болсныг харуулжээ. Ажил олох боломж муудсанаас голчлон бий болсон эдийн засгийн найдваргүй байдал нь мал аж ахуйн эрсдлийг багасгах нийтийн үйлдлээс бий болсон байгаль орчны найдваргүй байдалтай хавсарч байлаа. АТОАҮС нь бас ураг төрлийн холбоо суларснаас болж нийгмийн найдваргүй байдал өсч байгааг онцлон тэмдэглэжээ. Тэрчлэн өрхүүд архидалт, доромжлол, хүчирхийлэл, салалт зэрэг бие бялдрын эрсдэлд өртөгдөж байгааг дурджээ (АТОАҮС, 2001, хуудас 20). Судалгаанд хамрагдагсад ажлаа алдах нь ядууралд өртөх хамгийн анхны хүчин зүйлс гэж үзэж байсан ба үүний дараа өвчин эмгэг, эмчилгээтэй холбоотой зардал ордог гэжээ (хуудас 21). Боловсролын зардал хурдацтай өсч байсан нь ялангуяа дунд зэргийн амьжиргаатай өрхийн ядууралд нөлөөлөгч хүчин зүйл байсныг бас тэмдэглэжээ. Орлогын ядуурлын гүнзгийрэл нь үйлчилгээний хүртээмжгүй байдал, сул засаглал, хээл хахууль зэрэг бусад найдваргүй байдлын өсөлтийг дагуулж байлаа. Эцэст нь дүгнэхэд 2000 оны байдлаар нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ шилжилтийн өмнөх үеийн түвшинд ч хүрээгүй, амьжиргааны дундаж түвшин 1980-аад оны сүүл буюу Монгол Улс хуучин ЗХУ-аас их хэмжээний тусламж авдаг байсан үеийнхээс мэдэгдэхүйц доогуур байсан хэвээр байна. ДНБ-ний энэ хэмжээ нь урьд өмнө үзэгдээгүй ядуурал буюу нийт Монголчуудын гуравны нэгээс илүү хэсэг нь албан ёсоор ядууралд байгаа болон нилээд хэсэг нь ядуурлын шугамд ойрхон амьдарч байгаагтай холбоотой. Нийгмийн хамгааллын сүлжээ суларч, боловсрол, эрүүл мэндийн салбарт олсон социализмын үеийн ололтоосоо ухарч нийгмийн

үйлчилгээний хүртээмж ядуучуудын хувьд төлбөрийн чадвараас нь хамаарах явдал нэмэгдсэн. Тэгш бус байдал нь Тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн (ТУХН) зарим улсуудтай харьцуулахад бага боловч өссөөр байгаа бөгөөд баян ядуугийн ялгаа нэмэгдсээр байгааг статистик мэдээ болон АТОАУС аль аль нь харуулж байна.

3. Монгол дахь хувьчлал

Хувьчлал нь Монгол орны шинэчлэлийн үйл явцын гол хэсэг байсан. Хувьчлалыг дэмжигчид үүний үр дүнг маш “сэтгэл хөдөлгөм” байсан ба Монгол Улс хуучин Зөвлөлт Холбоот Улсын (ЗХУ) бусад Бүгд найрамдах улсуудыг бодвол “хувьчлалын хөтөлбөр”-ийг хамгийн их амжилттай хэрэгжүүлсэн гэж үздэг байна (Гриффиний илтгэлээс авав, 1999, хуудас 9). Зарим төрлийн хувьчлал шилжилтийн эхэн үед үнэхээр боломжийн (ба хүсүүштэй) байсан боловч зарим төрлийн хувьчлалыг хийхгүй байж болох, ялангуяа хувьчлалыг хэт хурдан бишээр хийх нь зүйтэй байсан гэх мэт Гриффин (1994) янз бүрийн шүүмж байдаг. Мөн хувьчлалын зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед хувьчлалын гүйцэтгэх үүргийг “хэт үнэлсэн” бөгөөд Монгол Улсын хувьд хувьчлалд арай бага ач холбогдол өгөх ёстой байсан гэж үздэг ч явдал бий. Монгол орны хувьчлал нь зарим нэгэн захиргааны амжилтад хүргэсэн боловч шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлийг даван туулахад маш өчүүхэн дэмжлэг үзүүлжээ.

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрт зориулан гаргасан (Гриффин, 2001) хоёр дахь тайланд хувьчлалын дараах өмч хөрөнгийн дахин хуваарилалтад анхаарлаа хандуулсан байна. “Ядуурлыг бууруулах асуудлыг хөгжлийн стратегитай уялдуулах нь” (МУ-ын ЗГ, НҮБХХ, 2001) сэдэвт Үндэсний Семинарт тавьсан илтгэлдээ Гриффин ядуучуудад чиглэсэн эдийн засгийн өсөлтийг хурдасгах явдалд илүү тэргүүлэх ач холбогдол өгөх ёстой гэжээ. Уг семинар дээр үндэсний нэгэн төлөөлөгч хэлэхдээ “цоочроох эмчилгээ” амжилтгүй болсон бөгөөд “... үндэслэл, зохион байгуулалт муутай хувьчлал нь өмч хөрөнгийн будлиан үүсгэх өргөн боломжийг нээсэн бөгөөд зах зээлийг бий болгоход төрийн зохицуулалт, оролцоогүйгээр буруу бодлого явуулсан. Энэ бүхэн нь Монгол Улсад шударга бус нийгэм бүрэлдэх, орлого, хөрөнгийн хуваарилалтад шударга бус байдал нэмэгдүүлэх аюулд хүргэсэн” гэжээ (Пүрэвбаатар. 2001, хуудас 19)

Монгол Улсад хувьчлал эхлэлээ 1991 онд тавьсан бөгөөд энэ үед Монгол Улсын нийт өмчийн 75 хувийг эзэмшиж байсан төр анхныхаа хувьцаа эзэмших эрхийн бичгийг олон нийтэд олгож эхэлсэн (Стаббс эт эл, 2000; ХХ хавсралтын хувьчлалын он дарааллыг харна уу). 1991 оны 10 дугаар сард эхэлсэн хөтөлбөрийн хүрээнд 1991 оны 5 дугаар сарын 31-ээс өмнө төрсөн бүх иргэдэд улсын жижиг болон хоршоололд хувьцаа худалдаж авахад хэрэглэх 1000 төгрөгтэй дүйцэх 3 ширхэг ягаан эрхийн бичгийг тус бүрт нь олгосон. Энд жижиг үйлдвэр гэдэгт 50-аас доош хүн ажилладаг үйлдвэрийг хамруулжээ. Ягаан эрхийн бичиг нь хоёрдогч зах зээлд ашиглах боломжтой байв.

1991 оны 10 дугаар сараас 1992 оны 7 дугаар сарын хооронд 7000 төгрөгтэй дүйцэх нэг цэнхэр эрхийн бичгийг хүн бүрт олгосон. Ийм эрхийн бичгийг ойролцоогоор 550 хуучны улсын том үйлдвэрээс бүрдэх хамтарсан аж үйлдвэрүүдийн хувьцааны төлөө төндэрт оролцоход хэрэглэх боломжтой байжээ.

Цэнхэр эрхийн бичгийг худалдаж болдоггүй байсан бөгөөд харин төлөөлөлдөө дамжуулан өгч болдог байсан. Хувьцаа худалдах боломж бүрдүүлэх зорилгоор 1991 оны 1 дүгээр сард Монголын хөрөнгийн бирж байгуулагдсан. 1992 оны шинэ Үндсэн хуульд хувийн өмчтэй байх эрхийг баталгаажуулжээ.

Хувьчлагдсан үйлдвэрийн бодит тооны талаарх тооцоо өөр өөр байдаг. Монголын Засгийн газрын (Төрийн өмчийн хороо, 2002) тооцоогоор 1991-1994 оны хооронд эрхийн бичиг ашиглах замаар 4500 үйлдвэр, аж ахуйн газар хувьчлагдсан байна. 1996-аас 2000 он хүртэл 942 үйлдвэр, аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгө төндэрийн битүүмжилсэн дуудлага худалдаа, Англи маягийн дуудлага худалдаа, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хувьцаа худалдах болон бусад аргаар хувьчлагдаж, улсын орлогыг ойролцоогоор 48 тэрбум төгрөгөөр (65 сая ам.доллар) нэмэгдүүлсэн байна.

Эхний хувьчлалууд нь хувийн секторын өсөлтөнд хязгаарлагдмал боломж олгож байсан бөгөөд улс орныг төвлөрсөн байдалтай хэвээр орхиж байсан (Стаббс эт эл, 2000, хуудас 141). Жижиглэн худалдааны болон үйлчилгээний бусад салбарын хувьчлал, ийм салбар шинээр үүсэх явдал нь амжилттай хэрэгжсэн боловч төрийн өмчийн харилцаа, хяналтын түүх бие даасан үйлдвэрлэл явуулах, аж ахуй эрхлэх чадварыг хөгжүүлэх асуудал хязгаарлагдмал байсныг илэрхийлж байна.

Хувьчлах арга хэмжээ нь эхэндээ үйлдвэр, аж ахуйн нэгж бүрийг хувьчлах төлөвлөгөө боловсруулж батлахыг шаардаж байсан. Үйлдвэр, аж ахуйн нэгжийн хөрөнгөд зөв үнэлгээ хийх, “Замбараагүй хувьчлал” гэгчийг аль болох багасгахыг оролдох шаардлага болон хамтын эзэмшилтэй холбоотой асуудлуудаас (энэ нь өмчлөлийн асуудал хэврэг болж, бага хувьцаа эзэмшигчид үр бүтээлгүй байхтай холбоотой үүсдэг) гадна нилээд олон асуудлуудыг тодорхойлсон. Үүнд;

- Хэт эрмэлзэлтэй цагийн хувиараас болж хувьчлал хийх зохицуулалтууд нь шаардлагад нийцэхгүй байсан.
- Хувьцааны идэвхтэй зах зээлийг дэмжих нь хэцүү байх нь нотлогдсон. Ялангуяа, хамтын эзэмшил, эрх мэдлийн асуудлыг шийдвэрлэх нь хүндрэлтэй байсан.
- Эрхийн бичгийн талаарх олон нийтийн ойлголт сул байсан нь нилээд эрхийн бичиг хэрэглэгдэхгүй буюу хүнд зүгээр өгснөөс харагдаж байсан.

- Хувьчлалын үйл явцад ил тод байдал дутагдаж, боломжит хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл, мэдлэг олгох явдалд хангалтгүй анхаарал тавьсан байна.
- Хувьцааны хоёрдогч зах зээлийн хөгжил удааширч улмаар хамтран эзэмшлийн асуудлыг хурцатгасан.

Хувьчлалын эхний хөтөлбөрүүдийн амжилт буюу бусад зүйлсийн талаарх санаа бодол өөр өөр байдаг. Дээр дурдсанчлан Монгол орны хувьчлал нь улс төрийн чухал зорилгыг агуулж байсан ба ашигтай үл хөдлөх хөрөнгүүдийг улсын мэдлээс хувийн секторт шилжүүлэхэд хүргэсэн нь маргаангүй бөгөөд хувийн секторын хөгжилд чухал ач холбогдолтой байсан. Харин зарим хүмүүс хувьчлалыг хэт хурдан хийгдэж, ноцтой алдаанд хүрсэн ба олон нийтийн нүдэн дээр нэр хүндгүй болоход хүрсэн гэж үздэг байна.

1996 онд сонгууль явагдаж, Засгийн газар солигдсоны дараа 1997 онд хувьчлалын үйл явцын хурдасгаж, ил тод байдлыг нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, улсын орлогыг өсгөх зорилго бүхий хувьчлалын шинэ хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийг дагаад Монголын эдийн засгийг чөлөөлөх явдал хурдассан (хавсралтыг үз). Өмч хувьчлалын газар 2000 он хүртэл хувьчлагдах үйлдвэр, аж ахуйн газрууд, өмч хөрөнгийн жагсаалтыг гаргасан ба үүнд улсын бүрэн болон бүрэн бус эзэмшилд байгаа том жижиг үйлдвэр, аж ахуйн газрууд багтаж байсан. (Эдгээр үйлдвэр аж ахуйн газруудыг худалдаалах янз бүрийн арга замыг Стаббс эт эл, 2000, 144-5 дугаар хуудсанд дурдсан байдаг).

Засгийн газрын хувьчлалын талаарх өнөөгийн стратеги нь Монгол Улсын Засгийн газрын удирдамжид (2001; 2002)-д тусгагдсан байдаг. 2001 оны 1 дүгээр сард Улсын их хурлаас *2001-2004 оны Хувьчлалын удирдамжийг* (Монгол Улсын Засгийн газар) батлан гаргасан. Бодлогын эрхэм зорилго нь хувьчлалын үйл явцыг хурдасгах, эдийн засагт хувийн секторын оролцоог нэмэгдүүлэх явдал юм. Энэхүү стратеги нь Монголын томоохон компаниудыг (Хамгийн үнэтэй компаниуд-ХҮК) “ил тод, бодитой, олон улсын тендэр”-ийн замаар хувьчлахад чиглэдэг байна. Эдийн засгийн тухайн салбарт стратегийн чухал байр суурьтай, зах зээлд тодорхой нөлөө бүхий, гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломжтой компаниудыг ХҮК гэж тодорхойлжээ. Засгийн газар хувьчлал бүрийн хувьд тодорхой, бодит зорилго, ашиг тусыг тогтоохыг зорьж байгаа бөгөөд эдгээр зорилгод хүрэхийн тулд хэрэгжилт, үр дүнд нь хяналт хийх болно (МУ-ын ЗГ, 2002). Зорилго, Зарчим, Бүтэц, Зохион байгуулалт, Арга зам, Мэдээлэл, Эрх зүйн хүрээ бүгд Монгол улсын Засгийн газрын төрийн өмчийн хорооны хувьчлалын удирдамжид (2001)-д тодорхой тусгагдсан байна.

Засгийн газар дэд бүтэц (цахилгаан дулаан, зам харилцаа, төмөр зам болон бусад салбар, үйл ажиллагаа), нийгмийн салбар (эрүүл мэнд, боловсрол, соёл, урлаг), газар эзэмшилд бүтцийн өөрчлөлт, хувьчлал хийх зорилтоо нийтэд мэдэгдсэн. Засгийн газар газар

хувьчлал, өмчийн шинэчлэлийг хэрэгжүүлэх алхам хийхээр бэлтгэж байна. Газрын тухай хууль, Газар өмчлөлийн тухай хуулийн хэрэгжилтийг хурдасгах, газрын бүртгэл, кадастрал судалгаа хийсний үндсэн дээр Монгол иргэдэд газар өмчлүүлэх ажлыг эхлэх болно (МУ-ын ЗГ, 2001, хуудас 75).

1992 онд хийгдсэн мал хувьчлал, 1996-1997 онд хийгдсэн орон сууцны хувьчлалыг тусгайлан дурдах нь зүйтэй.

Мал хувьчлал

Шилжилтийн өмнөх үед хэдийгээр Монголд хязгаарлагдмал тооны хувийн малтай байхыг зөвшөөрдөг, хувийн гэрээгээр мал маллах тогтолцоо 1980-аад онд нэвтэрсэн байсан боловч мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд улсын мэдлийн хоршооллууд давамгайлдаг байсан (Рассел эт эл, 2000, хуудас 162). Хэдийгээр хоршооллын (*нэгдэл*) гишүүд нийгэм, эдийн засгийн хувьд ялгаатай байсан боловч тэгш бус байдлын хэмжээ бага, ихэнх ашигтай хөрөнгө улсын мэдэлд байсан (Гриффин, 2001, хуудас 10). 1990 оноос өмнө Монгол Улс бэлчээрийн мал аж ахуйг дэмжих, ган зудыг (мал бэлчээрээс өвс ургамал олж идэхэд саад болдог өвөлтэй холбоотой янз бүрийн нөхцлийг Монголд энэ үгээр илэрхийлдэг) даван туулах татааст ихээхэн түшиглэсэн боловч үр дүнтэй зохион байгуулалтын тогтолцоог хөгжүүлэн ашиглаж байсан (Миллер, он байхгүй, хуудас 5).

Мал хувьчлал нь даруй өөрчлөлтөд хүргэсэн. Малын анхны хуваарилалт өрхүүдийн болон хувь хүмүүсийн аль алины хувьд тэгш бус байсан ба малыг зөвхөн малчдад хувиарлаагүй байна (Нэгдлийн малчдаас гадна өөр ажиллагсад харьцангуй их хэмжээний мал авах тохиодол нилээд гарчээ) (Гриффин, 2001). Туршлагатай малчид, алдартай өрхийн гишүүд хувьчлалаас ашиг олсон байхад залуу малчид, өрх толгойлсон эмэгтэйчүүд үүнээс сайн ашиг хүртээгүй байна (ганц бие эмэгтэй малчид мал хуваарилалтаас оногдсон хэмжээнээсээ багыг авсан баримт байна-энэ талаар Робинсон, Солонго, 2000-аас харна уу).

Гриффиний (2001) ишлэл авсан тоон мэдээнээс харахад 1992 он гэхэд өрхийн яг 5 хувь нь 200-аас дээш толгой малтай болсон байсан ба хувиарлалтын төгсгөлд нийт өрхийн 42 хувь нь 31-ээс доош толгой малтай байсан. 2000 онд нийт өрхийн 63 хувь нь 100-аас доош толгой малтай, 22 хувь нь 100-200 толгой малтай, 12 хувь нь 200-500 толгой малтай байсан гэсэн тооцоо гарчээ (Миллер, он байхгүй, хуудас 3). 100-150 толгой малтай малчин өрхийг ерөнхийдөө амьжиргаагаа залгуулахад хангалтгүйд тооцдог. Мэдээж, хөдөөгийн хүн амын дунд ядуурал, тэгш бус байдал газар авсан талаар баримт байдаг.

Анхны хувиарлалт тэгш бус байснаас гадна ийм ялгаатай байдал бий болсон янз бүрийн шалтгаан байдаг. Цөөн тооны толгой мал авсан зарим өрхүүд олон малтай байх нь хэцүү

гэж үзсэн; малчдын мал маллах ур чадвар янз бүр байсан ба зарим залуу, туршлагагүй малчид байгалийн гамшиг болон ур чадваргүйгээсээ малаа алдсан байдаг, зарим нь эдийн засгийн хүнд үед амьжиргаагаа залгуулахын тулд малаа зарж хэрэглэсэн байдаг байна (Гриффин, 2001). Харин зарим өрхүүд малынхаа тоог нэмэгдүүлж амжилттай ажилласан нь тодорхой.

Мал хувьчлахын хамт нэгдэл, улсын фирмүүд хуваагдаж, задарсан. Энэ талаар Миллерээс (он байхгүй, хуудас 5-6) иш татах нь зүйтэй:

“Малын эмчийн үйлчилгээ, мал усалдаг худгийн засвар үйлчилгээ, болон мал аж ахуйн бүтээгдэхүүнийг дэмждэг улсын бусад дэмжлэгийн хэмжээ багассан. Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны судалгаа, мал маллах олон арван жилийн туршлагын ололт амжилт орхигдож эхэлсэн. Хөдөөгийн зах зээл уналтад орж, арилжааны эдийн засаг, малын арилжаанд хүргэсэн. Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ суларсан. Улс бэлчээрийн эрсдлийн удирдлага, ялангуяа өвс тэжээл үйлдвэрлэдэг хуучин татаасын хариугүй уналтад орох гэж байгаа системээс түргэн тусламжийн өвс тэжээлээр хангах, малын заавал даатгал зэргээс ухралт хийсэн. ...Эдийн засгийн шилжилт нь ядуурлын түвшин, гүнзгийрэлт нэмэгдэх, шатахууны үнэ өсөх, машины сэлбэг ховордох, худаг эвдэрч ашиглалтаас гарах, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хүртээмж багасахад хүргэсэн ба энэ бүгд нь бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг гэр бүлүүдэд сөргөөр нөлөөлсөн. Худаг, усан хангамж, хот суурин газар, зам, өвс ургамал сайтай газар малын бөөгнөрөл нэмэгдсэн явдал нь бэлчээрийн элэгдэл болон бэлчээр, нутгийн талаарх маргаан нэмэгдэхэд хүргэсэн”

Хувьчлалын дараах байдал нь малын тоо толгой, сүргийн бүтцэд гарсан өөрчлөлтийн улмаас төвөгтэй болсон. 1991 онд 25,5 сая мал тоологдсон ба 1999 он гэхэд 33,5 сая болж өсчээ. Гэвч цаг уурын хүндрэлээс болж малын тоо 2002 онд 23 сая болж буурсан байна (АХБ, 2003). 1999/2000 оны зуднаар 2,8 сая толгой мал хорогджээ. Үүний дараа нутгийн өмнөд болон баруун хэсгийн ихэнхийг хамарсан ган болж ихэнх мал зуданд тэсвэргүй болсны улмаас 4,1 сая толгой мал хорогджээ (бүх тоог Миллерээс авав, он байхгүй, хуудас 6-7). Бэлчээрийн эрсдлийн удирдлагын урд байсан үр дүнтэй тогтолцоо үгүй болж, засгийн газар үр ашигтай хариу арга хэмжээ авах чадваргүй байлаа. Малчид улсаас тусламж дэмжлэг хүлээсэн хэвээр байсан ба энэ нь дандаа бэлэн байх нь үгүй байлаа. Малчид өөрсдөө малын тоо толгой нэмэгдсэнээс бий болсон хүндрэл, нэгдэлийн задрал, цаг агаарын хүнд нөхцөл байдал зэрэгт бэлэн бус, хариу арга хэмжээ авах чадваргүй байсан. Мал сүрэг нь тэмээ, адуу, үхэр, хонь, ямаанаас бүрддэг. Тэмээ хонины эзлэх хувь буурсан (1989 онд нийт сүргийн 58 хувийг эзэлдэг байснаа 2000 онд 46 хувь болж буурчээ). Харин зах зээлд ноолуурын үнэ ханш нэмэгдсэний улмаас ямааны нийт сүрэгт эзлэх хувь 1989 онд 20 хувь байснаа 2000 онд 34 хувь болж өсчээ (Миллер, он байхгүй, хуудас 3). Мал сүргийн тоо хэмжээ, бүтцийн аль алинтай холбоотой асуудал гарч ирсэн. Монгол улс

бэлчээрийн хамгаалал, сайжруулалтад тодорхой хөрөнгө оруулахгүйгээр, хөдөө аж ахуйн бүтээмжийг сайжруулахгүйгээр, фирмийн бус үйл ажиллагаа хөгжүүлэхгүйгээр, дэд бүтцийг сайжруулахгүйгээр, зах зээлд улам ойртохгүйгээр мал сүргийнхээ тоог нэмэгдүүлэх бэлчээрийн даацтай юу? Мал сүргийн бүтцэд гарч байгаа өррчлөлтүүд нь хэрэглэгчдийн өсөн нэмэндэж байгаа хэрэгцээ, тухайлбал, махны хэрэгцээ, болон аж үйлдвэрийн салбарын чухал хэсэг болох боловсруулах үйлдвэрлэлийн (ноос, ноолуур, савхи) хэрэгцээнд нийцэх үү? (Рассэл эт эл, 2000).

Монгол Улсын Засгийн газар хувийн болон хагас хувийн газар эзэмшлийн тогтолцоонд шилжих гэж байна. 2002 онд УИХ 2003 онд хэрэгжүүлэх газрын тухай 2 хууль батлан гаргасан. Эхний хууль нь хотын ба хотын захын газрын хагас өмчлөлийн тогтолцоог солих, өвлүүлэх, худалдах эрхтэйгээр удаан хугацаагаар өмчлүүлэх, барьцаалан түрээслүүлэх замаар ашиглах боломжтой болгон өргөжүүлсэн байна (АХБ, 2003, хуудас 4). Хоёр дахь хуулиар Монголын гэр бүл бүрт жижиг газар хувьдаа эзэмших зөвшөөрөл олгосон. Танил тал сайтай, нөлөө бүхий, дунд ба түүнээс дээш орлоготой бүлгүүд дийлэнх болох ядуучуудыг хохироох замаар түрээсийн зах зээлд давамгайлах асуудал тулгарч байна (АХБ, 2003).

Орон сууцны хувьчлал

Хувьчлалын өмнө орон сууц, сууцны барилгууд нь Улс, хоршоо, үйлдвэр, аж ахуйн газрын өмч байсан. Монгол иргэд Орон сууцны хороо, орон нутгийн засаг захиргаа, үйлдвэр, аж ахуйн газарт орон сууц хүссэн өргөдөл гаргаж, хүлээлгийн жагсаалтанд нэрээ бичүүлдэг байсан (Зарим нэгэн дугааргүй үйлчлүүлэх тусгай тохиолдлууд байдаг байсан).

Хувийн орон сууцыг хувьчлах бэлтгэл ажил 1993 онд эхэлсэн. Хамгийн анхны алхам нь орон сууцны жинхэнэ эзнийг тогтоох явдал байлаа (Нэг орон сууцанд хэд хэдэн хүн амьдрах тохиолдол нийтлэг байсан тул энэ нь тийм хялбар байгаагүй). 1996 оны 10 дугаар сард УИХ-аас шаардлагад нийцсэн эрх зүйн баримтыг батлан гаргаж, 1997 оны 5 дугаар сараас эхлэн орон сууцыг хувьчилж эхэлсэн. Орон сууцыг оршин суугчдад үнэгүй өгсөн бөгөөд 1997 оны 5 дугаар сараас 1998 оны эцэс хүртэл 84,584 орон сууц (370 тэрбум төгрөгийн ...өртөг бүхий) хувийн өмч болсон (орон сууцны судалгааг үзнэ үү). Нэгэн тооцооноос харахад (орон сууцны судалгаанд иш татсанчлан) ойролцоогоор нийт хүн амын 22 хувь нь энэ хувьчлалаас ашиг хүртжээ.

1998 оны байдлаар нийт хүн амын 52 хувь нь гэрт амьдардаг байсан ба хөдөөгийн нийт хүн амын 75 хувь, хотын оршин суугчдын 29 хувь нь гэрт амьдарч байсан тооцоо гарчээ (Гриффин, 2001). Орон сууцны хувьчлалын үр дүнд хөдөөгийн хүн ам ба хотын ядуучуудын ихэнх нь юу ч олж аваагүй бөгөөд харин тухайн үед орон сууцанд амьдарч байсан хүмүүс мөнгө зээлэхэд барьцаалж болох, түрээслэж болох, бизнесийн үйл ажиллагаа эхэлж болох,

мөнгө олохын тулд зарж болох, зарим тохиолдолд хөрөнгө мөнгө олох чухал эх үүсвэр байж болох үнэт хөдлөшгүй хөрөнгөтэй болсон байна. Иймээс орон сууцны хувьчлал нь ашигтай хөрөнгийн хувиарлалт дахь тэгш бус байдлыг мэдэгдэхүйцээр нэмэгдүүлэхэд хүргэсэн гэж үзэж болохоор байна (Гриффин, 2001, хуудас 10). Эдгээр асуудлыг 6-р хэсэгт илүү нарийвчлан хэлэлцэх болно.

4. Онолын төлөв байдал

Энэ хэсэгт хувьчлалын 'үйл явц' ядуурал, орлогын хувиарлалтад гарсан өөрчлөлтөд хүргэсэн замыг илүү албан ёсны, өрөнхий байдлаар авч үзнэ. Хувьчлалын 'үйл явц', түүний үр нөлөө 2-ын учир шалтгааны төрөл бүрийн сувгуудыг тодорхойлно. Мөн ядуурал, тэгш бус байдалд үзүүлж буй үр нөлөө нь учир шалтгааны эдгээр сувгууд цаад хүчин зүйлсээс шалтгаалах хэмжээтэй нарийн холбоотой байдаг талаар онцлон дурдана. Цаад хүчин зүйлсийн ихэнх нь хувьчлал шиг шилжилтийн үйл явцын нэгэн хэсэг байдаг.

Ядуурал, орлогын хувиарлалтад хувьчлалын хувиарлалтад үзүүлсэн нөлөө

Хувьчлалыг явцуу байдлаар хөрөнгийн хувиарлалтад гарсан зүгээр нэг өөрчлөлт гэж тодорхойлж болно. Учир нь улсын мэдэлд байсан хөрөнгө хувь хүмүүст шилжин очсон. Урд өмнө улсын мэдэлд байсан хөрөнгийг зөв үнэлж, бүрэн мэдээлэл бүхий байгууллага, хувь хүнд худалдсан бол хэдийгээр хувьчлал төрөл бүрийн өмчийн эзэмшлийг дахин хувиарлаж байгаа боловч хөрөнгийн хувиарлалтад нөлөө үзүүлэхгүй байх байсан; Тухайн байгууллага, хувь хүний мөнгөн хадгаламж авсан хөрөнгийн үнэтэй адил хэмжээгээр буурч, улсын орлого худалдсан хөрөнгийн үнэтэй тэнцүү хэмжээгээр өсөх байсан гэдгийг дурдах нь чухал ач холбогдолтой (Алексеев, 1999, Хуудас 450). Ядуурал тэгш бус байдалд үзүүлэх үр нөлөө нь (а) улсын өмчийг үнэн зөв үнэлээгүй хэмжээ (б) хувь хүн байгууллагуудад мэдээлэл жигд хүрэхгүй буюу хувьчлалын үр шимийг хүртэх тэгш боломж байхгүй байгаа хэмжээ (в) хөрөнгийн хувиарлалтад гарсан өөрчлөлт орлогын бодит хангамжид хэрхэн нөлөөлөх арга зам (г) хөрөнгө эзэмшлийн шинэ бүтэц гэнэтийн гадны цохиолтод хариу арга хэмжээ авах арга зам зэргээс хамааран бий болдог.

Хэдийгээр хувьчлалын эхэн үед хөрөнгийн хувиарлалтанд тэгш бус өөрчлөлт гарсан гэж үзэх онолын үндэс байгаа боловч ядуурал, тэгш бус байдалд гарсан өөрчлөлт нь бодит орлогын урсгалын хувиарлалтанд гарсан өөрчлөлтийн тусгал юм. Тиймээс, хувьчлалын үр нөлөө нь хувьчлалын дараах хөрөнгийн шинэ хувиарлалт бодит орлогын урсгалын өөрчлөлтөд хүргэж буй арга замаас хамаардаг. Энэ арга зам нь маш их ярвигтай байж болно. Тухайлбал, орон сууцны хувьчлал бодит орлогын урсгалыг шууд өөрчилдөггүй. Хүмүүс өөрсдийн амьдарч байсан орон сууцандаа хэвээр амьдарч хувьчлалын дараа урдын адил байрны үйлчилгээг хүлээн авсаар байдаг. Харин, хувьчлалын дүнд эзэмшигч нар өрөөгөө түрээслүүлэх, бизнэсийн зорилгоор ашиглах, үйлдвэрлэл явуулах хөрөнгөтэй

болох зорилгоор худалдах зэрэг орлогын хувиарлалтанд нөлөөлж болох шийдвэр хийх боломжтой болдог. Хувьчлалын хувиарлалтын үр нөлөөнд дүн шинжилгээ хийхдээ энэ байдлыг сайн судлах ёстой.

Тэгш бус хувиарлалтын үзүүлсэн нөлөө

Хувьчлалын үр нөлөө нь орлогын хувиарлалт дахь аливаа өөрчлөлтийг улам дордуулах олон тооны шууд бус үр нөлөөг агуулдаг. Хувьчлал, үүнтэй холбоотой өөрчлөлтүүд хөрөнгийн ашигийн хэмжээг өөрчлөх хандлагатай байдаг (Бирдсалл ба Неллис, 2002; Алексеев, 1999). Тэрчлэн, хөрөнгийн өмчлөл нь байгууллагын хяналт, эдийн засгийн бусад эх үүсвэр, ялангуяа эдийн засгийн эрх мэдлийн бусад хэлбэрт хүрэх боломжийг өөрчилдөг. Тухайлбал, байгууллага, хувь хүний зээл авах боломж нь хангалттай хөрөнгө барьцаалах чадавхитай нь шууд хамааралтай байдаг. Тэгш бус хувьчлал нь байгууллага, хувь хүмүүсийн хөрөнгө барьцаалах боломжийг өөрчлөж, улмаар зээл авах тэгш бус боломжийг үүсгэн, шинээр үүсч буй хувийн секторт оролцох байгууллага, хувь хүмүүсийн чадавхийг боогдуулна. Энэ нь орлогын бодит хангамжийн хувиарлалтад бие даасан, үргэлжилсэн нөлөө үзүүлэх болно (Фериера, 1999). Түүнээс гадна, хөрөнгө эзэмшил дэх өөрчлөлт нь байгууллага, хувь хүний яаралтай үед авах арга хэмжээний төлөвлөгөө байр суурийг шууд өөрчилдөг. Энэ нь тухайн байгууллага, хувь хүний гэнэтийн цохилтод эмзэг байдлыг нэмэгдүүлэх ба эрсдлийг давж гарах, эдийн засгийн шинээр үүссэн боломжийг ашиглах чадварт нөлөөлдөг. Эдгээр хүчин зүйлс нь хувьчлал орлогын хувиарлалт, цаашилбал цагийн явцад ядуурал, тэгш бус байдалд нөлөөлөх болохыг харуулж байна. Иймээс хувьчлалын ядуурал, тэгш бус байдалд үзүүлэх нөлөөний талаарх дүгнэлт нь цаг хугацаанаас хамаардаг ба олон жилийн дараа магадгүй тэнцвэрт нөлөөнд хүргэдэг байна (Бирдсалл ба Неллис, 2002, хуудас 7).

Changes in the Behaviour of Privatised Institutions

Хөрөнгө эзэмшлийг өөрчлөх нь шилжилтийн гол зорилгын нэг юм. Энэ нь эрх мэдлийн улс төрийн шинэ хувиарлалтыг бэхжүүлж хуучин тогтолцоонд буцах явдлыг боломжгүй байдалд оруулдаг. Гэвч, хувьчлал нь эдийн засгийн үр нөлөөнийхөө хувьд зөвтгөгдөх нь олонтаа байдаг. Ийм үр нөлөө нь хувьчлалын улмаас хуучин улсын өмчийн удирдлагын зорилго, эрх мэдэлд гарсан өөрчлөлтийг дагаж бий болдог. Харин, эдгээр өөрчлөлтүүд нь заавал хувьчлалын үр дүн байх албагүй бөгөөд энэ нь нилээд улс оронд хувьчлалаас өмнө улсын мэдэлд байсан үед гарсан гэдгийг дурдах нь зүйтэй. Гэвч зорилго, эрх мэдэлд хийгдсэн эдгээр өөрчлөлтөөс урган гарсан ядуурал, тэгш бус байдалд үзүүлэх үр нөлөөг гол төлөв хувьчлалын үйл явцын нэг хэсэг гэж үздэг. Эдгээр үр нөлөө нь ээдрээтэй ба онолын хувьд ч бие биенээс нь ялган үзэхэд төвөгтэй байдаг. Бас эдгээр нь хэд хэдэн өөр өөр түвшинд үйлчилдэг.

Үйл ажиллагааны зорилгыг үр ашигт чиглүүлэн нарийсгана гэдэг нь хангамжийн хэд хэдэн хэлбэр, тухайлбал, хүүхэд асрах, зарим нэгэн болосролын үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээний зарим хэлбэр, зарим тохиолдолд орон сууцны хангамжийг үгүй хийснийг харуулж байна (Коммандер эт эл, 1999, энэ ойлголт нь Оросын тохиолдол гэдгийг анхаарна уу). Эдгээрийн нилээд нь шинэ төр хангах хүсэлгүй буюу чадваргүй нийгмийн төлбөрийн зах зээлийн бус элементүүд байсан. Энэ нь ядуурал, тэгш бус байдалд шууд үр нөлөө үзүүлэх хандлагатай байдаг байна. Тэрчлэн үр ашигт онцгой ач холбогдол өгөх нь хувьчлалын шууд үр дагавар гэж үзэх ёстой цаашдын өөрчлөлтүүдэд хүргэдэг. Ядуурал, тэгш бус байдалд үзүүлэх нөлөөнийхөө хувьд хамгийн чухал нь хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс, үнэд гарсан өөрчлөлтүүд юм.

Ихэнх орнуудад хувьчлал нь ажиллах хүчний томоохон өөрчлөлт, хэмнэлтэд хүргэсэн (Бирдсалл ба Неллис, 2002). Энэ нь бараг бүх тохиолдолд ажилгүйдэл асар ихээр нэмэгдэхэд хүргэж, ядууралд ба тэгш бус байдалд шууд нөлөөлсөн. Яг нарийн тодорхой үр нөлөө мэдээж бие биеэсээ шалтгаалсан олон тооны нөхцөл байдлаас хамаарна (Фериера, 1999). Үүнд ажлын байраа алдсан ажилгүйдчүүд дахин ажилд орох хурдыг тодорхойлох шинээр үүссэн хувийн секторын эрүүл саруул байдал, оршин тогтнох чадвар орно.

Тэрчлэн, улсаас үзүүлдэг халамж, үйлчилгээний төрөл, хэмжээ нааштай нөлөө үзүүлдэг. Шилжилтийн үнэ цэний ихээхэн хэсэг нь голчлон улсын ажлаа алдсан хүмүүст ноогддог ба энэ нь хувьчлал эхэлснээс хойш нилээн хэдэн жил сунжирч болзошгүй бөгөөд шинэ, урт хугацааны тогтвортой улсын онцлог шинж тэмдэг байж болно гэсэн эргэлзээ байдаг байна (Фериера, 1999).

Ашигийн төлөө шинээр бий болсон хүсэл чадавхийн өөр нэг үр дагавар нь фирм доторхи орлогын хувиарлалтад үзүүлэх үр нөлөө юм. Үүнээс хоёрыг тусгайлан авч үзье. Нэг дэх нь шинэ хөрөнгө эзэмшигч, ажилчин хоёрын хоорондын хувиарлалт ба өргөн хүрээгээр нь цалин ашиг хоёрын хоорондох хувиарлалтыг хэлж болно (Милановик, 1999). Хоёрт, үйлдвэрийн хувьцаан дахь хувиарлал өөрчлөндөх хандлагатай байдаг. Хувьчлал нь өндөр орлоготой удирдах ажилтан, мэргэжилтнүүд болон энгийн ажилчидын хоорондох хувиарлалтыг сунгахад хүргэдэг (....). Энэхүү заримыг нь баяжуулж, заримынх нь цалинг огцом унагахад хүргэж байгаа хувиарлалтын голчийг өөрчлөх явдал нь Зөвлөлт маягийн эдийн засгаас шилжих шилжилтэд нийтлэг байсан (Милановик, 1999; Коммандер эт эл, 1999).

Хувьчлал бас харьцангуй үнийн огцом өөрчлөлтөд хүргэсэн. Хувьчлал нь социализмын үед төр засаг үндсэн бараа, үйлчилгээг үнэ хямдтай, хүртээмжтэй байх явдлыг хангадаг байсан татаасын тогтолцоог үгүй хийх үйл явцын хэсэг юм. Тиймээс хувьчлалын зайлшгүй үр

нөлөөний нэг нь өдөр тутмын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний харьцангуй үнийн өсөлт юм. Энэ нь ядуучуудын амьжиргааны түвшинд шууд нөлөөлдөг. Энэ үр нөлөө нь тухайн үед шилжилтийн бүх орнуудад тохиолдсон инфляцаас огт тусдаа асуудал байсныг анхаарах хэрэгтэй. Харин, алсын үр нөлөө нь тодорхой бус байна (Бирдсалл ба Неллис, 2002, хуудас 15-16). Хэрвээ хувьчлалын дүнд бүтээмж нэмэгддэг бол хувьчлагдсан бүтээгдэхүүний харьцангуй үнэ буурч болно. Харин энэ нь өрсөлдөөнт орчин, зохицуулах хүрээнээс ихээхэн хамаардаг ба тэдгээр хувьчлалын улмаас тодорхой бус байдаг. Тэрчлэн, хувьчлалын улмаас ядуучуудын боломж хязгаарлагдахад хүрдгийг тэмдэглэх ёстой. Энэ нь ядуучуудыг төгсгөлгүй үнэтэй хувьчлалын дараах үетэй танилцуулж байгаа мэт бодогдуулж байна (Бирдсалл ба Неллис, 2002, хуудас 16).

Засгийн газрын санхүүжилтэд хувьчлалаас үзүүлэх нөлөө

Хувьчлал ядуурлын түвшин, орлогын хувиарлалтад нөлөөлж болох сүүлийн нэг чухал боломжит суваг бол хувьчлалын төрийн санхүүд үзүүлэх нөлөө байдаг (Бирдсалл ба Неллис, 2002, хуудас 17). Энэ үр нөлөө нь төвөгтэй бөгөөд ядуурал, тэгш бус байдалд үзүүлж болох нөлөөний чиглэл нь хоёрдмол байдаг. Улсын өмчийн олон газрууд, ялангуяа, улсын мэдлийн фирмүүд маш их татаас авдаг байсан. Хувьчлал нь дор хаяж зарчмын хувьд эдгээр татаасын хэрэгцээг үгүй болгодог. Түүнээс гадна, нэгэнт хувьчлагдсан хуучны улсын өмчийн фирмүүд нь зарчмын хувьд татвар төлөх ёстой ба улсын мөнгөн хангамжид эерэг хувь нэмэр оруулах ёстой байдаг. Харин, үүний хамтаар улс орны нийгмийн талаарх олон үйл ажиллагааг улсын мэдлийн байгууллагууд гүйцэтгэдэг байсан. Орост нийгмийн үйлчилгээний хангамжийг бууруулж байсан талаар баримт байдаг (Коммандер эт эл, 1999) бөгөөд ийм замаар үр ашигийг дээд хэмжээнд нь хүргэх аргыг шилжилтийн бусад орнуудад ч хэрэглэх хандлагатай байдаг. Ийм мөнгөн бус тэтгэмжийг хангах үүрэг хариуцлага улсад шилждэг бөгөөд шилжилтийн эдийн засгийн бусад орны туршлагаас харахад төр энэ үүргийг хүлээх бэлтгэлгүй байдаг байна (Коммандер эт эл, 1999).

Засгийн газрын бодлого нь өргөн утгаараа болон илүү тодорхой байдлаараа аль алинд нь хувьчлалын үйл явцад нэн чухал ач холбогдолтой. Хувьчлал эхэлмэгц улсын нөөц болон Засгийн газрын бодлого өөрчлөгддөг. Хувьчлалд үнэлгээ хийхдээ хувьчлалын өөр өөр загвар, үйл явцад төр засгийн бодлого нь хэрхэн үйлчилж байгаа, хувьсан өөрчлөгдөж байгааг тодорхойлох нь чухал байдаг.

Шалтгаалах гол сувагууд

Хувьчлал нь ядуурал, орлогын хувиарлалтад нөлөөлж болох сувгийн талаар авч үзэхэд 3 гол сувгаар нөлөөлж байна гэж үзэж болно:


- Хөрөнгө эзэмшилд гарсан өөрчлөлтийн бодит орлогын хангамжид үзүүлэх нөлөө;
- Эзэмших эрхэд өөрчлөлт гарсантай холбоотой бүтцийн өөрчлөлт;
- Хувьчлалын улмаас төсөв санхүүжилтэд гарах өөрчлөлт гэх мэт.

Хэдийгээр эдгээр холбоо аль ч хувьчлалд үйлчлэх хандлагатай байдаг боловч аль нь илүү давамгайл нөлөө үзүүлэх болон нийт үр нөлөө нь бусад хүчмн зүйлсээс хамаарна. Анхдагч учир холбогдолтой нөлөөнүүдийг холбогч эдгээр цаад хүчин зүйлсийн нилээд нь зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн чухал элемент байдаг.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн улмаас улс бүрт бүтээгдэхүүн, хөдөлмөр эрхлэлт буурсан бөгөөд энэ нь хувьчлалтай холбоотой байж болох өөрчлөлтүүдээс тусдаа, давхар явагдсан байдаг. Үнэндээ, бүтээгдэхүүний бууралт нь хувьчлалын өмнө явагдсан боловч үр нөлөөнийх нь хувьд тэдгээрийг тусгаарлаж үзэх нь маш төвөгтэй байдаг. Түүнээс гадна, зах зээлд шилжих шилжилт нь маш өндөр инфляцийг дагуулсан. Үнийн инфляци болон харьцангуй үнийн өөрчлөлтийн аль аль нь ядуучуудад нэмэгдсэн бодит орлогод маш огцом нөлөө үзүүлсэн байж болзошгүй.

Шууд болон тодорхой хүчин зүйлсийн хажуугаар хувьчлалын үр нөлөөнд нөлөөлөгч бусад олон тооны хүчин зүйлс байдаг. Эдгээрээс хамгийн чухал нь хувьчлал хийгдсэн зохион байгуулалтын тогтолцоо юм. Өргөн утгаараа энэ нь хуулийн нийт тогтолцоо, хуулийн мөрдөлт, ялангуяа өмчийн эрх, гэрээний тухай хууль зэрэг амин чухал салбарын хуулийн мөрдөлт зэргийг хамарна. Явцуу утгаараа, шинээр хувьчлагдсан секторын байдал төрх нь хувьчлалын үеийн зохицуулалтын бүтэц болон янз бүрийн хувьчлал хийгдэхэд ийм бүтэц үүсч бий болох, хөгжих арга замаас маш хүчтэй хамаарах болно.

Хувьчлал хуваарилалт, ядууралд нөлөөлж болох төрөл бүрийн сувгуудыг 1 дүгээр хүснэгтээр харуулж энэхүү хэсгийг дуусгаж байна. Энэ нь нөлөөллийн замын төвөгтэй байдлыг харуулж байгаа боловч нөхцөл шалтгааных нь хүчин зүйлсийг харуулахгүй бөгөөд хувьчлалын үйл явцад үнэлгээ хийхэд тус болох юм. Энэ нь Бирдсалл, Неллис нарын хэлснээр “хуваарилалтын үр нөлөөнд дүн шинжилгээ хийх боломжтой бол үндэсний түвшинд хийх нь хамгийн сайн арга зам байдаг” (Бирдсалл ба Неллис, 2002, хуудас 26).



5. Олон улсын жишээ, туршлага

Хувьчлалыг гол төлөв хоорондоо зөрчилдсөн олон зорилтуудад хөтлөгдөн төлөвлөж явуулдаг.

Зах зээл хөгжсөн орнуудад эдийн засаг болон итгэл үнэмшлийн зорилгоор өмч хувьчлалыг явуулах нь олонтаа. Эдийн засгийн зорилгод үр ашгийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, улсын мэдлийн өмч хөрөнгийг зарж борлуулснаас ашиг олох, улмаар улсын секторын санхүү төсвийг чадавхжуулах зэргийг оруулна. Итгэл үнэмшлийн зорилгод төрийн үүрэг оролцоог багасгах, улсын сектор дэх үйлдвэрчний эвлэлүүдийг сулруулах зэрэг багтана. Бага орлоготой орнуудад макро эдийн засгийг тогтворжуулах, ялангуяа улсын төсөв санхүү, төлбөрийн балансыг тогтворжуулах, борлогдох чадвартай бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбар болгон өөрчлөхөд чиглэсэн дахин хуваарилалтыг хийх замаар дотоодын эдийн засгийг чөлөөлөх, төрийн хатуу хяналтаас гаргахад чиглүүлэн хувьчлалыг явуулдаг. Шилжилтийн үе шатанд байгаа орнуудад хувьчлалыг дээр дурьдсан зорилгоос гадна зах зээлийн эдийн засгийг хэвшүүлэхэд чухал хөшүүрэг болгон ашиглах зорилгоор явуулдаг.

Улс орнууд, бүс нутгууд дах өмч хувьчлал маш ялгаатай явагддаг. Тухайлбал өмч хувьчлалыг явуулж буй зорилго нь харилцан адилгүй байхаас гадна өмч хувьчлалын хамрах хүрээ, явц, хурд, хэрэглэж буй арга хэрэгсэл, хувьчлалын дараах өрсөлдөөн өрнөх болон зохицуулалт хийх орчин хоорондоо адилгүй байдаг. Бага орлоготой болон шилжилтийн орнууд өмч хувьчлалын эхний шатанд хөдөө аж ахуйн жижиг ахуй, үйлдвэр, хөнгөн үйлдвэр, үйлчилгээг хамруулдаг. Гэвч 1980-аад оны сүүлд ялангуяа дэд бүтцийн салбар дах улсын том үйлдвэр аж ахуйнуудыг гадны хөрөнгө, үнэт цаасанд тулгуурлан хувьчилсан арга хэмжээ нь өмч хувьчлалаас олж байсан нийт орлогын талаас илүү хувийг бүрдүүлж байв. (Латин Америкт ийм орлого улсын өмч хөрөнгийг зарж борлуулснаас олж байсан ашгийн 60 гаруй хувийг бүрдүүлж байв) (Киркпатрик, 2002, х.121).

Шилжилтийн орнуудад явуулж буй өмч хувьчлалын үйл явц, гарах үр дүн ч хоорондоо асар их ялгаатай байна. Дотоодын болон гадаадын капиталд зарсан хөрөнгийн борлуулалтын баланс ихээхэн тэнцвэргүй байна. Дотоодын капитал хомс, хүрэлцэхгүй байгаа нөхцөлд олон орон чөлөөт хуваарилалтын загварыг сонгон авсан (маш тодорхой жишээг Лавинье, 1995, х.165-д харна уу). Энэхүү загвараар ваучер, тасалбарыг тараах эсхүл хөрөнгө оруулалтын сан эсхүл хувьцаат компанид хувьцааг хуваарилах хувилбаруудыг ашиглана. Чех, Словак, Румын, Болгар, Польш, Орост энэ загварын хувилбаруудыг ашигласан ба Польш, Унгар зэрэг хэд хэдэн оронд **ГЭНЭТИЙН** хувьчлалыг явуулж удирдах албан тушаалын хүмүүс нь үйлдвэр аж ахуйгаа хувьчилж авсан байна. Орос зэрэг оронд үйлдвэр аж ахуйн

гзрууд өөрсдөө хувьчлалыг санаачилж, мэдээллийг зөвхөн өөрсдийн хүрээнд давуу эрхтэйгээр хүртэж байсан нь ийм **ГЭНЭТИЙН** хувьчлал явагдах нөхцлийг бүрдүүлжээ (Лавинье, 1995, х.169).

Тэгвэл Монгол улс дах өмч хувьчлал нь ядуурал болон орлогын хуваарилтанд хэрхэн нөлөөлснийг илүү сайн мэдэхийн тулд өмч хувьчлалын талаарх бусад орны ямар туршлагаас сургамж авах вэ? Бусад орны туршлагыг доор дүгнэснийг толилуулья.

- Өмч хувьчлалын хувиарлалтанд үзүүлсэн үр нөлөөнд харьцангуй бага анхаарчээ (Раманалхам, 1995, Бүлэг 14-т Филиппин, Тайланд, Бангладеш, Нигерт хийсэн case study-ийн талаар дурджээ); Өмч хувьчлалыг ил тод зарчимтай улам нягт холбосноор энэ асуудалд зүй ёсоор анхаарал тавих болно;
- Үйлдвэр аж ахуйг хувьд шилжүүлснээр үйл ажиллагаа нь ерөнхийдөө сайжирдаг. Гэхдээ бүр эсрэгээр эргэж дордсон тохиолдлууд бий (Бэрдсал, Неллис, 2002, х.12);
- Бага орлоготой болон шилжилтийн орнуудад өмч хувьчлалыг явуулахад илүү бэрхшээлтэй бөгөөд хурдан хугацаанд сайн үр дүн нөлөө үзүүлэх магадлал бага байдгийг бодит жишээ харуулж байна (Бэрдсал, Неллис, 2002, х.12);
- Хөрөнгийн өмчлөлийн үр дүнд урам хугарах, түвэгтэй байдалд орох явдал цөөнгүй гарч байв. Орос, Чех, Молдав, Казакстан, Литва, Монгол зэрэг оронд хувьцаа эзэмшсэнээр орлогын түвшин доройтоогүй боловч хувьцаанаас олох ашиг нь санасан эсвэл амласан хэмжээнээс бага байсанд хүмүүсийн урам хугарч, харин эд баялгийн ихэнхийг сэргэлэн “овсгоотой” буюу “шударга бус арга хэрэглэсэн цөөнх завшсан байна (Бэрдсал, Неллис, 2002, хх.18-19). Шилдэг сайн ажилллагаатай компани үйлдвэр аж ахуйг хувьцаа олгох замаар бус, харин дарга, удирдагч, тэднийг дэмжигчдийн бүлэгтэй нууцаар тохиролцон ил тод бус замаар хувьчилжээ.
- Хувьчлалын хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөөг авч үзвэл, хувьчлалаар олон хүн ажилтай болох бус харин ажлын байрнаас хагацаж ажилгүйчүүдийн эгнээнд шилжсэн (ийм байдал ялангуяа нүсэр орон тоотой ажиллаж байсан улсын үйлдвэрүүдэд их гарсан).
- Үнэ, хүртээмжийн хувьд, Нийтийн аж ахуйн үйлчилгээг хувьчилснаар сүлжээ нь өргөжиж, хүн амд, ялангуяа хот суурин газрын ядуу хүн амд хүрч үйлчлэх хүртээмж сайжирсан боловч үнэ өртгийн хувьд өссөн.
- Хувьчлалын санхүүгийн үр нөлөөний хувьд, өмч хувьчлалаас олох ашиг орлогыг төсөвт оруулан хэмнэлт гаргана, өөрөөр хэлбэл орлого зарлагын тэнцлийг барихад зарцуулах хөрөнгийн алдагдлыг багасгана (Барнет, 2000). Бэрдсал, Неллис нар (2002) ядуу орнуудад татварын систем голдуу үр ашиг муутай ажилладаг тул хувьчлалыг явуулснаар алдагдалтай ажиллаж байсан улсын үйлдвэрүүдийн тоог бууруулах замаар татвараа бууруулах (гэхдээ л бараг амжихгүй биз) эсхүл олсон ашгаа илүү үр дүнтэй зүйлд зарцуулах зэргээр шууд бус эерэг нөлөөг бий болгодог гэж үзэж байна. Түүнчлэн шинээр хувьчлагдсан үйлдвэр аж ахуйн төлөх татварын

хэмжээ нэмэгдэж төсвийн орлогыг сайжруулан төсвийн орлого зарлагын харьцаанд эерэгээр нөлөөлж болох юм.

Бэрдсал, Неллис нарын үзэж байгаагаар (2002) өмч хувьчлал ихэвчлэн тэгш байдлыг бус харин үр ашгийг нэмэгдүүлэхэд нөлөөлжээ. Тэрээр эхэн үедээ эд баялаг болон орлогын хуваарилтанд сөрөг нөлөө үзүүлсэн. Эд хөрөнгө харьцангуй чинээлэг хэсгийнхэнд шилжсэнээс үүдэн эд баялгийн хуваарилтанд сөрөг үр дагавар гарч, харин үнэ, цалинд хөдөлгөөн орсноор /өөрчлөгдсөнөөр/ орлогын хуваарилтанд муу нөлөө үзүүлнэ. Гэхдээ дээр дурьдсанчлан эд хөрөнгө орлогын эх үүсвэрийг бүрдүүлж цаашилбал тэгш бус байдлыг гүнзгийрүүлж болох талтай.

Дээрх дүгнэлтүүд зөвхөн тодорхой улс орон, тогтолцоонд хамааралтай юу? Бэрдсал, Неллис нар (2002) хуучин ЗХУ, Зүүн Европын орнуудын (Тухайлбал, Орос, Чех улсын) туршлагад үндэслэн хувьчлал, орлого хувиарлалтын талаарх дүгнэлтүүдээ гаргасан тул нийт бүх улсад хамааруулан авч үзэж болохгүй гэж зөвлөж байна. Үүнтэй бүрэн санал нийлж байгаа хэдий ч Монгол оронд явагдсан хувьчлал болон дээрх хоёр орны хувьчлалын хооронд нэлээд нийтлэг зүйл байгааг харгалзан үзэж энэ гурван орны туршлагыг судлан чухал сургамжуудыг авах нь хэрэгтэй алхам болох юм.

Энэ хэсэгт чухал дүгнэлт хэсгүүдийг дахин тодруулан дурьдая.

Юуны өмнө, бид бүхэн бодитой жишээ баримт байхгүй тохиолдолд тухайн оронд явагдсан өмч хувьчлалыг ядуурал, тэгш бус байдал өсөн нэмэгдэж байгаатай нь шууд холбон авч үзэхэд болгоомжтой няхуур хандах ёстой. Орлогын хувиарлалтын өөрчлөлт болон ядуурал нь бусад шинэчлэлийн арга хэмжээ, бодлогын өөрчлөлтийн үр дүнд гарсан байж болох юм.

Хоёрдугаарт, зарим жишээ баримтаас харахад өмч хувьчлалын хэмжээ, хурд бус харин мөрдөж ашигласан аргачлал, өмчийн шинэ эздийн өөрсдийнх нь хандлага, үйл ажиллагаа, зах зээлийн шинэчлэлийн бусад үйл явцын дараалал, эрч хүч, өмч хувьчлалын өмнөх болон тухайн үе шатанд үйлчилж байсан зохион байгуулалт бүтцийн чанар зэрэг хүчин зүйлүүд орлогын хуваарилтанд сөргөөр нөлөөлсөн байж болох талтай (Бэрдсалл, Неллис, 2002, хх.24-25). Иймд хууль, шүүхийн тогтолцооны үйл ажиллагаа, хүртээмж, үнэн шударга байдал, хөрөнгийн зах зээлийн бүтэц, зохистой зохицуулалт, төлбөрийн чадваргүй болох болон дампуурлын нөхцөл байдлыг зохицуулах дүрэм журам, монополь эрхийг хэтрүүлэн ашиглах явдлаас сэргийлэх, зохицуулахад төр чадавхитай байх нь маш чухал зүйл юм (Жанков, Муррел, 2000, Бэрдсалл, Неллис, 2000-д харуулснаар).

Гуравдугаарт, хэрвээ энэ үнэхээр үнэн юм бол (Барнетийн үзэж буйгаар, 2000) өмч хувьчлал нь макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулж, ДНБ-ний бодит өсөлтийг

ханган, орлого, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэн ядуурлыг бууруулахад нааштайгаар нөлөөлж байгааг нотолсон бодитой жишээ баримт болж байна гэсэн үг бөгөөд өмч хувьчлалын үр нөлөөнд үнэлгээ хийх үе хугацаа ч ихээхэн чухал хүчин зүйл болох юм. Бэрдсал, Неллис хоёр (2002) Чех, Польш улсын эдийн засаг буюу эд баялгийн хувиарлалтанд гарсан өөрчлөлт, үүнтэй холбоотойгоор эдийн засгийн шинэчлэл зөв замаар явж байгаа эсэх талаар хүмүүс өөр өөр бодол санаатай байгааг онцлон тэмдэглэжээ. Өмч хувьчлал явагдсан хугацаанаас хойш яг хэдий үед тэгш буй байдал, ядууралд түүний үзүүлсэн нөлөөг үнэлж эхлэх вэ?

Дөрөвдүгээрт, бодит жишээнээс үзэхэд өмчлөл бус харин өрсөлдөөнт зах зээлийн бүтэц үйлдвэр аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, хэрхэн амжилттай ажиллахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг байна. Зарим үйлдвэр аж ахуйн нэгж болон зарим эдийн засгийн салбар улсын секторын эзэмшилд байхдаа бүтээмж, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд чиглэсэн зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлт хийх хөрөнгө нөөц байхгүй байж болох юм. Гэвч ерөнхийд нь дүгнэж хэлэхэд үр ашгийг нэмэгдүүлэхэд өмчлөлийн хэлбэр бус харин зах зээлийн бүтэц илүү үүрэгтэй гэдгийг нотлон харуулсан онол, бодит жишээ аль алиныг нь хайхрахгүй байж болохгүй юм.

Тавдугаарт, зах зээл хэвшсэн эдийн засаг дах өмч хувьчлал нь шилжилтийн үеийн өмч хувьчлалаас эрс ялгаатай. Эхний тохиолдолд зах зээл, бүтэц зохион байгуулалт аль аль нь бүрэлдсэн байхад шилжилтийн үйл явцад дөнгөж үүсэх, хөгжих үе шатандаа байдаг. Өмч хувьчлал өөрөө зах зээл, түүний бүтцийг бий болгодоггүй бөгөөд Стиглиц (2002) болон бусад хүний үзэж буйгаар зохистой зохион байгуулалт бүтцийн дэд бүтэц байхгүй нөхцөлд өмч хувьчлал нь хүсэн хүлээсэн үр дүн, ялангуяа эдийн засгийн өсөлтийг хурдасгах үр дүнд хүргэдэггүй. Эндээс харахад үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого нь стратегийн хувьд асар ач холбогдолтойг нотолж шилжилтийн үеийн бүхий л шатанд төрийн үүрэг оролцоо (ялангуяа, зах зээлийн бүтэлгүйтлийг даваг туулахад) байх хэрэгтэйг анхааруулж байгаа юм.

Зургаадугаарт, Польш, Чех зэрэг нэлээд хэдэн орон хувчлагдсан үйлдвэр аж ахуйн хувьцааг өргөн хүрээнд эзэмшүүлэхэд чиглэсэн **нийтийн капитализмын** үзэл бодлыг баримталсан (энэ нь адаглаад далд хэлбэрээр Монгол улсад хэрэгжсэн билээ). Дээр дурдсанчлан өмчлөх эрхийн бичиг эсхүл хувьцааг олгох нь өмч хувьчлалыг түргэтгэж үйлдвэр аж ахуйн нэгжийн хөрөнгийг үнэлэх, худалдаж авахад хувийн хуримтлал хөрөнгө дутагдах зэрэгтэй уялдан гарах бэрхшээлт асуудлыг шийдвэрлэн шилжилтийн үйл явцыг эргэж буцалтгүй болгох арга зам болдог. Гэтэл Босын мэтгэж буйгаар (1995, х.64, Раманадхам) **“Нийтийн капитализм** гэдэг нь дахин хуваарилалтын үр ашигтай хэлбэрүүдэд тохирохгүй арга хэрэгсэл болдог (өөрөөр хэлбэл баячуудаас авч ядуучуудад өгнө гэсэн үг). **Нийтийн капитализм** нь харин дахин хувиарлалтын үр ашиггүй хэлбэрт зохицсон арга хэрэгсэл байж болох юм (өөрөөр хэлбэл тодорхой сонирхлын бүлгийн эрх

ашигт үйлчлэх)”. Тэрээр өмч хувьчлал нь орлогын хувиарлалт, ядууралд ихээхэн нөлөөлдөг бөгөөд эрч хүчтэй, өрсөлдөх чадвартай хувийн хэвшлийг хөгжүүлэх дан ганц баталгаат арга болж чадахгүй гэж үздэг. Ялангуяа өмч хувьчлалын эрхийн бичиг буюу ваучер хувиарлан олгох нь хувьчлалын дараах үе шатанд үйлдвэр аж ахуйн нэгжийг өөрчлөн зохион байгуулахад шаардагдах санхүүжилтийг эх үүсвэрийг баталгаажуулах, бүтээмж, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн технологи, мэдлэг мэргэшилтийг нэвтрүүлэх баталгаат арга болдоггүйгээс гадна хамтын засаглалын асуудлыг (хөрөнгө оруулалт үр дүнтэй байх зарим онцгой нөхцлөөс бусад үед) үр дүнтэй шийдвэрлэж чаддаггүй.

Ярьсан хэлэлцсэн зүйлээ дүгнэж үзье. Орлогын тэгш бус байдал (Жини коэффициентээр хэмжигддэг) хувьчлалын дараах үе шат болон шилжилтийн үед улам гүнзгийрсэн байна. Чех, Унгар, Словени зэрэг зарим оронд орлогын тэгш бус байдал нэлээд гүнзгийрсэн байхад Орос, Таджик, Армени улсад (Бэрдсал, Неллис, 2002, х.24) орлогын ялгаа асар их болсон. Гэвч хувьчлалын талаар бидний өнөөгийн мэдлэг нь тэгш бус байдлыг нэмэгдүүлэхэд өмч хувьчлал ямар нөлөө үзүүлсэн, ямар үүрэг рольтой байсныг нарийвчлан тодорхойлж хэлэхэд хангалтгүй байна. Түүнчлэн өмч хувьчлал нь орлого хувиарлалтын явц төлөв байдлыг тодорхойлохгүй. Грийниж (1995, х.263) огт өөр орны жишээн дээр тулгуурлан (Гуяана) ингэж дүгнэжээ: “[Өмч хувьчлал нь]...цаг хугацаа болон зорилтоос хамааран орлогын хувиарлалтанд нэг бол нааштай эсхүл сөрөг нөлөө үзүүлнэ, гэхдээ түүний эцсийн дүр зураг төлөв байдалд эдийн засгийн бодлого, гадаадын өрсөлдөгч нартай харьцуулахад хувийн хэвшлийн чадавхи хэр байна, дотоодын болон гадаадын түнш, засгийн газартай хир хэрхэн хамтран ажиллаж байгаа зэрэг чадвар чадавхи нөлөөлнө”.

Ядуурал болон орлогын тэгш бус байдал нь хоорондоо нягт холбоотой боловч хоёр өөр тусдаа ойлголт юм. Олон улсын жишээ баримт нь өмч хувьчлал нь хувиарлалтанд хэрхэн нөлөөлсөн тал дээр түлхүү анхаарсан байна. Харин өмч хувьчлал нь ядууралд хэрхэн нөлөөлсөн талаар тун бага судалжээ. Энэ талаар судалсан цорын ганц хүн буюу Бэйлис нийтийн үйлчилгээний хувьчлал, тэр нь ядууралд яаж нөлөөлснөөр хязгаарласан хүрээнд судалжээ (2000). Гэвч цаашид судалж болох чиглэлийг тогтооход ашиглаж болох нийтлэг асуудлууд байна.

Өмч хувьчлалын ядууралд үзүүлсэн нөлөө орлогын хувиарлалтанд үзүүлсэн нөлөөний адил эдийн засгийн өсөлт, хувийн хэвшлийн хөгжил, санхүүгийн өсөлт, үйлдвэр аж ахуйн үйл ажиллагаа сайжрах, өмч хувьчлалыг явуулах нөхцөл хангагдмагц хоёр талт болон олон талт тусламжийн хөтөлбөрийн нэг хэсэгт хамруулан дэмжлэг үзүүлэх зэрэг сайн талуудтай байхын зэрэгцээ сөрөг нөлөө мөн үзүүлдэг байна. Сөрөг нөлөөнд хувийн үйлдвэр аж ахуй нь зөвхөн ашиг харан үйл ажиллагаа, салбараа сонгох, үнэ, ажил эрхлэлтэнд таагүй байдал

үзүүлэх, хувьчлалын дараах үе шатанд бүтэц зохион байгуулалт, удирдан хянах чадавх сул байх, өмч хувьчлалыг танил тал, авилгал харан явуулснаар ядуу хүн амын ашиг сонирхлыг тэр болгон төлөөлж чаддаггүй, ашиг сонирхлын бүлгүүдэд эдийн засаг, улс төрийн эрх мэдлийг төвлөрүүлэх зэрэг үр дагаврууд байж болно (ийм санааг Кук, Киркпатрик нар мөн хэлж байв, 1995).

Бэйлис (2000, х.17) өмч хувьчлал нь ядууралд цогц нөлөө үзүүлж байж болох юм гэж дүгнэснийг нийтээрээ хүлээн зөвшөөрч байгаа билээ. Харин бодлогын үзэл баримтлалын үүднээс түүний хэрхэн дүгнэснийг дурдья:

“Үнэхээр л бодитой бодлого гаргаж хэрэгжүүлье гэж байгаа бол түүнийг анхдагч түвшинд нь эргэн харж үзэх хэрэгтэй. Ядуу хүн амын эрх ашгийн төлөө үйлчлэх талаар хуучин дурьдсан зүйлээ өөр шинэ хэллэгээр илэрхийлэх явдлыг бодлого гэдэггүй. Ерөнхийлөн нэг аргачлалаар явуулж буй өмч хувьчлалын оронд ерөнхий зорилтын хүрээнд тухайн тохиолдол байдал бүрд уялдуулсан өмч хувьчлалыг явуулах хэрэгтэй (үйлчилгээг бүх нийтэд хүргэх гэх мэт). Ерөнхий зорилтын хүрээнд олон хувилбарыг харгалзан үзэж шүүн тунгааж сонголт хийх нь ядуу хүн амын эрх ашгийг хамгаалахад илүү тохиромжтой арга байж болох юм. Өмч хувьчлал нь эдгээр олон хувилбарын нэг боломжит хэлбэр бөгөөд төрийн шинэчлэл, корпорацжуулалт нь бусад боломжит хувилбар юм. Энэ нь ядуучуудын хэрэгцээг хангах илүү тохиромжтой арга ч байж болно.

Энэ бүхнийг ярихын гол учир нь бид өмч хувьчлалыг эцсийн зогсоол гэж үзэж байна уу эсхүл бусад зорилтонд хүрэх арга хэрэгсэл гэж үзэж байна уу гэдгийг тунгаан бодож шийдвэр гаргахад оршино.Түүнийг эцсийн зогсоол гэж үзэж байгаа бол өөрөөр хэлбэл өмч хөрөнгийг улсын сектороос хувийн хэвшил рүү шилжүүлэх хэрэгсэл гэж үзэж байгаа тохиолдолд бол хялбар байдал, хурдан шинжийг гол шалгуур болгон өмч хувьчлалын явцад мөрдөх ёстой.

Харин өмч хувьчлалыг улам бүр өсөн хөгжиж буй зах зээлийн эдийн засгийн нөхцөлд эрч хүчтэй, өрсөлдөх чадвар бүхий хувийн хэвшлийг хөгжүүлэхэд хүрэх арга хэрэгсэл гэж үзэж буй тохиолдолд бүхэл бүтэн цогц хүчин зүйлүүдийг сайтар харгалзан хооронд нь уялдаатай авч үзэх хэрэгтэй. Үүнд цаг хугацаа, дараалал, өмч хувьчлалын дараах үе шатны зохицуулалт, өрсөлдөөнт орчин, хамтын засаглал, өмчийн эзний үйл ажиллагаа, хандлага, тоног төхөөрөмж, зохион байгуулалт бүтцийг шинэчлэхэд зарцуулах хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын зардал, шинэ технологи, мэргэшил мэдлэг, зах зээл, урамшууллын бүтцийг зохистой ажиллуулахад чиглэсэн засгийн газрын бодлого, зах зээлийн бүтэлгүйтлийг залруулахад болон үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллагуудыг чадавхжуулахад тусламж дэмжлэг үзүүлэх бүтцийг бий болгох зэрэг цогц асуудлууд улам

илүү ач холбогдол, үүрэгтэй оролцоно (Лал, 1991). Энэ тохиолдолд тооноос илүү чанарыг эрхэмлэнэ.

Энэ үүднээс үзэхэд тодорхой нөхцөл байдалд өмч хувьчлал нь үр дүн муутай байж болох юм. Үр дүнтэй зохион байгуулалт бүтцийн хүрээ тогтоогүй, төр нь сул дорой, гадаадын хөрөнгө, технологи хомс, үйлдвэр аж ахуй эрхлэгчдийн эгнээ өргөжөөгүй, хөгжөөгүй, төр засгийн байгууллагуудаас энэ чиглэлээр зохих дэмжлэг үзүүлэхгүй байгаа, олон нийтийн дунд өмч хувьчлалын талаар таагүй ойлголт, үзэл хандлага зонхилж байгаа нөхцөлд (танил тал, авилгалтай холбон үзэх зарим хандлагын улмаас) хөгжлийн зорилтууд, түүн дотроо ядуурлыг бууруулах зорилтуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл учруулах болно.

6. Түүвэр Судалгаа

Ядуурал, тэгш бус байдалд өмч хувьчлалын үзүүлсэн нөлөөг судлах зорилгоор хийгдсэн хэд хэдэн судалгааг НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр явуулсан байна. Нийгмийн Хөгжлийн Төв мал хувьчлал болон орон сууцны хувьчлалын талаарх оролцооны аргын 2 судалгаа, Монгол Улсын Үндэсний Их Сургууль орон сууц болон жижиг дунд үйлдвэр, аж ахуйн газруудын хувьчлалын талаарх түүвэр судалгааг тус бүр явуулжээ. Эдгээр дөрвөн судалгааны гол дүгнэлтүүд болон тэдний талаарх санал бодлыг дор танилцуулья.

Мал хувьчлалын талаарх оролцооны аргын судалгаа

1991-1993 онд явагдсан мал болон мал аж ахуйн холбогдолтой эд хөрөнгийн хувьчлал бэлэгдлийн болон амьдрал ахуйд бодитой нөлөөний аль алиныг агуулсан нэлээд ач холбогдолтой арга хэмжээ болсон боловч хэрхэн явагдсан талаар бодитой нарийвчилсан мэдээлэл хомс байгаа юм. Ийнхүү мэдээлэл хомс байгааг хэд хэдэн шалтгаанаар тайлбарлаж болно. Үүнд хөдөө аж ахуйн нэгдэл, хоршооллын гишүүдэд мал хувьчлан өгөх ерөнхий зарчмын шинжтэй шийдвэрийг их хурлаас гаргаж, харин малыг хэрхэн яаж хэнд хувиарлан олгох аргаа нэгдэл хоршоод өөрсдөө шийдэн хувьчлалыг явуулж, ингэхдээ энэ талаар нэг бүрчлэн нарийвчилсан бүртгэл хийн нэгтгээгүй байна. Ялангуяа мал хувьчлалын талаарх мэдээллийг хувь хүмүүс, айл өрх тус бүрээр нарийвчлан гаргаагүй байна. Түүнчлэн Монгол улсын шилжилтийн үеийн эхэн жилүүдэд өмч хувьчлалын салхийг хагалж хамгийн түрүүнд явагдсан мал хувьчлалаас хойш эдүгээ 10 гаруй жил өнгөрчээ. Энэ мэтчилэн шалтгааны улмаас мал хувьчлалын талаар зохих дүгнэлт үнэлгээг өгөх, тэр тусмаа ядуурал, тэгш бус байдалд хэрхэн нөлөөлсөн талаар тодорхой дүгнэлт үнэлгээг өгөхөд туйлын хүндрэлтэй байгаа юм. Ямар ч гэсэн мал хувьчлалын нөлөө, үр дүн харилцан адилгүй ихээхэн өөр өөр байж болох юм.

Иймд тоо мэдээллийн хоосон орон зайг нөхөх хамгийн тохиромжтой аргаар оролцооны аргын судалгааг сонгон авчээ. НҮБХХ-ийн санхүүжилттэйгээр Нийгмийн Хөгжлийн Төв мал хувьчлалын талаарх оролцооны аргын судалгааг явуулж, хүн амын суурьшил, тархац, малын тоо толгой, ядуу болон нэн ядуу өрхийн тоо зэрэг жишиг үзүүлэлтийн дагуу Архангай, Төв, Замхан аймгуудаас тус бүр гурван сумыг сонгон авч хамруулжээ. Сум тус бүрд ярилцлагын арга ашиглан судалгааг авсан бөгөөд тус судалгааны гол дүгнэлтүүдийг дор танилцуулж байна.

1991-1993 онуудад явагдсан мал хувьчлалаас өмнө тодорхой нөхцөл болзлын дагуу малчидтай гэрээ байгуулж, гэрээнд заасан тооноос илүү гарсан малыг малчдад өөрсдөд нь үлдээх зэргээр малчид хөдөлмөрөө зохих ёсоор үнэлүүлсэн хагас хувьчлалын шинжтэй үйл ажиллагаа явагдаж байжээ. Иймд зарим малчин ийм зууч үйл ажиллагааг малыг бүрэн хувьчлах аргаар яаран халж сольсон гэж шүүмжлэлтэй хандаж байв. Судалгаанд оролцогсдын олонх нь мал хувьчлалыг хэтэрхий түргэдсэн арга хэмжээ болсон гэж үзэхийн сацуу энэ талаарх мэдээлэл ойлголтыг өгөхөд хангалттай анхаараагүй, мал хувьчлал нь нийгэм эдийн засгийн ямар үр дагавар гаргахыг урьдчилж сайн тооцоогүй гэж хариулжээ.

Мал хувьчлалыг хувьцааны буюу эрхийн бичгийн системээр явуулсан /хувьцааны/. Хэдийгээр засгийн газраас нэгдэл хоршооллууд малаа хувьчлах арга замыг өөрсдөө сонгохыг зөвшөөрсөн шийдвэр гаргасан боловч мал, хөрөнгийг тэгш бус хувиарлан хувьчилсан явдал нэлээд гарсан байна. Хувьцаагаар мал хувьчлах болон малын хашаа, хороо худаг мэт хөрөнгийг хувьчлахад хоёр аргыг ерөнхийд нь мөрдөн хэрэгжүүлсэн шиг байна. Эхний аргаар хувьцаа эзэмшигч сумын иргэд, нэгдлийн гишүүд, тэдний гэр бүл, нэгдлийн салбар аж ахуйд ажиллагсад болон зарим сумын захиргааны ажилтан хувьчлалд оролцсон. Энэ аргыг нийтээрээ шударга арга гэж хүлээн зөвшөөрч байхад хоёрдогч аргыг тийм ч шударга бус гэж үзэж байгаа юм байна. Хоёрдогч аргаар мал болон малын хашаа, хороо зэрэг эд хөрөнгийг урьд нь хэрхэн хувиарласан байдалд нь үндэслэн нэгдлийн идэвхтэй гишүүдэд олгон хувьчилж харин олон жил нэгдэлд хүч хөдөлмөрөө өгч байсан зарим тэтгэврийнхэн, нэгдэл байгуулагдахад малаа анх нийгэмчилсэн хүмүүс болон хүүхэд, сурагчид оюутнууд хувьчлалын гадуур үлдсэн.

Мал хувьчлалыг явуулахад мөрдсөн засаг захиргааны үйл явц ерөнхийдөө жигд сайн явагдсан гэж үзэж байна. Гэхдээ жижиг алдаанууд их гаргасан. Тухайлбал гишүүдийг бүртгэлд хамруулаагүй, хувьцаа олгоогүй, хүүхдүүдийн мал хувьчилж авах эрхийг бүртгээгүй зэрэг илэрхий алдаанууд мал хувьчлалын талаарх мэдээлэл хязгаарлагдмал байсан тохиолдлууд гарч, мал хөрөнгө хувиарлан олгоход өрөөсгөл хандлага гаргажээ.

Гэхдээ судалгаанд оролцогсод хүн амын нягтралыг мал сүргийн тоо толгойд харьцуулан энгийн арифметикийн аргаар хуваан явуулсан нь тэгш бус хувиарлалт гаргахад хүргэсэн

гэж үзжээ. Тэрчлэн, хувь хүн бүрт хувьчилсан нь янз бүрийн тооны ам бүлтэй гэр бүлүүд тэгш бус байдлаар хувьчлалд оролцоход хүргэжээ.

1991-1922 онд улаан тасалбараар мал хувьчлах ажлыг эхлүүлж, түүний дараагаар цэнхэр тасалбараар нэгдэл хоршооллын том оврын хөрөнгө, аж ахуйн нэгжүүдийг хувьчилсан. Ингэхдээ нэгдэл хоршооллын хуучин удирдлагын гаргасан төлөвлөгөөний дагуу нэгдэл хоршооллын гишүүд хамтран оролцож хөрөнгө, аж ахуйн нэгжүүдийг хувьчлан авахад чиглүүлсэн байна. Гэвч 1990-ээд оны эхээр шинээр бий болсон нөхцөл байдалд ихэнх аж ахуйн нэгж компаниуд сайн ажиллаж чадахгүй байсан энэ үед дээрх хувьчлал амжилттай үр дүнд хүрсэнгүй. Эдгээр аж ахуйн нэгж компаниуд хувьцаа эзэмшигч эзэд нь хөрөнгө мөнгөө хоорондоо хувааж авснаар тарж бутран алга болсон байна.

Хувьцаа эзэмшигчид хувьцаагаа татан авч, нэгдэл хоршооллоос шилжиж ирсэн эд хөрөнгийг задлан хувь хувьдаа хуваан авах замаар шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж компаниуд тарж бутрахад хүргэсэн байна. Гэхдээ зарим томоохон хөрөнгийг эхлээд сумын удирдлагад хариуцуулан өгч дараа нь хувьд шилжүүлэх замаар сэмхэн хувьдаа авч байсан талаар судалгаанд оролцогсод ярьж байв. Энэ нь хэдхэн хүн хувьчлагдах эд хөрөнгө, тэдний үнэ өртгийн талаар мэдэж ийм цэвэрхэн далд аргаар өмчтэй болж байсан гэсэн үг. Ер нь энэ хувьчлалыг тэгш бус явагдсан гэж судалгаанд оролцогсод санал нэгтэй хэлж байв.

Нэгдэл хоршооллын барилга байшин хуучирч муудан эвдэрч, аж ахуйд нь сүйрсэн; үйлдвэрлэл үйлчилгээ нь зогсож, ажилгүйдэл, ядуурал бий болов. Нэгдэл хоршооллоор дамжуулан үзүүлж байсан боловсрол, эрүүл мэнд, ахуй соёлын олон үйлчилгээ алга болсон нь амьжиргааны түвшин төдийгүй чанарт ч том цохилт болсон. Судалгаанд оролцогсдын үзэж буйгаар сайтар үндэслэлтэй судалж, эдийн засаг нийгмийн үр дагаврыг урьдчилж сайн тооцолгүйгээр хувьчлалыг явуулсан байна.

Мал хувьчлалын үндсэн арга хэмжээг явуулснаас хойшхи 10 жилийн хугацааг 1993-1998 болон 1998-2003 гэж хувааж үзье. Эхний жилүүдэд малын бүтээгдэхүүний үнэ өсч, малын тоо толгой дөрөвний нэг хувиар нэмэгдэн шинэ малчдын ихэнх нь харьцангуй чинээлэг амьдралд хүрчээ. Түүнчлэн хотод бий болсон аж үйлдвэрийн уналттай холбоотойгоор мал маллах арга туршлагагүй хотын ядуучууд хөдөө очиж суурьшин малчдын тоо үлэмж нэмэгдэж мал аж ахуй нь шилжилтийн эхэн үеийн эдийн засгийн гол салбарыг төлөөлж байв. Ийнхүү, үнэ, бүтээмжийн аль аль нь буурсан. Харин 1998 оноос хойшхи хугацаанд цаг агаар хүндрэн зуд, ган тохиолдож, түүний сацуу малын бүтээгдэхүүний үнэ унасан нь цөөн малтай малчдын амьжиргааг үлэмж доройтуулж, нийт улсын түвшинд малын тоо толгой буурах үр дагаврыг авчирсан.

Хэдийгээр ийм үр дагавар гаргахад цаг агаарын хүндрэл шууд нөлөөлсөн боловч өмч хувьчлал нь эдгээр бэрхшээлийг дордуулахад нөлөөлсөн байж болох талтай. Судалгаанд оролцогсдын санаа бодол 3 дугаар хэсэгт дурдсан Миллер (он саргүй) болон бусад хүний мэдэгдлийг баталж байсан. Энэ талаар судалгаанд оролцогсод ийнхүү ярьж байна. Өмч хувьчлал явагдсаны дараа мал аж ахуйн чиглэлийн үйлчилгээ, тусламж анхаарлын гадуур орхигдож, олон малчин ялангуяа цөөн малтай малчид мал маллах, арчлах туршлага багатай байсан боловч нэгдэл хоршоолол тарснаар тэдэнд ийм арга туршлагыг түгээх боломж байхгүй болсон. Түүнчлэн хөдөлмөрөө хамтатгаснаар улам мэргэшиж төрөлжин ажиллаж байсан үр чадвар алдагдаж, хөдөлмөрийн үр ашигтай хувиарлалт утсан.

Өмч хувьчлалын үр дүнд нийтийн суурь үйлчилгээ устах буюу үлэмж хорогдсон. Судалгаанд оролцогсод худаг, малын хашаа саравчийн дийлэнх нь эвдэрч сүйрсэн талаар ярьж байв. Малын тэжээлийн техник хэрэгслийг хувьчилсан тул тэжээл бэлтгэлийн ажил үлэмж багасч, тэжээл ховордохын зэрэгцээ хуучин нэгдэл хоршооллын үед үзүүлж байсан мал үржүүлэг зэрэг мал эмнэлгийн үйлчилгээ бараг зогссон нь хээл хаях, үржил шим буурах, сайн үүлдрийн мал устаж алга болох сөрөг үр дагаврыг авчирсан. Түүнчлэн малын сүргийн бүтэц өөрчлөгдөн, ноолуурын үнэ өссөний улмаас малчид ямаа голлон маллах болсон нь бэлчээрийг доройтуулах нэг гол шалтгаан болж байна. Нэгдэл, хоршоодын үед бэлчээрийг доройтуулахгүй байх талаар дотооддоо шийдвэрлэн зохицуулж чадаж байсан билээ.

Хэдийгээр энэ бүх бэрхшээлийг цаг агаартай холбож үзэж болох ч тэдгээрийг цаг тухайд нь шийдвэрлэн хариу арга хэмжээ авдаггүй байсан байна. Зун цагт ган, өвөл цагт зуд тохиолдож дээрх бэрхшээлүүдийг улам хүндрүүлж байв. Ийнхүү хувьчлалыг яаран явуулж, нэгдэл хоршоодыг татан буулгаснаар гарах үр дагаврыг нь судалж тогтоогүйгээс цаг агаарын бэршээлтэй нөхцөлд уян хатан зохицож ажиллах боломжгүй байдалд хүргэжээ.

Судалгаанд оролцогсод малчдын орлогод ч өөрчлөлт гарч байгаа талаар ярьж байв. Зах зээлийн үйл ажиллагаанаас олж буй орлогын эзлэх хувь нэмэгдэж харин нэгдэл хоршоодоос олгож байсан хөдөлмөрийн хөлс болон хөнгөлөлт үйлчилгээ буурсан. Энэ өөрчлөлтийн дүнд эмзэг байдал нэмэгдэж, ялангуяа амьжиргааны доод түвшинд ойрхон байгаа ядуувтар өрхүүд илүүтэй нэрвэгдэх хандлагатай болж байна. Нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээ хорогдсон нь эдгээр өрхийн амьжиргааг улам доройтуулж, үйлчилгээний даатгалын төлбөр нь хэдийгээр өндөр биш ч тэдэнд дарамт болж, ихэнх нь төлөх чадваргүй байна. Түүнчлэн хүүхдийн сургуулийн зардал ч нэмэгдэж байгаа талаар судалгаанд оролцогсод дурьдаж байв. Дээрх нөхцөл байдал тэтгэмж авах боломжтой хүний талаарх мэдээлэл хангалттай түвшинд хадгалагдаагүй байснаас улам доорджээ. Энэ талаарх мэдээлэл нэгдэл, хоршооллын түвшинд хадгалагддаг байснаас алдагдаж, олон хүн хүнд байдалд орсон.

Мал сүргийн тоо толгойноос хамааран зээл олгодог тул цөөн болон цөөвтөр малтай малчид банк санхүүгийн байгууллагаас зээл авч чаддаггүйг судалгаанд оролцогсод нотлон ярьж байлаа. Банк санхүүгийн байгууллагууд зээлийн барьцаанд наад зах нь 500 мал шаарддаг тул ихэнх ядуу малчин болон дундаж малтай малчин өрх эдгээр санхүүгийн үйлчилгээнд хамрагдаж, эрхэлж буй аж ахуйдаа хөрөнгө оруулах, эд хөрөнгө авах боломжоор хангагддаггүй байна.

Орон сууцны хувьчлалын талаарх оролцооны аргын судалгаа

Шилжилтийн бүр эхэн үед орон сууцыг хувьчлах талаар ярьж, 1992 он гэхэд Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасан байна. 1994 оны 3-р сард Өмч Хувьчлалын Комисс бусад яам, газартай хамтран 1994-1996 оны мөрийн хөтөлбөрийг боловсруулан, орон сууц, ахуйн үйлчилгээний хангамж, хөлс, хууль эрхийн болон бусад зүйл, засаг захиргааны шинэ зохион байгуулалт зэрэг орон сууцны хувьчлалтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхээр төлөвлөжээ. 1995 онд Их Хурал бэлтгэл ажлыг бүрэн хангасны дараагаар орон сууцны хувьчлалыг явуулахаар шийдвэрлэж, 1996 оны 10-р сард Орон Сууцны Хувьчлалын хуулийг баталсан. Энэ хуулиар хууль ёсоор түрээслэн сууж буй хүмүүст орон сууцыг нь үнэгүй хувьчилж өгөх болжээ. Энэ хууль батлагдсаны дараа орон сууцыг хувьчлах үйл явц эхэлж, 2001 он гэхэд орон сууцны дийлэнхийг (1996 онд бүртгэгдсэн орон сууцны 97.13 хувийг) хувьд шилжүүлсэн. Энэ хувьчлалыг дагаад хувийн орон сууцны салбарт хэд хэдэн чухал өөрчлөлт гарсан. Үүнд орон сууцны үйлчилгээ хариуцсан байгууллагуудыг Сууц Өмчлөгчдийн Холбоо болгон өөрчлөн байгуулж, эдгээр байгууллага нь 2001 онд хувийн орон сууцны 75 хувийг хамран үйл ажиллагаагаа явуулж байна.

2003 оны эхний хагаст Нийгмийн Хөгжлийн Төв орон сууцны хувьчлалын талаарх оролцооны аргын судалгааг явуулсан. Судалгаанд Улаанбаатар хотын 2 дүүрэг, Дархан Уул хотын оршин суугчдыг санамсаргүй түүврийн аргаар сонгон хамруулж 30 бүлэг ярилцлагыг зохион байгуулсан. Хувьчлагдсан орон сууцны 63% нь Улаанбаатар хотод, 11% нь Дархан Уул хотод төвлөрсөн. Судалгаанд оролцсон өрхүүдийг санамсаргүй түүврийн аргаар сонгосон бөгөөд хувьчлалд оролцсон болон оролцоогүй өрхүүдийн аль алиныг хамруулсан.

Судалгаагаар маш сонирхолтой дүгнэлтүүд гарсан бөгөөд Монгол улсад явагдсан орон сууцны хувьчлалын үйл явцад тэгш бус байдлыг үүсгэх олон хүчин зүйл үйлчилснийг тодруулан гаргав. Орон сууцны хувьчлалын тэгш бус байдалд үзүүлсэн нөлөөг судалгаанд оролцогсод олон хэмжүүрээр уялдаатай авч үзсэн.

Судалгаанд оролцогсдын үзэж байгаагаар ихэнх хүн тавьсан шалгуур үзүүлэлтийн дагуу орон сууц хувьчилж авсан тул энэ утгаараа орон сууцны хувьчлал шударга болжээ. Гэхдээ хувьчлалын үр шимийг нийт хүн амын ердөө 22% хувь хүртэж олон хүн үр шимийг хүртээгүй, эсвэл харилцан адилгүй хэмжээнд үр шимийг хүртсэн байна. Орон сууцыг үнэ өртөггүй хувьд шилжүүлсэн нь гэрт амьдарч буй хүмүүсийн хувьд туйлын шударга бус явдал болсон гэж судалгаанд оролцогсод үзэхийн сацуу орон сууцны хувьчлалын үеэр гарсан бусад тэгш бус байдлын талаар ярьсан. Орон сууцны байруудыг сайн, муу гэж ангилбал сайн орон сууц нь эрх мэдэлтэнгүүд, чинээлэг амьдралтай хүмүүсийн хувьд шилжиж очсон байна. Үнэ өртөггүйгээр орон сууцыг хувьчилсан нь мэдээлэл, танил талын сүлжээгээ ашиглан хөрөнгө гаргаж, өөртөө ашигтайгаар шийдвэрлүүлэх боломжийг нэг хэсэг хүмүүст олгосон гэж судалгаанд оролцогсод үзжээ. Энэ байдлыг орон сууцны байршилтай холбоотой ялгаатай байдал улам хурцатгажээ. Улаанбаатар хотын төв хэсэг чинээлэг Монголчууд болон гадаадынхны хувьд хамгийн үнэтэй, эрэлттэй хэсэг болж хувирсан. Хотын төвд орон сууц эзэмшиж байсан хүмүүс хотын захад болон аймгийн төвд амьдарч байсан хүмүүстэй харьцуулахад орон сууцаа худалдах буюу түрээслүүлэх замаар нилээд ашиг олсон байна.

Түүнчлэн нэг байранд хамтран амьдарч байсан хэд хэдэн өрхийн хувьд ихээхэн бэрхшээл учирж байсан. Ийм өрхүүдийн нэгнийх нь нэрэн дээр л орон сууцны эрхийн бичиг бичигдсэн байв. Орон сууцны хувьчлалын явцад бас өөр нэг тэгш бус байдал гарсан байна. Өмнөх тогтолцооны үед орон сууц хүссэн өргөдлийн дагуу орон сууц хүлээх жагсаалтыг гарган түүн дээр үндэслэн байр хувиарлан олгож байсан (зарим онцгой тохиолдолд очер дугааргүй байр олгодог байсан). Гэтэл хувьчлалын үйл явцад ордер нь нэр дээр нь байсан хүмүүст байрыг хувьчилж, харин ямар нөхцөлтэй байгаа, хичнээн хугацаанд орон сууц хүлээх дугаарт байсан зэргийг үл харгалзан энэ орон сууц хүлээх жагсаалтанд байгаа хүмүүст байр хувьчилж олгоогүй нь шударга бус явдал болсон. Урьд нь орон сууц улсын өмч байх үед хүмүүс өөрийн гэсэн байргүй боловч хууль эрхийн дагуу түрээслэн эзэмших эрхтэй байжээ. Эдүгээ залуу хос, оюутан суралцагсад, цэргийн алба саяхан хаасан хүмүүс байр сууцтай болно гэж нэг их итгэхгүй байгаа бөгөөд орон сууцны байшингийн дийлэнхийг хувьчилж, улсын өмчийн байр бараг үлдээгүй, улсаас орон сууцаар хангах боломж байхгүй тул орон сууцтай болох найдлага тун бага байна. Байргүй хоцорсон болон байр түрээслэх боломжгүй хүмүүсийн хувьд гэр хороололд суурьших ганц л боломж үлдэж байгаа юм.

Энэ судалгааны дүнгээс үзэхэд байрны хувьчлал бус харин гэрэл, цахилгаан, дулаан ус зэрэг үйлчилгээний хөлс нэмэгдэж байгаа нь орон сууцанд амьдрагсдын амьжиргааг доройтуулж, ядууруулах хамгийн гол хүчин зүйл болж байна. Хөнгөлөлттэй үнээр түрээслэхээ больж, дээрх үйлчилгээний үнийг өсгөх болсны улмаас эмзэг бүлгийн хүмүүсийн байдал хувьчлалаас өмнөх үетэй харьцуулахад эрс дордон, бодит орлого нь унасны улмаас янз бүрийн арга хайн, бүр аргагүйд хүрвэл байраа зарцгааж байна.

Орон сууцны хувьчлал нь үл хөдлөх хөрөнгийг дахин хувиарласан алхам болсон бөгөөд ядуурал, тэгш бус байдал нь үйлчилгээний үнийн өсөлтийг даван туулах зорилгоор хувьд ирсэн хөрөнгөө орлогын эх үүсвэр болгон хэр их ашиглаж байгаагаар хэмжигдэх болсон. Тус судалгаагаар орлогын эх үүсвэртэй болохын тулд үл хөдлөх хөрөнгөө янз бүрээр ашиглаж байгааг тодруулав. Нэн ядуу хэсэг нь байраа зарж гэр хороолол руу шилжин нүүж байхад зарим өрх нь байраа багасгах эсхүл байр болон өрөөгөө оюутан, ганц бие хүмүүст түрээслэн амьжиргаагаа залгуулж байна.

Орон сууцанд амьдрах өртөг нэмэгдэж байгаагийн улмаас байраа зарах, эсвэл түрээслэх замаар бэлэн мөнгөний орлоготой болохыг зорьж байна. Орон сууцны талбай томтой байранд амьдрах бодит үнэ өртөг өндөр тусаж, өөрсдийн бодит орлоготой уялдуулан орон сууцны талбайн хэмжээгээ багасган өөрчилж байна. Хувьчлалаас хойш орон сууцны талбайн дундаж хэмжээ илэрхий буурсан нь үүнтэй холбоотой. Харин шилжилтийн эхэн үед худалдаа наймаа хийн хөлжсөн бэлтэй хүмүүсийн хувьд орон сууцны хувьчлал нь үлэмж бололцоог олгож байгаа юм. Ийм хүмүүс байр сууцаа ашиглан бизнес аж ахуй эрхэлж байна. Байранд явуулж буй тэдний бизнес үйл ажиллагаа бусад хөрш айлын тав тухыг алдуулж, энэ талаар тухайн нутаг дэвсгэрийн захиргаа болон цагдан сэргийлэхийн газарт мэдэгдсэн ч хариу ямар нэг арга хэмжээ авдаггүй нь хахууль авсантай холбоотой гэж судалгаанд оролцогсод ярьж байв. Түүнчлэн хувьчлалын дүнд байр сууцаа зээл авах барьцаа болгон ашигладаг болсон нь эд баялаг, орлогын хувиарлалтыг улам гүнзгийрүүлэхэд нөлөөлсөн байж болох юм. Мэдээж гэр хороолол болон муу ангиллын байранд амьдарч буй хүмүүстэй харьцуулахад сайн байр хувьчилж авсан хүмүүсийн хувьд байраа боломжийн үнээр барьцаалж зээл авах бололцоо илүү байх нь ойлгомжтой. Түүнчлэн байраа ашиглах боломжийг ашиглах нь энэ талаарх ойлголт, туршлага дадалтай холбоотой боловч олон хүн ийм ойлголт, туршлага дадал мэдээллээр дутагдаж байна.

Судалгаанд оролцогсод орон сууцны нийтийн эзэмшлийн өмч болох шат, талбайн талаар бас саналаа хэлж байв. Шинээр байгуулагдсан Сууц Өмчлөгчдийн Холбоо нь үр дүн муутай, ихэнх тохиолдолд маш муу ажиллаж байгаа талаар шүүмжлэн ярилцаж байв. Орон сууцны нийтийн эзэмшлийн хэсгийн засвар арчилгааны талаар ч судалгаанд оролцогсод сэтгэл дундуур байгаа бөгөөд нийтийн эзэмшлийн эрхтэй холбоотой хэд хэдэн бэрхшээлтэй асуудлыг хөндөж ярилцсан. Тухайлбал орон сууцны нийтлэг хэсэг тэнд суугчдын нийтийн өмч болж, нийтийн эрх ашгийг хувь хүмүүс эзэмшигчдийн эрх ашигтай уялдуулахад бэрхшээл учирж байна. Даацын ханыг нураах, дотоод засвар хийхтэй уялдан нэлээд их хүндрэлүүд гарч энэ нь хөршүүдэд нөлөөлөх, хүмүүс амьдран суух зориулалттай байранд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх зэрэг сөрөг үр дагаврын талаар судалгаанд оролцогсод ярьж байв. Хувьчлалыг явуулах, түүний аргыг сонгохдоо ийм асуудлууд болон тэдний цар хүрээг

харгалзаж үзээгүй, тэдгээрийг шийдвэрлэх хууль эрх зүйн бүтцийн талаар урьдчилан төлөвлөөгүй байна.

Орон сууцны хувьчлалын түүвэр судалгаа

2003 оны хавар МУИС нь орон сууц эзэмшигчдийн түүвэр судалгааг 5 бүс нутгийг хамруулан явуулав. Судалгаанд санамсаргүй түүврийн аргыг ашиглан судалгааны нэгжийг 2 стратад үндэслэн сонгосон. Эхлээд 481 байрыг сонгон авсан боловч эзэн нь тодорхойгүй, эзгүй байсан эсхүл зарагдсан зэрэг шалтгааны улмаас зөвхөн 342 байрыг судалгаанд хамруулж, эзэмшигчид, оршин суугчдаас нь ярилцлага авсан. Өмчлөл, байр зарсан тохиолдол дутуу хамрагдах явдлаас сэргийлэх зорилгоор байр өмчлөл болон байр зарсантай холбоотой асуултуудад нэлээд хянуур болгоомжтой хандан хариултуудыг нарийвчлан авсныг дурьдах нь зүйтэй. 342 байрыг судалгаанд хамруулж, тархаалтыг Улаанбаатар хот (204), баруун бүс (16), хангайн бүс (36), төвийн бүс (65) and зүүн бүс нутагт 21 хийв.

Судалгааны үндсэн зорилт нь өмчлөл болон байрны хөлс, үнэ өртгийг тодорхойлох явдал байсан бөгөөд орон сууцанд амьдрагсдын боловсролын түвшний талаар бас асуусан. Судалгаагаар урьд нь амьдарч байсан орон сууцаа хүмүүс хувьчилж авсан бөгөөд хувьчлалаас өмнө дунджаар 12 жил тэр байранд амьдарч байсныг тодруулав. Нийт судалгаанд хамрагдагсдын 57 буюу 17 хувь хувьчилсан байрыг худалдаж авч, 9 хүн буюу 2.6 хувь нь 2, 3 болон 4 байр эзэмшиж байна. Өмчлөгч нь тодорхойгүй байгаа байрнуудыг оруулаагүй тул дээрх тоо бүрэн бус тоо байж болох юм. Судалгааны дүнгээс харахад байр орон сууцны зах зээл бий болж, Улаанбаатар хотод төвлөрсөн байна.

Хэдийгээр нарийвчилсан тоо байхгүй боловч байр орон сууц түрээслэх зах зээл ялангуяа Улаанбаатар хотод үүсэн хөгжиж байна. Улаанбаатар хотод зарим хүн бусдын 1 болон 2 өрөө байрыг сард дунджаар 105000 төгрөгөөр түрээслэн амьдарч байна. Гэхдээ ийм хариултыг ердөө 17 хүн өгсөн тул шууд нийтэд хамааруулан авч үзэж болохгүй. Харин сүүлийн үед хэвлэгдсэн материалаас харахад Улаанбаатар хотод чинээлэг, гадны хүнд түрээслүүлж байгаа байр маш өндөр үнэтэй, дунджаар сард 1000 ам.доллар хүрч байгаа бөгөөд хангамж нь маш сайн байдаг байна¹.

Судалгаагаар нийтийн орон сууцны аж ахуйн үйлчилгээ, үйлчилгээний хөлс хувьчлалын дараагаар эрс нэмэгдсэн нь харагдлаа. Хувьчлалын өмнөх болох дараах үеийн үйлчилгээний өртгийг тодруулж асуусны дүнг дор танилцуулав :

¹ Улаанбаатар хотод зориулсан товхимол болон 2003 оны 11 сарын үеэр орон нутгийн хэвлэлд гарсан зарлал

Хүснэгт 5: Орон сууцны үйлчилгээний сарын зардал

	Хувьчлалаас өмнө				Хувьчлалаас хойш			
	Бүгд	Цахилг аан	Халаал т	Ус	Бүгд	Цахилг аан	Халаал т	Ус
Дундаж	15147	5176	3350	2240	29551	10231	7270	7454
Дээд үнэ	35500	15000	13000	1500	122670	30000	72000	28000
Доод үнэ	785	105	150	150	7700	1400	736	500

Жич: төгрөгөөр мөнгөн дүнг илэрхийлэв.

Байр хувьчлагдсан он болон хувьчлагдсаны дараах оныг нарийн тодруулах боломжгүй тул дээрх тоонд дүн шинжилгээ хийхэд бэрхшээлтэй байна. Түүнээс гадна тоо мэдээг бодит утгаар нь илэрхийлэх боломжгүй байна. 1997 он болон түүнээс хойшхи хугацаанд ихэнх байрыг хувьчилсан боловч тэр үеийн инфляцийн ерөнхий түвшинг нэлээд доогуур хэмжээнд авсан тул зарим талаар бага гарсан байж болох юм. Орон сууцны бодит өртөг асар их нэмэгдэж ойролцоогоор хоёр дахин их болсон. Хэрвээ нийт үйлчилгээний хөлсийг нийт орлогын хувиар авч үзэх юм бол 29-37 хувийн өсөлт ажиглагдаж, орон сууцны харьцангуй үнэ өртөг огцом нэмэгдсэнийг харуулна. Харин тэгш бус байдал, ядуурлын талаас авч үзэх юм бол хувьчлалаас өмнөх болон дараачийн үеүдэд үнэ хөлсний доод хэмжээнд ихээхэн сонирхол татсан дүн гарч байна. Энэ үнэ маш их өсөж, орон сууцны үйлчилгээний нийт өртөг дунджаар бараг 10 дахин нэмэгдсэнтэй тэнцэж байна. Хэрвээ хувьчлалаас өмнө хамгийн хямд байранд харьцангуй ядуу хүмүүс амьдарч байсан гэж үзвэл хувьчлалын дараа орон сууцны үйлчилгээний хөлс нэмэгдсэн нь эдгээр хүмүүст хүндээр тусах болжээ.

Орон сууцны үнэ өртгийн талаарх тоо мэдээнээс харахад хувьчлагдсан байрны үнэ ялангуяа Улаанбаатар хотод асар их өсчээ. Хувьчлалын үеийн байрны үнэ өртгийг судалгааны үеийн үнэ өртөгтэй харьцуулахад дундаж үнэ 470 хувиар нэмэгджээ. Хэдийгээр үүнийг инфляцийн ерөнхий түвшинтэй холбож тайлбарлаж болох ч ихэнх байр 1997 оноос хойш хувьчлагдсан тул энэ нь нийт үнийн өсөлтийн багахан хувийг эзэлж байж болзошгүй. Түүнчлэн одоогийн үнэ ханш нь зах зээлээр тодорхойлогдсон үнэ ханш бус харин өмчлөгчид нь таамаглан барагцаалж хэлсэн үнийн дүн байж болох юм. Гэсэн ч энэ бүхэн орон сууцны харьцангуй үнэ асар их нэмэгдсэнийг харуулах хангалттай нотолгоо болж байна. Хувьчлалын үеэр өндөр үнэ ханшаар үнэлэгдсэн байрны үнийн өсөлт 180 хувьтай байхад хамгийн доод хэмжээнд үнэлэгдсэн байрны үнийн өсөлт 4900 хувьтай байгаа нь сонирхол татаж байна.

Улсаас олгох орон сууцны хангамж муу, орон сууцны харьцангуй үнэ өссөн, байрны сарын түрээс зэрэг хүчин зүйлийн улмаас хувьчлалын үеэр байрны ордергүй байсан ядуу хүн ам орон сууцанд амьдрах боломжгүй болж байна. Хувьчлалын үеэр байр хувьчилж авч чадсан ядуу хүмүүсийн бодит орлого нь орон сууцны өндөр үнэ хөлсийг дийлэхгүйд хүрч олон хүн гэр хороолол руу нүүж байна.

Судалгаагаар орон сууц байрыг зээл авахад барьцаа болгон ашиглаж, авсан зээлээ орон сууцны нөхцлөө сайжруулах эсхүл солиход зарцуулж байгаа нь харагдлаа.

Жижиг, дунд үйлдвэр аж ахуйн газрын хувьчлалын талаарх үүвэр судалгаа

2003 оны эхний хагаст МУИС нь түүвэр судалгаа явуулсан. Төрийн Өмчийн Хорооноос мэдээлж байгаагаар 1991-1999 онуудад улаан, цэнхэр тасалбар, нээлттэй болон хаалттай дуудлага худалдаа, үнэт цаасны биржээр худалдаалах зэрэг аргаар нийт 1146 үйлдвэр, аж ахуйн газрыг хувьчилжээ. Гэвч тухайн аж ахуйн газар, үйлдвэрийг хувьчлах ажлыг хэд хэдэн удаа явуулсан, эхний жилүүдэд хувьчлагдсан зарим үйлдвэр аж ахуйн газрууд үйл ажиллагаагаа зогсоосон эсхүл устаж алга болсон зэрэг шалтгааны улмаас хувьчлагдсан аж ахуйн газруудын тоо дээрх тоотой нийцэхгүй байна. МУИС-ын судалгааны баг нийт 751 үйлдвэр, аж ахуйн газруудад түүвэрлэлт хийн, том, дунд, жижиг оврын гэж ангилсан байна. Нэгэнт том аж ахуйн нэгжийн талаар нарийвчилсан тодорхойлолт байхгүй тул хөрөнгийн хэмжээнд нь тулгуурлан аж ахуйн нэгжүүдийг ангилан, 50 болон түүнээс дээш сая төгрөгөөр үнэлэгдэн хувьчлагдсан үйлдвэр аж ахуйн газруудыг том оврын, бусдыг нь буюу үлдсэн 651-ийг дунд, жижиг оврын үйлдвэр аж ахуйн газар гэж тооцжээ. Үүнээс 82 үйлдвэр аж ахуйн газруудыг байрлал, хувьчлалын үнэ, хувьчилсан жилүүдээр нь шатлан түүвэрлэж авсан.

Тархаалтыг дараах байдлаар хийсэн. Үүнд, Улаанбаатар хотод 38 үйлдвэр аж ахуйн газар, баруун бүсэд – 7, төвийн бүсэд – 15, зүүн бүсэд –9, хангайн бүсэд –13 үйлдвэр аж ахуйн газруудыг тархаав. Судалгааны үеэр 21 үйлдвэр аж ахуйн газар үйл ажиллагаагаа зогсоосон эсхүл дампуурсан тул түүврийн хэмжээ багасч 61 үйлдвэр, аж ахуйн газруудыг судалгаанд хамруулсан байна².

Хүснэгт 6-д үйлдвэр аж ахуйн газруудыг хувьчлагдсан жилүүдээр харуулснаас үзэхэд нэлээд сонирхолтой дүр зураг бууж байна.

Хүснэгт 6: Судалгаанд хамрагдсан үйлдвэр, аж ахуйн газруудын хувьчлагдсан жилүүд

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Үйлдвэр аж, ахуйн газрын тоо	3	18	12	7	3	3	10	18	2	1	1	0

Жич: Судалгаанд хамрагдсан боловч хувьчлагдсан он нь тодорхой бус үйлдвэр, аж ахуйн газрууд дээрх хүснэгтэд ороогүй болно.

² Үйлдвэр, аж ахуйн газрууд асуултанд хариулахдаа бүрэн хаагдаагүй боловч үйл ажиллагаагаа түр зогсоосон үеэ янз бүрийн байдлаар илэрхийлж байсан тул хариултад цоорхой гарч байсан.

Нийт түүвэрлэгдсэн үйлдвэр аж ахуйн газруудын тэн хагасаас илүү хувь нь 1992 болон 1998 онд хувьчлагдсан нь хамгийн өндөр үзүүлэлттэй жилүүд байна. Харин 1998 оноос хойш хувьчлагдсан үйлдвэр, аж ахуйн газруудын тоо маш багассаныг хүснэгт харуулав.

Хувьчлалыг эдийн засгийн салбараар ангилан үзэхэд тээврийн салбар (71.4 хувь), боловсруулах үйлдвэрлэл (64.3 хувь) 1990-ээд оны эхэн болон 1995 оны өмнөх үед хувьчлалд нэлээд хамрагджээ. Түүнчлэн барилга, худалдаа, үйлчилгээний салбарын газрууд ч энэ хугацаанд нэлээд хувьчлагдсан байна.

Судалгааны асуулга өмч хувьчлал нь орлогын хувиарлалт болон ядууралд хэрхэн нөлөөлсөн талаар дүгнэлт хийж болохуйц мэдээлэл цуглуулахыг зорьсон. Гэхдээ асуулгыг хувьцаа эзэмшил, түүний төвлөрөл, ажлын орон тоо, цалин хөлс, хөнгөлөлт, нэмэгдэл үйлчилгээний талаар мэдээлэл цуглуулахад голчлон чиглүүлж явуулснаас гадна ашиг, орлого, татварын хураамжийн талаар асуултуудыг мөн оруулсан. Гэхдээ асуултуудад бүрэн дүүрэн үнэн зөв хариулт өгөөгүй, эдгээр хариултаас мэдээлэл боловсруулахад учир дутагдалтай байсан тул бусад мэдээлэлтэй зөрчилдсөн, тийм ч их хэрэгтэй мэдээлэл гарсангүй.

Хувьцаа эзэмшил

Хувьцаа эзэмшил нь корпораци, бүрэн бус хариуцлагат компани, түншлэл гэсэн 3 бүлэгт хуваагдаж байна. Корпораци нь үнэт цаасны биржээр дамжуулан нийтэд хувьцааг нь чөлөөтэй худалдаалж, худалдан авч буй бүрэн бус хариуцлагат компаниуд, харин хувьцааг нь үнэт цаасны биржээр дамжуулан нийтэд чөлөөтэй худалдаалахгүй байгаа компаниудыг бүрэн бус хариуцлагат гэж тодорхойлж байна. Нөхөрлөл нь хөрөнгө мөнгөө хамтатган нэгтгэсэн жижиг бизнесүүдээс бүрдэж байна. Судалгаанд хамрагдсан жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн газрын нилээд хэсэг нь хязгаарлагдмал хариуцлагатай өмчлөлийн хэлбэрийг сонгодог байна. Нийт 61 үйлдвэр, аж ахуйн газар судалгаанд хамрагдсаны 37 нь корпораци, 22 нь хязгаарлагдмал компани, 1 нь түншлэл байсан ба 1 нь аль ч ангилалд багтаагүй байна.

Дээрх мэдээллийг салбараар задаргаа хийн үзэхэд шинээр хувьчлагдсан жижиг, дунд оврын үйлдвэр, аж ахуйн газрын 41 хувь боловсруулах салбарт, 29.5 хувь худалдаа, үйлчилгээний салбарт, 23.3 хувь барилгын салбарт, 4.9 хувь тээврийн салбарт, 1.6 хувь уул уурхайн салбарт, 1.6 хувь боловсролын салбарт тус тус ажиллаж байна.

Хувьцаа эзэмшил, түүний төвлөрлийн талаах мэдээлэл ихээхэн сонирхол татаж байна. Мэдээлэл хязгаарлагдмал хүрээнд байж, мэдээллийг өөртөө төвлөрүүлж байсан хүмүүс

хувьчлалд давуутай оролцсон байна. Судалгаанд хамрагдсан нийт хувьцаа эзэмшигчдийн 55.7 хувь тухайн үйлдвэр аж ахуйн газарт урьд нь ажиллаж байжээ. Түүнчлэн хувьцааны төвлөрөл нэмэгдэж байгаа нь судалгаагаар харагдлаа. Хувьчлалын эхэн үед 855 байсан хувьцаа эзэмшигчдийн тоо судалгааны үеэр 538 болж хорогдсон байна. Хувьцааны төвлөрлийн талаар дүгнэлт хийхдээ хувьцааны он жилүүд харилцан адилгүй байсантай уялдуулж болох юм. Ер нь хувьчлал явагдсан эхний жилүүдэд хувьцааны төвлөрөл ямар байв гэдэг нь сонирхол татаж байна.

Хувьцаа эзэмшигчдийн тоо буурахын сацуу үндсэн эзэмшигчдийн гарт хувьцаа төвлөрч буй хандлага ажиглагдлаа. Хүснэгт 7-д 4 том хувьцаа эзэмшигчдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг оруулав.

Хүснэгт 7: 4 том хувьцаа эзэмшигчид

	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Хувьцаа эзэмшигч 1	42.4	51.0	51.0	44.2	47.7	42.9	47.5	50.3	55.5	56.5	55.6
Cell size	3	6	6.	9	14	21	25	32	24	25	30
Хувьцаа эзэмшигч 2	40.0	37.7	37.7	34.2	28.1	25.9	27.7	24.4	27.0	27.4	29.1
Cell size	3	4	4	5	9	16	16	19	15	17	21
Хувьцаа эзэмшигч 3	0.0	13.0	13.5	16.0	15.9	16.9	17.9	18.0	15.8	15.6	15.1
Cell size	0	2	2	4	7	12.	13	14	9	9	13
Хувьцаа эзэмшигч 4	0.0	0.0	0.0	19.0	17.8	15.7	16.2	14.5	8.3	8.3	10.7
Cell size	0	0	0	1	2	3	6	7	3	3	6

1992 онд үндсэн эзэмшигч нийт хувьцааны 42 хувийг эзэмшиж байсан бол 2002 онд 56 хувийг эзэмших болжээ. Бусад томоохон хувьцаа эзэмшигчдийн хувьд онцын өөрчлөлт гарсангүйгээс харахад бага хэмжээний хувьцаа эзэмшигчдээс авах замаар үндсэн эзэмшигч хувьцааг төвлөрүүлсэн байна. Ажилчид болон удирдлагын хувьцаа эзэмшсэн хувийн хоорондын харьцааг харахад удирдлагын гарт хувьцаа төвлөрч буй хандлага ажиглагдаж байна. Хувьчлалын үеэр ажилчдын гарт хувьцааны 33.9 хувь байсан бол судалгааны үеэр 12.7 хувь болж буурчээ. Бусад хувьцаа эзэмшигчдийн хувьд эзлэх хувь нь өөрчлөгдөөгүй хэвээр байгаа тул удирдлага ажилчдаас хувьцааг худалдан авсан гэсэн үг. Энэ талаарх мэдээллийг Хүснэгт 8-д харуулав.

Хүснэгт 8: Хувьцаа эзэмшил удирдлага, ажилчид, бусад хүмүүсийн эзлэх хувиар

	Удирдлага	Ажилчид	Бусад
Судалгааны үеэр	57.5	12.7	29.9
Хувьчлалын үеэр	34.8	33.3	31.9

Хувьцаа эзэмшлийн бүтцэнд гарсан энэ өөрчлөлтийн дүнд хувьчлагдсан аж ахуйн нэгж, компанийн удирдах зөвлөлийн бүтэц шинээр үүсч гарсан ба энэ зөвлөлд ажилчдын

төлөөлөл үлэмж буурчээ. Үнэндээ, удирдлагын зөвлөлийн одоогийн бүтэц хувьцаа эзэмшлийн бүтцийг илэрхийлж байгаа юм.

Ажил эрхлэлтэнд үзүүлсэн нөлөө

Судалгаанд хамрагдсан бараг бүх аж ахуйн нэгж, компани хувьчлагдсаны дараа цомхотгол хийжээ. Үүний үр дүнд 1992 оноос 2000 хүртэлх хугацаанд нэг аж ахуйн нэгж, компанид ногдох ажил эрхлэлтийн дундаж түвшин тогтмол буурсныг Хүснэгт 9-д үзүүлэв. Харин 2000 оны дараа энэ түвшин бага зэрэг өсөх болсон.

Хүснэгт 9: Хувьчлагдсан аж ахуйн нэгж, компаний ажил эрхлэлтийн дундаж түвшин

	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
No.	8	13	15	17	23	31	37	46	33	35	34
Дундаж ажил эрхлэлт	270	198	162	136	105	79	67	63	42	56	74

Дээрх тоо нь янз бүрийн хугацаанд хувьчлагдсан аж ахуйн нэгж, компанийн ажил эрхлэлтийн дундаж түвшний бууралтыг илэрхийлсэн бөгөөд хувьчлалын дүнд ажлын байрыг цомхотгож байсан явцыг зарим талаар харуулж байгаа юм; дээр дурьдсанчлан хувьчлагдсан аж ахуйн нэгж, компанийн тоо жил бүр харилцан адилгүй байсан тул ажил эрхлэлтийг дунджаар авсан. **Эхний жилүүдэд когортын хэмжээ бага байгаа нь** Хүснэгт 10-т ажил эрхлэлтийн дундаж түвшинг хувьчлагдсан жилээр задаргаа хийн харуулснаас үзэхэд когорт бүрт ажлын байрны хорогдол тогтмол давтагджээ.

Нарийвчилсан тоо мэдээнээс үзэхэд хувьчлал нь ажлын орон тоо их хэмжээгээр хорогдохын дохио болж, түүний дүнд ажил эрхлэлтийн дундаж түвшин буурсан байна. Хувьчлагдсан аж ахуйн нэгжийн дундаж хэмжээ унаж буй нь хувьчлалаас өмнө хэрэгжиж эхэлсэн хувьчлалын хөтөлбөрийн үеэр ажлын орон тоог цомхотгосонтой холбоотой байж болох юм. Гэхдээ энэ талаарх мэдээллийг түүвэр судалгаагаар цуглуулаагүй тул нарийвчлан дүгнэлт хийх боломжгүй байна. Ажлын байрны цомхотгол он бүрээр хэлбэлзэж байна. Шилжилтээс хойшхи хугацаанд эдийн засгийн байдал тогтворгүй байсан тул энэ нь гайхмаар зүйл биш юм. Гэсэн хэдий ч 1999-2000 онуудад ажлын цомхотгол асар их явагджээ. Когорт бүрээр хэлбэлзэлтэй байгаа нь нийт ажил эрхлэлтэнд үзүүлсэн нөлөөг хэмжихэд хүндрэл учруулж байна. Хүснэгт 10-т ажлын дундаж орон тоо гэнэт өссөн нь 1999-2000 онд илэрхий ажиглагдаж байгаа бууралтын өндөр хувьтай холбоотой нь тодорхой. Тухайлбал 1992 оны когорт 8 байснаас 1 болж унасан байна. Үйлдвэр аж ахуйн газруудын хэмжээ томорсон нь нэг талаар жижиг өрсөлдөгчид зах зээлээс шахагдан гарсантай холбоотой байж болох юм. Түүнчлэн, 2002 онд 423 ажилтан бүхий компанийг нэмж оруулсан нь оны эцсийн үйлдвэр аж ахуйн дундаж хэмжээний дүнд өрөөсгөл нөлөө үзүүлсэн нь тодорхой.

Хүснэгт 10: Аж ахуйн нэгж, компаний дундаж ажил эрхлэлт хувьчлалын когортоор

	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
1992	270	252	223	206	171	125	108	99	212	248	249
Когортын хэмжээ	8	8	8	8	8	8	8	8	1	1	2
1993		112	128	66	61	60	45	42	20	23	28
Когортын хэмжээ		5	4	3	3	3	4	5	3	3	4
1994			46	49	47	35	34	33	16	26	27
Когортын хэмжээ			3	3	3	3	3	3	2	2	2
1995				105	100	76	79	78	61	54	56
Когортын хэмжээ				3	3	3	3	3	3	3	3
1996					72	68	68	64	17	28	35
Когортын хэмжээ					6	6	6	6	3	3	2
1997						67	51	53	63	76	69
Когортын хэмжээ						8	8	7	4	3	3
1998							58	80	33	33	41
Когортын хэмжээ							5	4	3	3	2
1999								51	35	40	46
Когортын хэмжээ								10	8	6	5
2000									36	31	29
Когортын хэмжээ									6	6	6
2001										118	122
Когортын хэмжээ										5	4
2002											423
Когортын хэмжээ											1

Нийт ажил эрхлэлтэнд үзүүлсэн нөлөөг тодорхойлох өөр нэг арга бол когорт бүрд нийт ажил эрхлэлтийн төлөв байдлыг судлах явдал юм. Энэ талаарх мэдээллийг Хүснэгт 11-д үзүүлснээс харахад бараг бүх үйлдвэр, аж ахуйн газар хувьчлалын дараахан ажлын орон тоог огцом бууруулсан байна. Тоо мэдээнээс харахад 1999-2000 онд нийт ажлын орон тоо когорт бүрд маш ихээр цомхогдсон, ажлын орон бүхий үйлдвэр аж ахуйн газруудын тоо огцом буурсан байна. Гэхдээ 2003 онд судалгааны үеэр судалгаанд хамрагдсан үйлдвэр аж ахуй татан буугдаагүй ажиллаж байсан гэж тооцсон тул олон үйлдвэр аж ахуй ажлын байрны цомхотгол хийжээ гэсэн дүгнэлтэнд хүргэж байна. 2002 онд энэ байдал бага зэрэг дээрдэж эхэлжээ.

Хүснэгт 11: Нийт ажил эрхлэлт хувьчлалын когортоор

	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
1992	2163	2015	1782	1644	1366	996	862	793	212	248	498
Когортын хэмжээ	8	8	8	8	8	8	8	8	1	1	2
1993		558	510	197	183	180	181	211	59	69	111

Когортын хэмжээ 1994	5	4	3	3	3	4	5	3	3	4	
Когортын хэмжээ 1995		138	148	141	104	101	99	32	51	54	
Когортын хэмжээ 1996		3	3	3	3	3	3	2	2	2	
Когортын хэмжээ 1997			315	300	228	236	234	183	163	168	
Когортын хэмжээ 1998			3	3	3	3	3	3	3	3	
Когортын хэмжээ 1999				429	410	405	382	50	84	70	
Когортын хэмжээ 2000				6	6	6	6	3	3	2	
Когортын хэмжээ 2001					534	407	372	250	227	207	
Когортын хэмжээ 2002					8	8	7	4	3	3	
Когортын хэмжээ 2003						290	318	99	99	81	
Когортын хэмжээ 2004						5	4	3	3	2	
Когортын хэмжээ 2005							507	278	238	231	
Когортын хэмжээ 2006							10	8	6	5	
Когортын хэмжээ 2007								213	185	172	
Когортын хэмжээ 2008								6	6	6	
Когортын хэмжээ 2009									590	486	
Когортын хэмжээ 2010									5	4	
Когортын хэмжээ 2011										423	
Когортын хэмжээ 2012										1	
Нийт	2163	2573	2430	2304	2419	2452	2482	2916	1376	1954	2501
Когортын хэмжээ	8	13	15	17	23	31	37	46	33	35	34

Цалин хөлсний хуваарилалт

Цалин хөлсөнд гарсан өөрчлөлтийн талаарх мэдээлэл үнэхээр сонирхол татаж байна. Шилжилтийн эдийн засагтай бусад оронд цалин хөлсний огцом ялгаа гарч (Миланович, 1999), зарим ажилтан ихэвчлэн өндөр албан тушаалын хүмүүсийн цалин ихээр нэмэгдэж, харин дундаж болон доогуур түвшинд цалин буурч улмаар инфляцийн нөлөөгөөр бодит цалингийн хэмжээ огцом унаж байгаа билээ. Монгол улсад ч бодит цалингийн хэмжээ буурч байна (ҮСГ). Ажилгүйдэл ч өсөж, ихэнхи судалгаанд ажилгүйдлийн түвшинг ойролцоогоор 20 хувьтай байна гэж тооцоолжээ (Кларк болон бусад, 2000). Энэ нь цалин хөлс буурч, ялангуяа ажлын ур чадвар дадал эзэмшээгүй хүмүүсийн цалин хөлс их доогуур байна гэсэн үг. Хэдийгээр бусад шилжилтийн эдийн засагтай оронтой харьцуулахад цалингийн тэгш бус байдал Монгол улсад харьцангуй бага байсан боловч сүүлийн жилүүдэд огцом нэмэгдсэн байна. Түүвэр судалгааны дүнгээс үзэхэд цалин хөлсний ялгаа ялангуяа дээд болон доод цалин хөлсний хэмжээнд бага байгаа аж.

Судалгаагаар хувьчлагдсан үйлдвэр, аж ахуйн газруудад ажиллаж буй өндөр болон дунд тушаалын удирдах ажилтнууд, ахлагч нар, бичиг хэргийн ажилтан, энгийн ажилчдын цалингийн талаар мэдээлэл цуглуулсан. Энэ тоо мэдээлэл нь бодит дүнг тусгаагүй, хувьчлал нь өөр өөр онуудад явагдсан тул когорт бүрээр хэлбэлзэлтэй зэрэг шалтгааны улмаас дүн шинжилгээ хийхэд бэрхшээлтэй байна. Гэвч Хүснэгт 12-т бүх түвшний цалин хөлсийг өндөр тушаалын удирдах ажилтны цалинд эзлэх хувиар гарган харьцуулж үзэхэд тухайн хугацаанд онцын ялгаа ажиглагдаагүй байна. Харин харьцуулалтанд хамрагдсан хугацааны дунд үед цалингийн тэгш бус байдал /ялгаа/ нэлээд нэмэгдсэн нь сонирхол татаж байна. Тэрчлэн ахлах менежер болон энгийн ажилтны хоорондох **харьцаа** мэдэгдэхүйц нарийсч байгааг судалгаагаар харуулсан нь маш их сонирхол татаж байна. Гэвч энэ нь когортын хэмжээ өөрчлөгдөхийн хамт он бүрээр хэлбэлзэлтэй байна.

Хүснэгт 12: Цалин хөлс удирдах албан тушаалын хүмүүсийн цалин хөлсөнд эзлэх хувиар

	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Дунд түвшний удирдах албаны хүмүүс /											
Ахлагч нар	79.7	88.3	73.2	65.2	62.3	67.2	96.1	98.4	63.6	70.7	80.1
Бичиг хэргийн ажилтнууд	48.8	51.4	52.7	58.4	37.7	37.8	30.9	36.3	38.0	37.1	50.6
Энгийн ажилтнууд	30.5	41.7	49.6	62.2	50.8	62.8	64.2	72.7	81.0	75.3	71.9

Үнэхээр гайхал төрүүлж буй эдгээр сонирхолтой тоо мэдээг дээр дурьдсан тэгш бус байдал нэмэгдэж буйг харуулсан тоо мэдээтэй уялдуулан харьцуулж үзэхэд тун хэцүү байна. Цалин хөлс нийт орлогын зөвхөн нэг бүрэлдэхүүн хэсгийг төлөөлдөг ч сүүлийн жилүүдэд ажилгүйдэл өсөн, бодит цалин буурч, эдийн засгийн өсөлт зогсонги байдалд орсон энэ нөхцөлд зах зээлийн ямар процессийн дагуу цалин хөлсийн ялгаа багасав гэдгийг тодорхойлоход хэцүү байна. Ийм учраас тус судалгаа нь зах зээлийн процесийг зөв хамарч явагдаж чадсан уу гэдгийг нягталж үзэх ёстой болов уу. Ер нь ажил эрхлэлтийн ангиллыг бүрэн дүүрэн зөв тодорхойлж, цалин хөлсний ялгааг гаргахад хүндрэлтэй байдаг. Ингэж чадаагүй бол өөрөөр хэлбэл буруу ангилал хийсэн бол цалин хөлсөнд гарсан томоохон өөрчлөлтүүдийг тодорхойлон гаргаж чадаагүй гэсэн үг. Нөгөө талаар цалин хөлсний ялгаанд хуучин улсын өмчлөлд байсан үйлдвэр, аж ахуйн газрын өв уламжилсан давуу нөлөө хэвээр байсан тул цалин хөлсний ялгаа шинээр бий болсон үйлдвэр, аж ахуйн газартай холбоотой байж болзошгүй. Ямар ч гэсэн энэ асуудлыг цааш нь гүнзгийрүүлэн судлах хэрэгтэй. Судалгаагаар ажиглагдсан цалин хөлсний харьцангуй бага ялгаа өрсөлдөөнт орчинд удаан хэвээр хадгалагдахгүй байж болзошгүй.

Цалин хөлснөөс гадуур нэмэгдэл тусламж дэмжлэг

Судалгаанаас харахад хувьчлагдсан жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн газруудад ажиллагсад цалин хөлснөөс гадуур төрөл бүрийн нэмэгдэл тусламж дэмжлэгт хамрагдах боломжтой хэвээр байсаар байна. Үүнд тэтгэвэр, эрүү мэндийн тэтгэмж, байр сууц олгох, сургуульд сургах, нийгэм, соёлын үйл ажиллагаа зэрэг орно. Харамсалтай нь, 2002 оны мэдээнээс харахад хувьчлалаас хойш эдгээр зардал буурсан эсэхийг хэлэх боломжгүй байсан. Үүний хамт, энэ мэдээллийг ашиглан ажиллагч тус бүрийн хувьд зарцуулалтыг тооцоолох боломж огт байгаагүй. Гэвч, судалгаа зах зээлийн эдийн засагт байдаггүй цалин хөлснөөс гадуур тусламж дэмжлэг хуучин улсын өмчлөлд байсан үйлдвэр, аж ахуйн газарт байсаар байгааг харуулсан байна.

7. Дүгнэлт

Энэхүү тайланг шилжилтийн эхний жилүүдэд ядуурал, тэгш бус байдал үлэмж нэмэгдэхэд өмч хувьчлал хир зэрэг нөлөөлснийг тодорхойлох зорилгоор бэлтгэн гаргалаа. Түүнчлэн хуримтлуулсан туршлага, сургамжуудыг тодруулан гаргаж, цаашид хувьчлалыг явуулахдаа хувиарлалтанд аль болохоор бага сөрөг үр дагавар үзүүлэхэд ашиглах зорилгыг бас агуулсан юм. Бусад орны адил Монгол улсад ч гэсэн улс төрийн шийдлээр хувьчлалыг явуулж, улсын өмч, үйлдвэр, аж ахуйн газруудыг хувьчлахад дагалдан гарах ядуурал, тэгш бус байдлын үр дагаварт хангалттай анхаарал тавиагүй байна. Монгол улс 1990 оноос хойш муужруулах эмчилгээний стратегийг хэрэгжүүлж, энэ стратегийн хүрээнд өмч хувьчлал, үнийн чөлөөлөлт, төрийн оролцоог багасгах, тогтвортой байдлыг тогтоох арга хэмжээг төлөвлөн явуулжээ. Энэ стратегийн хэрэгжилтийн дүнд тэгш бус байдал, ядуурал үүсэж, түүнийг дагалдан бүтээгдэхүүн, ажил эрхлэлт буурчээ. Иймд хувьчлалын үзүүлсэн нөлөөг бусад өөрчлөлтийн арга хэмжээний үзүүлсэн нөлөөнөөс тусад нь ялган нарийвчлан тодорхойлж болох эсэхэд юуны өмнө анхаарал хандуулах хэрэгтэй болов. Ерөнхийдөө ингэх нь боломжгүй санагдаж, гаргасан дүгнэлтүүдийг баталгаажуулах ёстой байлаа. Дараагийн асуудал нь хувьчлалаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг баримтаар нотолгоожуулан тодорхойлох явдал байсан. Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шийдвэр гаргаж, эдийн засаг, улс төрийн эрх мэдлийг эргэж буцалтгүй шилжүүлэх хэрэгцээ шаардлага бодитойгоор оршиж байсны улмаас хувьчлалыг ямар нэг хэлбэрээр явуулах нь зайлшгүй /бас хүсүүштэй/ хийх ёстой алхам байв. Ийм учраас өмч хувьчлалын үр нөлөөг өмч хувьчлал явагдаагүй орчин нөхцөлтэй харьцуулан гаргахад бус харин засгийн газраас шилжилтийн үед дэвшүүлсэн зорилтуудтай уялдан явагдсан өмч хувьчлалын арга хэлбэрүүд, үйл явц нь ядуурал, тэгш бус байдалд ямар нөлөө үзүүлсэн бэ гэдгийг тодорхойлоход асуудлын гол оршиж байгаа юм.

Макро-эдийн засгийн салбарт хүнд цохилт гарсан үед өмч хувьчлал явагдсан. Энэхүү хүнд цохилт нь бүтээгдэхүүн, ажил эрхлэлтийг бууруулж, улмаар ядуурал, тэгш бус байдалд шууд нөлөөлсөн байна. Хуучин ЗХУ-аас үзүүлж байсан тусламжх өнгөлөлтийн үр дүнд

орлогын түвшинг нэг хүнд ноогдох ДНБ-ний тэр үеийн түвшингээс дээгүүр хэмжээнд барьж байв. Гэвч ЗХУ задран унаснаар дээрх туслалцаа хөнгөлөлт зогссон юм. Түүнчлэн ЭЗХТЗ татан буугдаж, хатуу валютын худалдаанд даруй зохицож ажиллах шаардлага Монгол улсад тулгарч худалдааны бодит хэмжээ нь үлэмж буурчээ. Энэ бүхний дүнд нэг хүнд ноогдох бодит орлого эрс унасан байна. 1993 оноос хойш худалдаа эргэж өсөх хандлагатай болсон боловч гадаад орнуудын нөхцөл болзлоос ихээхэн хамааралтай, ялангуяа ийм байдал гол экспортын бүтээгдэхүүний үнэ импортын гол нэрийн бараануудын үнэтэй харьцуулахад их ажиглагдаж байв. Шилжилтийн эхний жилүүдэд ядуурал үлэмж өсөн 35 хувьд хүрсэн бөгөөд энэ нь дутуу тооцогдсон дүн байж болох юм. Энэ хугацаанд ядуурлын гүнзгийрэл, хамрах хүрээ бас нэмэгдсэн байна. Орлогын тэгш бус байдал гүнзгийрч, орлогын ялгааны үзүүлэлт болох Жини Коэффициент 0.31 байснаас 0.35 болж өсчээ.

Хувьчлалын эхний шатанд эрхийн тасалбарыг хуваарилан олгох стратегийг баримталсан. Хэдийгээр энэ стратеги нь тэгш зарчим дээр үндэслэн явагдсан ч бодит амьдрал дээр тэгш бус байдлыг бий болгосон байна. Эхний шатанд явагдсан хувьчлалыг судлан үзэхэд хэд хэдэн хүчин зүйл тэгш бус байдлыг гаргахад нөлөөлжээ. Ялангуяа мал хувьчлалд энэ нэлээд ажиглагдав. Монгол улсад мал хувьчлалыг явуулсан арга хэлбэр нь нэгдэл устаж үгүй болгох үр дүнд хүргэж, энэ нь мал аж ахуйн салбарыг өвлийн цас зуд, зуны ган гачиг зэрэг цаг агаарын бэрхшээлд маш эмзэг өртөмтгий болгоход нөлөөлсөн. Энэ байдал нь малын тоо толгойг хувьчлалын үеэр тэгш бус хуваарилан олгосон байдлыг бүр ч дордуулсан байна. Ерөнхийд нь дүгнэж хэлэхэд хамтын үйлчилгээ, бүтээгдэхүүнээр хангаж байсан хоршооллын бүтцийг үгүйсгэсэн хувьчлалын аргыг сонгож хэрэгжүүлсэн нь гарах үр дагаврын цар хэмжээг ихэсгэн гүнзгийрүүлэхэд зарим талаар нөлөөлжээ. Орон сууцны хувьчлал ч гэсэн тэгш хуваарилалтад хүргэсэнгүй. Хэдийгээр энэ хувьчлалыг орон сууц эзэмших эрхийн бичиг дээр үндэслэн шударга зарчмаар явуулсан гэх боловч яаран хувьчилсны улмаас хүн амын дийлэнх нь үр шимийг хүртэж чадаагүй байна.

Өмч хувьчлал нь ядуурал, тэгш бус байдалд хэрхэн нөлөөлснийг судлахын тулд өмч хувьчлалыг бодит орлогонд гарсан өөрчлөлттэй уялдуулан нарийвчилж судлах шаардлагатай болж байна. Өргөн утгаар, өмч хувьчлал нь эд хөрөнгийн өмчлөлийн хэлбэрийг өөрчилж, энэ нь эргээд бодит орлогын хуваарилалтанд өөрчлөлт оруулдаг. Гэхдээ энэ үр дагаварт бусад хүчин зүйл хүчтэй нөлөөлдөг бөгөөд чиглэл, хандлага, явцаас ихээхэн хамааралтай.

Бүх л онолын бүтээлүүдээс харахад улсын сектороос хувийн хэвшилд өмч хөрөнгийг шилжүүлэх явцад орлогын тэгш бус байдал үүсдэг аж. Үүнд гурван чиглэлээр ийм байдал үүсч болохыг дурдъя. Нэгдүгээрт, эд хөрөнгийг дахин хувиарласны дүнд бодит орлогын хувиарлалт өөрчлөгдөнө. Хоёрдугаарт, хуучин улсын мэдэлд байсан үйлдвэр, аж ахуйн

газруудын үүрэг хариуцлага, зорилго өөрчлөгдсөнөөр цалин хөлс, ажлын байрын хуваарьт өөрчлөлт гарна. Гуравдугаарт, улсын төсөв хийгээд нийгмийн болон бусад үйлчилгээнд нөлөөлдөг байна.

Шилжилтийн ижил стратеги баримталсан бусад орны туршлагад үндэслэн Монгол улсад явагдсан хувьчлал ядуурал, тэгш бус байдалд ямар үр дагаврууд үзүүлснийг тодорхойлох аргыг гаргаж авч болох юм. Гэхдээ л энэ үр дагаврыг санаж байсан хэмжээнд бүрэн илрүүлэн тодорхойлж болохгүй байна. Хувиарлалтад үзүүлэх өмч хувьчлалын нөлөөнд бага анхаарснаас гадна энэ талаар бусад орны жишээ, туршлага харилцан адилгүй үр дүнг харуулж байна. Гэхдээ л олон улсын жишээ, туршлагаас хэд хэдэн ерөнхий дүгнэлтийг хийе. Өмч хувьчлал нь эрх тэгш байдлыг хангахад бус харин үр ашгийг нэмэгдүүлэхэд илүүтэй чиглэгдсэн бөгөөд эд баялаг болон орлогын хувиарлалтад сөргөөр нөлөөлсөн байж болох талтай. Түүнчлэн олон улсын жишээ, туршлагаас харахад орлогын хувиарлалтад өмч хувьчлалын арга хэлбэр, зохион байгуулалт, бүтцийн хүрээний цар хэмжээ, чанар, зах зээлийн шинэчлэлийн арга хэмжээний дараалал, эрч хүч, өмчийн шинэ эздийн хандлага, үйл ажиллагаа зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна. Ерөнхийдөө, өмч хувьчлал нь дангаараа эрч хүчтэй идэвхтэй хувийн хэвшлийг хөгжүүлэх арга хэрэгсэл болж чадахгүй гэж дүгнэж болох юм.

Монгол оронд явагдсан хувьчлалын талаар явуулсан түүвэр судалгаа болон оролцооны аргын судалгааны дүнгүүд нь олон улсын жишээ туршлага, эрдэмтэн судлаачдын дүгнэлтүүдийг ерөнхийдөө баталж байна.

Мал хувьчлал нь ядуурал, тэгш бус байдалд хэрхэн нөлөөлснийг нарийвчлан тодорхойлоход хүндрэлтэй байна. Гэхдээ оролцооны аргын судалгааны дүнгээс үзэхэд оролцогсдын олонхи нь хувьчлалыг хэт яарч явуулсан, ил тод явагдаагүй, гарч болох үр дагаврын талаар сайтар анхаараагүй, ялангуяа малчдын амьжиргаанд ихээхэн нөлөөтэй байсан нэгдэл хоршоодыг устгаснаар ямар үр дагавар гарахыг нарийвчилж тооцоолоогүй гэж шүүмжлэлтэй ханджээ. Иймд хувьчлалын дараа тэгш бус байдал зайлшгүй гарсан ба тоо мэдээллээс харахад нэг хэсэг малчдын гарт мал сүрэг төвлөрөх явдал нэмэгдэж байна.

Орон сууцны хувьчлалд хамрагдаж үр шимийг нь хүртсэн хүмүүсийн хувьд тус хувьчлал шударга явагдсан байна. Орон сууцны хувьчлал нь орон сууцны хувиарлалт болон дахин хувиарлалтад гарсан тэгш бус байдлыг ихээхэн нэмэгдүүлжээ. Тоо мэдээнээс үзэхэд орон сууц өмчлөлийн төвлөрөл ихсэж, хувийн орон сууц түрээслэх зах зээл бий болсон байна. Орон сууц өмчилсөн хүмүүс орлогын шинэ эх үүсвэр бүрдүүлж, орон сууцаа барьцаанд тавин зээл авах зэргээр тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлж байна. Судалгаагаар баримтжсан үнийн асар их өсөлт нь ядуучууд хувийн орон сууцны зах зээлд оролцох ямар ч

боломжгүй болсныг харуулж байна. Тэрчлэн, бараг бүх байр, орон сууцыг хувьчилснаар орон сууцны нийтийн үйлчилгээ үзүүлэх боломжийг хаасан. Үнэн хэрэгтээ, орон сууцны асуудлаар ядуурал, нийгмийн бусад зорилтуудыг хангахад чиглэсэн аливаа төрлийн бодлого байгаагүй.

Жижиг, дунд оврын үйлдвэр аж ахуйн газар явуулсан судалгаагаар хувьцаа эзэмшлийн төвлөрөл нэмэгдэж, шинээр хувьчлагдсан үйлдвэр аж ахуйн газрууд цомхотгол хийн ажлын байрны тоог цөөрүүлж байгаа нь харагдлаа. Харин судалгаагаар цалин хөлсний хуваарьт тэгш бус байдал нэмэгдэж байж болзошгүй гэсэн таамгийг баталж чадахуйц тоо мэдээ гарсангүй. Мөн үйлдвэр, аж ахуйн газрууд хувьчлагдсанаасаа хойш ч ажиллагсдадаа янз бүрийн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлсээр байлаа. Гэвч эдгээр нь ширүүн өрсөлдөөнт орчинд хэвээр хадгалагдах боломжгүй билээ.

Зөвлөмж

Энэ тайлангийн зарим дүгнэлтүүдийг зөвлөмж болгон ашиглаж болох бөгөөд тайлангийн зөвлөмжүүдийг дор толилуулж байна.

1. Үүнээс хойш аливаа хувьчлалыг хийхдээ эн тэргүүнд ил тод байдалд ихээхэн ач холбогдол өгөх хэрэгтэй. Тухайлбал, өмч хувьчлалын талаарх мэдээллийг нийтэд хүртээмжтэй тархаан, түүний үр дүнгийн талаарх ойлголтыг бий болгох чухал юм.
2. Хувьчлагдах эд хөрөнгийн үнэлгээг үнэн зөв тогтоох асуудалд гол хүчин чармайлт гаргах ёстой. Эдийн засгийн аливаа үйл ажиллагаа явуулдаггүй эд хөрөнгөөс байгууллагууд ёс бус ашиг олох ёсгүй.
3. Хувьчлагдах эд хөрөнгийн зөв үнэ тогтоох хамгийн зохимжтой арга бол нээлттэй, өрсөлдөөнт тендэр явуулах явдал байна.
4. Өмч хувьчлалын эхний шатанд өмч хувьчлалын талаар шийдвэр гаргахад шаардлагатай жинхэнэ өрсөлдөөнт орчин бий болгох хууль эрх зүйн болон зохицуулах хүрээ зайлшгүй хэрэгтэй.
5. Хоршооллын бүтцийн үүрэг роль, харилцан хамаарлын асуудал болон хувьчлалын улмаас бий болсон зах зээлийн уналт зэрэгт илүү анхаарах хэрэгтэй.
6. Хувьчлалын дараах төр засгийн үүрэг хариуцлагад илүү нарийн хандах ёстой.

7. Үүнээс хойш аливаа хувьчлалыг явуулахдаа нийгмийн хамгааллын сүлжээ, нийгмийн хамгааллын бусад тогтолцооны хангамжтай холбоотой хувьчлалын үр дагаврыг харгалзан үзэх хэрэгтэй.

8. Өмч хувьчлалыг дагалдан гарах санхүүгийн нөлөө, үр дагаврыг илүү ил тодорхой болгож, зах зээлд суурилсан эдийн засгийн нөхцөлд энэ талаарх төр засгийн үүрэг хариуцлагыг эрчимжүүлэх ёстой.

НОМ ЗҮЙ

Алексеев, Майкл (1999) “Орос улсад хувьчлалын хөрөнгийн хувиарлалтанд үзүүлсэн үр нөлөө”, *Шилжилтийн үеийн эдийн засаг*, Боть 7(2), 449-465 хуудас

Азийн хөгжлийн банк (2003), *Монгол Улс: Эдийн засгийн байдал*, Манилла хот

Баржа, Говер ба Мигуэл Уркивиола (2001), “Капитализмжалт, зохицуулалт ба ядуучууд: Болив дахь нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж”, Нэгдсэн үндэстний их сургууль, ВИДЕР Хэлэлцүүлгийн материал № 2001/34

Барнэтт, Стивэн (2000), “Хувьчлалын санхүү болон макроэдийн засгийн үр нөлөөний талаарх баримтууд” *ОУВС-ийн Ажлын хэрэгцээнд зориулсан материал*, ВП/00/130, ОУВС-ийн Санхүүгийн асуудал эрхэлдэг газар, Вашингтон

К.Майлисс (2002), “Хувьчлал ба ядуурал: нийтийн аж ахуйн үйлчилгээний хувьчлалын орлогын хувиарлалтанд үзүүлсэн нөлөө”, СРС Ажлын хэрэгцээнд зориулсан цуврал материал 16, ИДПМ, Манчестэр

Н.Бэрдсал ба Ж.Нэллис (2002), “Ашиг ологчид ба алдагчид: Хувьчлалын орлогын хувиарлалтад үзүүлсэн нөлөөг үнэлэх нь”, Ажлын хэрэгцээнд зориулсан материал №6, 5 сар, Дэлхийн хөгжлийн төв

Ц.Болормаа, К.Кларк (2000), “Шилжилтийн үеийн Монгол Улсын Хөдөлмөрийн эдийн засаг”, Никсон (2000)

П.Боонэ, (1994), “Монгол дахь макроэдийн засгийн шинэчлэл ард түмэнд”, *Харьцуулсан эдийн засгийн сэтгүүл*, 18(3), 329-356 хуудас

Боос, Диетэр (1995), “Хувьчлалын орлогын тэгш байдалд үзүүлсэн үр нөлөөг Зүүн Германы жишээн дээр харуулах нь”, Рамандхан (1995), 49-67 хуудас

Чимэддагва, Жаргалсайхан, Б.Волтерс (2000), “Макроэдийн засгийн бодлого ба үзүүлэлтүүд”, Никсон (2000)

С.Коммандер (1999), “Дахин хувиарлалтын сувгууд: Оросын шилжилтийн эдийн засаг дахь тэгш бус байдал ба ядуурал”, *Шилжилтийн үеийн эдийн засаг*, Боть 7(2), 411-447 хуудас

Куук, Паул, Киркпатрик, Колин нар (1995), “Хөгжиж буй орнууд дахь хувьчлалын орлогын хувиарлалтанд үзүүлсэн үр нөлөө: Хэн юу яагаад олж авав”, Рамандхан (1995), 25-38 хуудас

Куук Паул, Киркпатрик Колин нар (1998), “Хөгжиж буй орнууд дахь хувьчлал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал”, *Хувьчлал, Үйлдвэрийн хөгжил ба Эдийн засгийн шинэчлэлт: Хөгжиж буй болон шилжилтийн эдийн засгийн орнуудын туршлага*, Чэлтэнхам, Эдвард Элгар

Дэ Люса, Лоретта (1998), *Хувьчлал, өөрчлөн байгуулалтын хөдөлмөр, нийгмийн хэмжээс* (Женев, ОУХБ)

Жанков, Симеон, Петр Муррэл (2000), *Шилжилтийн эдийн засгийн Үйлдвэрлэлийн шинэчлэлийн тодорхойлогч шинжүүд: Баримтын үнэлгээ* (Вашингтон, Дэлхийн банк)

А.Эстачэ, А.Гомез-Лобо, Д.Лейпзигэр (2001), “Нийтийн аж ахуйн үйлчилгээний хувьчлал ба ядуучууд: Латин Америкийн туршлага, баримтууд”, *Дэлхийн хөгжил*, Боть 29, №7, 1179-1198 хуудас

А.Эстачэ, М.Гонзалес, Л.Трюжилло (2002), “Хувьчлал үр ашгийг сайжруулахад нөлөөлсөн үү? Аргентин, Бразилийн төмөр замын баримтууд”, *Дэлхийн хөгжил*, Боть 30, №11, 1885-1897 хуудас

Олон Улсын Файдэ, (1999) 1998 оны Монголын амьжиргааны түвшний түүвэр судалгааны тойм, ҮСГ, НҮБХХ-ийн хэвлэгдээгүй тайлан, Олон Улсын хөгжлийн эдийн засгийн чуулга уулзалт, Вашингтон

Феррэйр, Франциско, (1999), “Эдийн засгийн шилжилт ба орлого, хөрөнгийн хувиарлалт”, *Шилжилтийн үеийн эдийн засаг*, Боть 7, №2

К.Гриффин (1994), *Монгол Улс дахь ядуурал ба зах зээлийн эдийн засагт шилжих шилжилт*, НҮБХХ, Улаанбаатар, 6 сар

К.Гриффин (2001), *Монгол Улсын ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг*, НҮБХХ, Улаанбаатар, 7 сар

Монгол Улсын Засгийн газар ба НҮБХХ, (2001), Үндэсний семинар: Ядуурлыг бууруулах асуудлыг хөгжлийн стратегид уялдуулах нь, Боть 1, Улаанбаатар, 9 сар

Монгол Улсын Засгийн газар (2001), *Ядуурлыг бууруулах завсрын баримт бичиг*, 6 сар, Улаанбаатар

Монгол Улсын Засгийн газар, Үндэсний статистикийн газар, Дэлхийн банк, (2001), *Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа*, Улаанбаатар

Монгол Улсын Засгийн газар Төрийн өмчийн хороо, (2001), *2001-2004 онд хийгдэх хувьчлалын удирдамж*, 8 сар, Улаанбаатар

Монгол Улсын Засгийн газар, Үндэсний статистикийн газар, НҮБХХ, (1999) “1998 оны Амьжиргааны түвшний түүвэр судалгаа”, МОН/97/201 төсөл, Улаанбаатар

Грийнидж, Б.Карл (1995), “Гвиней дахь хувьчлалын тэгш хувиарлалтад үзүүлсэн үр нөлөө” Раманадхан (1995), 241-269 хуудас

С.Гупта, Ц.Счиллэр, Х.Ма (1999), “Хувьчлал, Нийгмийн үр нөлөө, Нийгмийн хамгааллын сүлжээ” *ОУВС-ийн Ажлын хэрэгцээнд зориулсан материал*, ВП/99/68, Санхүүгийн асуудал эрхэлсэн газар, ОУВС, Вашингтон

Олон Улсын валютын сан (1996), *ОУВС Эдийн засгийн тойм: Монгол Улс*, Олон Улсын валютын сан, Вашингтон

ОУВС (2001) *Монгол Улс: Ядуурлыг бууруулах завсрын баримт бичгийн үнэлгээ*, 9 сар, ОУВС, Вашингтон

ОУВС (2002) *Монгол Улс: Сонгосон асуултууд ба статистик хавсралтууд*, ОУВС-ийн Орны илтгэл, № 02/253, Ази, Номхон далайн асуудал эрхэлсэн газар, ОУВС, Вашингтон

Ивасченко, Оликсия (2002), “Өсөлт ба тэгш бус байдал: Шилжилтийн эдийн засгийн орнуудын баримтууд”, нийтлэгдээгүй материал, Готенбургийн их сургууль, Швед

Келегама, Самен, (1995), “Хувьчлалын орлогын тэгш байдалд үзүүлсэн нөлөө: Шри Ланкийн жишээ”, Раманадхан (1995), 143-180 хуудас

Киркпатрик, Колин (2002), “Хувьчлал, Киркпатрик, Колин, Кларк, Рон, Полидано Чарлес нар” (2002), *Бодлого боловсруулах болон удирдлагын талаарх гарын авлага*, Чэлтэнхам, Эдвард Элгар, 121-132 хуудас

С.Лоол (1991), “Хөгжиж буй орнууд дахь аж үйлдвэрийн салбарын ололт амжилтын учир”, В.Н.Баласубраманям, С.Лоол, (1991), *Хөгжлийн эдийн засгийн тулгамдсан асуудлууд*, Басингстоук, Макмиллан, 118-155 хуудас

Лавигнэ, Марие (1995), *Шилжилтийн үеийн эдийн засаг: Социализмаас зах зээлийн эдийн засагт*, Басингстоук, Макмиллан

Маседо,Роберто (2000), “Бразил дахь хувьчлал ба хөрөнгийн хувиарлалт”, Вашингтон, Америк хоорондын хөгжлийн банк, судалгааны газар, 3 сар

МкХайл, Жон ба Александр Панков, (1999), “Коммунизмын дараах хувьчлал ба хөрөнгийн хувиарлалт: Бид юу мэдэх вэ?” нийтлэгдээгүй төсөл, Дэлхийн банк, Вашингтон

Микхалев, Владимир (2000), “Шилжилтийн эдийн засгийн орнууд дахь нийгмийн бүтцийн тэгш бус байдал ба өөрчлөлт” *Шилжилтийн үеийн эдийн засаг*, Боть 7(2), 299-341 хуудас

Д.Миллер, (онгүй), “Бэлчээрийн эрсдлийн удирдлагын стратеги ба Үйл ажиллагааны төлөвлөгөө”, Монгол Улс: Тогтвортой амьжиргааны төсөл, Дэлхийн банк, Улаанбаатар

Нэллис, Жон (1999), “Шилжилтийн эдийн засгийн орнууд дахь хувьчлалын талаар дахин бодох цаг боллоо”, Вашингтон, Олон Улсын санхүүгийн хамтын ажиллагааны талаар хэлэлцэх баримт №38

Нэллис, Жон (2000), “Шилжилтийн эдийн засгийн орнууд дахь хувьчлал: Юу тохиолдов? Юу хүлээж байна? , 11 сар

Никсон, Фрэдрик, Бат, Сувд, Лувсандорж, Пунцагдаш, Волтерс, Бэрнард (2000), *Монголын эдийн засаг: Шилжилтийн эдийн засгийн орны хэрэглээний эдийн засгийн гарын авлага*, Чэлтэнхам, Эдвард Элгар

Парэдэс, Рикардо (2001), “Чили улс дахь хувьчлалын дахин хувиарлалтын үр нөлөө, Нийтийн аж ахуйн үйлчилгээний журам”, Нэгдсэн үндэстний их сургууль, ВИДЕР Хэлэлцүүлгийн материал № 2001/10

Раманадхам, В.В. (1995), *Хувьчлал ба тэгш байдал*, Нью-Йорк, Роутлэдж

Рассэл, Н.П, Б.Бат (2000) “Монголын эдийн засгийн шилжилтийн байгаль орчинд үзүүлсэн нөлөө”, Никсон, (2000)

Б.Робинсон, А.Солонго, (2000), “Монгол Улс дахь эдийн засгийн шилжилтийн жөндөрийн байдал”, Никсон (2000)

Стиглиц, Жозэф (2002), *Даяарчлал ба түүний үр дагавар*, Лондон, Аллэн Лэйн

П.С. Стаббс, Д.Дагвадорж, Л.Мягмаржав, (2000), “Хувьчлал, Үйлдвэр аж ахуйн газар ба хувийн секторын хөгжил”, Никсон (2000).

Триска, Дуан (1992), “1992 оны Чехословак дахь Эрхийн бичгийн хувьчлал”, Адрежа Бохм, Марко Симонети (1992), *Төв ба Зүүн Европ дахь хувьчлал, 1992*, Лжубжлана, Төв ба зүүн Европын хувьчлалын сүлжээ

Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр, (1997) Монголын хүний хөгжлийн илтгэл, НҮБХХ, Улаанбаатар

Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр, (2000) Монголын хүний хөгжлийн илтгэл, НҮБХХ, Улаанбаатар

АНУ-ын Хөгжлийн агентлаг (1999) *Монголд хувьчлалын дараах бизнесийг дэмжих төслийн боломжийн талаарх судалгаа*, Барентс групп ЛЛС

АНУ-ын Хөгжлийн агентлаг (1999) *Нийгэм, эдийн засгийн талаарх судалгааны тайлан: Хувьчлал*, Улаанбаатар, 2000

Дэлхийн банк (1996), *Монгол Улс: Шилжилтийн эдийн засгийн орны ядуурлын үнэлгээ*, Тайлан № 15723-МОГ, Дэлхийн банк, Вашингтон

Дэлхийн банк (1997), *Монгол Улс: эдийн засгийн санамж бичиг: Өсөлтийг хурдасгах бодлогууд*, Тайлан № 16749-МОГ, Дэлхийн банк, Вашингтон

Дэлхийн банк (2000), *Шилжилтийг хүн бүрт ашигтайгаар хийх нь: Европ, Төв Ази дахь ядуурал ба тэгш бус байдал*, Вашингтон